



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН
2021-2022 оны судалгааны үр дүн

Улаанбаатар хот
2023 он

СУДАЛГААНЫ ТАЙЛАН ХЯНАСАН

Үндэсний статистикийн хорооны Арга зүйн байнгын зөвлөлийн гишүүд

Салбар дундын техникийн ажлын хэсгийн гишүүд

СУДАЛГААНЫ ТАЙЛАН БИЧСЭН

О.Норовсамбуу	ҮСХ-ны Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын Судалгаа, шинжилгээ, түүврийн хэлтсийн дарга
Э.Гантуяа	ҮСХ-ны Нийгмийн статистикийн газрын Өрхөд суурилсан судалгааны хэлтсийн ахлах статистикч

Энэхүү судалгааг Олон улсын хөдөлмөрийн байгууллага болон АНУ-ын Хөдөлмөрийн яамны санхүүжилтийн хүрээнд IL-30147-16-75-K-11 (МАР-16 төсөл) дугаартай хамтын ажиллагааны гэрээний дагуу зохион байгуулав.

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

- 📍 Монгол Улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу
Засгийн газрын III байр
- ☎ 976-11-326414
- 🌐 www.nso.mn, www.1212.mn
- ✉ information@nso.mn

АГУУЛГА

АГУУЛГА	3
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	6
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	8
БҮЛЭГ I. ЕРӨНХИЙ ТОЙМ	11
БҮЛЭГ II. ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	15
2.1. Эрх зүйн баримт бичиг	15
2.2. Статистикийн ойлголт, тооцоолол	18
БҮЛЭГ III. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	21
3.1. Хүн ам	21
3.2. Эдийн засгийн өсөлт, бүтцийн өөрчлөлт	22
3.3. Тэгш бус байдал	23
3.4. Өрхийн амьжиргаа	24
3.5. Ядуурлын түвшин	25
3.6. Нийгмийн халамж	26
3.7. Хөдөлмөр	27
3.8. Хүний хөгжлийн индекс	28
БҮЛЭГ IV. ХҮҮХДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	31
БҮЛЭГ V. ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	37
5.1. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн ажлын хэлбэр	40
5.1.1. Цалин хөлс, орлого олох зорилготой хөдөлмөр эрхэлж буй хүүхэд	42
5.1.2. Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлж буй хүүхэд	45
5.2. Ажлын цаг	47
5.3. Ажлын байрны нөхцөл	49
5.3. Аюултай ажил хийж буй хүүхэд	51
5.5. Хүүхдийн хөдөлмөрийн улирлын хэлбэлзэл	55
БҮЛЭГ VI. ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БУЙ ХҮҮХЭД, ТЭДНИЙ ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ, СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ	59
6.1. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн өрхийн нийгэм, эдийн засгийн байдал	59
6.2. Хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн сургуульд хамрагдалт	61
БҮЛЭГ VII. ХҮҮХДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГ ХАНДЛАГА, НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ШИНЖИЛГЭЭ	63
БҮЛЭГ VIII. ХҮҮХДИЙН ӨРХИЙН ЦАЛИН ХӨЛСГҮЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРИЙН АЖИЛ, ЧӨЛӨӨТ ЦАГ	67

8.1. Гэрийн ажлын оролцоо	67
8.2. Гэрийн ажилд оролцож буй хүүхдийн хөдөлмөр эрхлэлт	70
Хавсралт – 1 Статистик хүснэгт	71
1.1. Хүүхдийн хөдөлмөрийн стандарт алдаа ба итгэмжлэлт интервалууд	71
1.2. Статистик хүснэгтүүд	75
Хавсралт 2. Ойлголт, тодорхойлолт	81
Хавсралт 3. Судалгааны аргачлал	84
Хавсралт 4. Судалгааны асуулга	91

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2.1. Насны доод хязгаарыг тооцох шалгуур.....	18
Хүснэгт 3.1. Тэгш бус байдал	23
Хүснэгт 3.2. Ядуурлын шугам, төгрөгөөр.....	25
Хүснэгт 3.3. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид, төрлөөр, мянган хүн	26
Хүснэгт 3.4. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд, мянган хүн	27
Хүснэгт 3.5. Хүний хөгжлийн индекс	29
Хүснэгт 4.1. Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон 5-17 насны хүүхэд, насны бүлгээр, хүйс, байршил, бүсээр.....	32
Хүснэгт 4.2. 6-14 насны хүүхдийн сургуульд хамрагдалт болон эдийн засгийн үйл ажиллагаа, хүйс, байршлаар	35
Хүснэгт 5.1. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, насны бүлгээр, хүйс, байршил, бүсээр.....	38
Хүснэгт 5.2. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, ажлын хэлбэрээр, насны бүлэг, хүйс, байршлаар.....	41
Хүснэгт 5.3. Цалин хөлс, орлого олох зорилготой хөдөлмөр эрхэлсэн хүүхэд, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, насны бүлэг, хүйс, байршил, бүсээр	42
Хүснэгт 5.4. Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлж буй хүүхэд, үйл ажиллагааны төрлөөр, хүйс, байршлаар, дүнд эзлэх хувиар.....	45
Хүснэгт 5.5. Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлж буй хүүхдийн долоо хоногт зарцуулсан дундаж цаг, үйл ажиллагааны төрлөөр, хүйс, байршил, насны бүлгээр	46
Хүснэгт 5.6. Хүүхдийн хөдөлмөрт зарцуулсан цаг, насны бүлэг, ажлын хэлбэрээр, хүйс, байршлаар	48
Хүснэгт 5.7. Хүүхдийн хөдөлмөрт зарцуулсан цаг, сургуульд хамрагдалтын байдлаар	49
Хүснэгт 5.8. Аюултай ажил эрхэлж байгаа хүүхэд, хүйс, насны бүлэг, байршил, бүсээр	51
Хүснэгт 5.9. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, улирлаар, хүйс, насны бүлэг, байршлаар	55
Хүснэгт 6.1. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, өрхийн тэргүүлэгчийн хүйс, ам бүлийн тоогоор	59
Хүснэгт 7.1. Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа, судалгаа явуулсан оноор	63
Хүснэгт 7.2. Ложистик регрессийн шинжилгээнд ашигласан хувьсагч, түүний тайлбар	64
Хүснэгт 7.3. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлсөн хүчин зүйлсийн стэпвайс ложистик регрессийн шинжилгээний маржинал эффект	65
Хүснэгт 7.4. Хүүхдийн аюултай хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлсөн хүчин зүйлсийн стэпвайс ложистик регрессийн шинжилгээний маржинал эффект	65
Хүснэгт 8.1. Гэрийн ажил эрхэлсэн, аюултай байж болзошгүй гэрийн ажил эрхэлсэн хүүхэд, хүйсээр, насны бүлэг, байршлаар.....	67
Хүснэгт 8.2. Гэрийн ажил хийсэн хүүхэд, хөдөлмөр эрхэлсэн байдал	70

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 2.1. Ажил, түүний хэлбэр.....	18
Зураг 2.2. Хүүхдийн ажил эрхлэлт, хэлбэрээр.....	19
Зураг 3.1. Монгол Улсын хүн амын тоо, жилийн дундаж өсөлтийн хувь, 2012-2022 он.....	21
Зураг 3.2. Хүн амын нас хүйсийн суварга	21
Зураг 3.3. Хүн ам зүйн ачаалал, хувиар	21
Зураг 3.4. Эдийн засгийн өсөлт, бууралт, хувиар.....	22
Зураг 3.5. Нэг хүнд ногдох ДНБ, ҮНӨ, ам. доллароор.....	22
Зураг 3.6. Хүн амын хэрэглээний бүтэц, тэнцүү 5 бүлгээр, дүнд эзлэх хувиар.....	23
Зураг 3.7. Өрхийн сарын дундаж нэрлэсэн болон бодит орлого, мянган төгрөгөөр	24
Зураг 3.8. Өрхийн сарын дундаж бодит орлогын өөрчлөлт, хувиар	24
Зураг 3.9. Өрхийн сарын дундаж бодит орлогын өсөлт, эдийн засгийн өсөлт, хувиар	24
Зураг 3.10. Ядуурлын хамралтын хүрээ, хувиар, ядуу хүн амын тоо, мянган хүнээр, улсын дунджаар	25
Зураг 3.11. Ядууралд өртөхөд ойрхон хүн амын хамралтын хүрээ, хувиар, ядууралд өртөхөд ойрхон хүн амын тоо, мянган хүнээр, улсын дунджаар	25
Зураг 3.12. Ядуурлын байдал, хот, хөдөөгөөр	26
Зураг 3.13. Хөдөлмөр эрхлэлтийн болон ажилгүйдлийн түвшин, хүйсээр, хувиар.....	27
Зураг 3.14. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, дүнд эзлэх хувиар	28
Зураг 3.15. Хөдөлмөрийн үзүүлэлт, аймгаар, 2022 он	28
Зураг 3.16. Хүний хөгжлийн индекс	29
Зураг 4.1. 5-17 насны хүүхдийн эдийн засгийн оролцоо	31
Зураг 4.2. Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн эзлэх хувь, насаар, хүйс, байршлаар	32
Зураг 4.3. Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн эзлэх хувь, хүйсээр, байршил, насны бүлгээр.....	33
Зураг 4.4. Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон 5-17 насны хүүхэд, насны бүлгээр, аймгаар.....	33
Зураг 4.5. 5-17 насны эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхэд, ажлын хэлбэрээр, хүйс, байршил, насны бүлгээр.....	34
Зураг 4.6. Хүүхдийн сургуульд хамрагдалт болон эдийн засгийн үйл ажиллагааны оролцоо, насны бүлгээр	34
Зураг 4.7. Хүүхдийн цэцэрлэг, сургуульд хамрагдалт болон эдийн засгийн үйл ажиллагаа, насаар	35
Зураг 5.1. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, насны бүлэг, хүйс, байршил, бүсээр	37
Зураг 5.2. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, ангиллаар.....	37
Зураг 5.3. Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд, нас, хүйсээр дүнд эзлэх хувиар	38
Зураг 5.4. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, нас, хүйсээр.....	39
Зураг 5.5. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, байршлаар	39
Зураг 5.6. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, аймаг, нийслэлээр	39
Зураг 5.7. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн үндсэн үйл ажиллагааны салбараар, дүнд эзлэх хувиар	40
Зураг 5.8. Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд	41
Зураг 5.9. Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, дүнд эзлэх хувиар	43
Зураг 5.10. Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд, ажил мэргэжлээр, дүнд эзлэх хувиар.....	43
Зураг 5.11. Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, хүйс, байршил, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар.....	44
Зураг 5.12. Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн сарын дундаж цалин, орлого, хүйс, байршил, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар.....	44
Зураг 5.13. Хүүхдийн цалин хөлс, орлого олох ажилд зарцуулсан цаг, салбараар, хүйс, байршил, насны бүлгээр	44
Зураг 5.14. Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн сургуульд хамрагдалт, дүнд эзлэх хувиар.....	45
Зураг 5.15. Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлж буй хүүхэд, үйл ажиллагааны төрлөөр, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар	46
Зураг 5.16. Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлж буй хүүхдийн сургуульд хамрагдалт, хүйс, байршил, насны бүлгээр	47
Зураг 5.17. Хүүхдийн хөдөлмөрт зарцуулсан цаг, ажлын хэлбэрээр, хүйс, байршлаар	47
Зураг 5.18. Хүүхдийн хөдөлмөрт зарцуулсан цаг, цагийн интервалиар, дүнд эзлэх хувиар	48
Зураг 5.19. Ажлын нөхцөл, тулгарсан хүндрэлээр	49
Зураг 5.20. Хөдөлмөр эрхлэх явцдаа алдаа гаргаж шийтгүүлсэн тохиолдол	50
Зураг 5.21. Хөдөлмөр эрхлэх явцдаа осол, гэмтэл авсан тохиолдол, төрлөөр	50

Зураг 5.22. Хөдөлмөр эрхлэх явцдаа өвдсөн тохиолдол, үүссэн өвчнөөр	50
Зураг 5.23. Аюултай хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хүйс, насны бүлэг, байршлаар	52
Зураг 5.24. Аюултай ажил эрхлэлтийн түвшин, аймаг, нийслэлээр	52
Зураг 5.25. Аюултай ажил эрхэлсэн хүүхэд, хэлбэрээр, дүнд эзлэх хувиар	52
Зураг 5.26. Хориглосон ажлын байранд ажиллаж байгаа хүүхэд, салбар, мэргэжлээр, хүйсээр	53
Зураг 5.27. Хориглосон ажлын байранд ажиллаж байгаа хүүхэд, салбар, мэргэжлээр, насны бүлэг, байршлаар, дүнд эзлэх хувиар	53
Зураг 5.28. Хэт их цагаар ажиллаж байгаа хүүхдийн хөдөлмөр эрхэлж буй хүүхдэд эзлэх хувь	54
Зураг 5.29. Хэт их цагаар ажиллаж байгаа хүүхдүүд, ажлын хэлбэрээр, дүнд эзлэх хувиар	54
Зураг 5.30. Хөдөлмөрийн аюултай нөхцөлд ажиллаж байгаа хүүхэд, ажлын нөхцөлөөр	54
Зураг 5.31. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, аюултай ажил эрхлэлтийн түвшин, улирлаар	55
Зураг 5.32. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хүйсээр, улирлаар	55
Зураг 5.33. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, байршлаар, улирлаар	56
Зураг 5.34. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, мянган хүүхдээр	56
Зураг 5.35. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, ажлын хэлбэрээр, улирлаар, мянган хүүхдээр	57
Зураг 5.36. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, ангиллаар, улирлаар, мянган хүүхдээр	57
Зураг 6.1. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, өрхийн тэргүүлэгч, ам бүлээр	59
Зураг 6.2. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшнээр, аав, ээжтэйгээ амьдардаг эсэхээр	60
Зураг 6.3. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, өрхийн сууц, усан хангамжийн төрлөөр	60
Зураг 6.4. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин	60
Зураг 6.5. Сургуульд хамрагдалтын хувь, хүйсээр, насаар	61
Зураг 6.6. Сургуульд хамрагдалтын хувь, эрхэлж буй ажлын хэлбэрээр, хүйс, байршлаар	61
Зураг 6.7. Өмнөх хичээлийн жилд суралцаагүй шалтгаан	62
Зураг 7.1. Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа, нийт хүүхдэд эзлэх хувиар, судалгаа явуулсан оноор	63
Зураг 7.2. Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, судалгаа явуулсан оноор	63
Зураг 8.1. Гэрийн ажил эрхэлсэн хүүхэд, нийт хүүхдэд эзлэх хувиар	67
Зураг 8.2. Гэрийн ажил эрхэлсэн хүүхэд, үйл ажиллагаагаар, хүйсээр, хувиар	68
Зураг 8.3. Хүүхдийн аюултай байж болзошгүй гэрийн ажил эрхлэлтийн түвшин, хүйс, нас, байршлаар	68
Зураг 8.4. Аюултай нөхцөлд гэрийн ажил эрхэлсэн хүүхэд, нийт гэрийн ажил эрхэлсэн хүүхдэд эзлэх хувиар, ажлын төрлөөр	69
Зураг 8.5. Гэрийн ажилд зарцуулсан дундаж цаг, үйл ажиллагаагаар	69
Зураг 8.6. Гэрийн ажил хийсэн хүүхэд, хөдөлмөр эрхэлсэн эсэхээр, дүнд эзлэх хувиар	70
Зураг 8.7. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт болон гэрийн ажил хийхэд зарцуулсан дундаж цаг	70

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АХС	Ажиллах хүчний судалгаа
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОУХСБХ	Олон улсын хөдөлмөрийн статистикчдын бага хурал
ӨНЭЗС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
ҮНО	Үндэсний нийт орлого
ҮНБ	Үндэсний нийт бүтээгдэхүүн
ҮТС	Үндэсний тооцооны систем
ХА	Хүн ам
ХАА	Хөдөө аж ахуй
ХЭК	Хүний эрхийн конвенц
ЯШ	Ядуурлын шугам



ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Аливаа эдийн засгийн үйл ажиллагаа нь хүүхдийн хөдөлмөр мөн эсэх нь хүүхдийн нас, ажлын цаг, нөхцөл, гүйцэтгэж буй ажлын төрлөөс хамаарна. Хэрвээ хүүхэд бага наснаасаа, урт цагаар эсвэл бие бялдар, сэтгэцийн эрүүл мэнд, хөгжил, боловсорч сурахад нь нөлөөлөхүйц ажил эрхэлдэг бол энэ нь хүүхдийн хөдөлмөр болно.




Монгол Улсад **138 мянга гаруй хүүхэд хөдөлмөр эрхэлж** байна.



Хөвгүүд охидтой харьцуулахад илүү хөдөлмөр эрхэлж байна.

Хөдөөд хүүхдийн хөдөлмөр их байна.





АЮУЛТАЙ АЖИЛ

Хүүхдийн аюултай ажил гэж хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуун, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх аюултай шинж чанар бүхий (аюултай орчин, тоног төхөөрөмж, салбар, ажил мэргэжил) аливаа ажил, үйл ажиллагаа юм.



Хөвгүүд охидыг бодвол аюултай ажилд илүү оролцож байна.


Аюултай ажил эрхэлж буй хүүхдийн ихэнх нь **хөдөө** амьдарч байна.



31.8%
Охид




68.2%
Хөвгүүд



Ажил эрхэлж буй хүүхдүүдийн ихэнх нь том мал, тэжээвэр амьтадтай харьцаж эсвэл өтөг, бууц, ялгадастай орчинд ажиллаж байсан тул аюултай ажил эрхлэлтэд тооцогдсон.

Аюултай ажил эрхэлж буй 10 хүүхэд тутмын 1 нь ажил, мэргэжлийн хувьд аюултайд тооцогдож, тэдгээрийн 2.0 мянга (40.8%) нь барилгын салбарт дотоод засал, чимэглэлийн ажил туслах, барилгын материал, багаж хэрэгсэл зөөх гэх мэт барилгын тулсан гүйцэтгэх үйл ажиллагаанд оролцжээ.



- Зөвхөн салбар, мэргэжлийн хувьд аюултай ажил
- Зөвхөн хэт их цагаар ажиллах (30 ба түүнээс дээш цаг)
- Зөвхөн хөдөлмөрийн аюултай нөхцөл
- Бусад/холимог

БҮЛЭГ I. ЕРӨНХИЙ ТОЙМ

1.1. Судалгааны талаар

Удиртгал

- Үндэсний статистикийн хороо Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэй холбоотой мэдээллийг бий болгох, үзүүлэлтийг өргөжүүлэх, мэдээллийн давтамжийг нэмэгдүүлэх, боловсронгуй болгох зорилгоор Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа /ХХС/-г 2002-2003, 2006-2007, 2011-2012 онуудад “Ажиллах хүчний судалгаа”-нд нэмэлт модуль хэлбэрээр оруулж, олон улсын аргачлалын дагуу зохион байгуулж, үр дүнг тархааж байв.
- Дээрх судалгаануудын үр дүнгээр хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг тэр дундаа аюултай ажил, хөдөлмөр эрхлэлтийг устгахад чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, статистикийн суурь мэдээллийг бий болгосон ба цаашид судалгааны мэдээллийг баяжуулах, давтамжийг тогтмолжуулах, хүүхдийн ажил, хөдөлмөрийн статистикийг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдсаар ирсэн.
- Энэ хүрээнд Үндэсний статистикийн хороо Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагатай хамтран “Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа”-г шинэ аргачлалын дагуу, анх удаа бие даасан түүвэр судалгаа хэлбэрээр 2021-2022 онд зохион байгууллаа.

Судалгааны зорилго

- Хүүхдийн ажил, хөдөлмөр эрхлэлтийн хэмжээ, бүтэц, тэдгээрт гарч буй өөрчлөлтийг тодорхойлж, дүн шинжилгээ хийхэд ашиглагдах тоон мэдээллийн багцыг бий болгоход оршино.
- Энэ зорилгын хүрээнд хүүхдийн амьдарч буй өрх, гэр бүлийг тодорхойлох, тэдний орон сууцны нөхцөл байдал, нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн онцлог шинж байдал, хүүхдийн боловсролын түвшин, тэдний ажил, хөдөлмөр эрхлэлт тэр тундаа аюултай ажил, хуулиар хориглосон хүүхдийн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийг тооцох, хүүхдийн ажил, хөдөлмөр эрхлэх болсон шалтгаан, үр дагаврыг үнэлэх зорилт тавьж судалгааг зохион байгуулсан.

Тайлангийн гол агуулга

- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал нь тайлангийн гол сэдэв бөгөөд энэ нь хуулиар хориглосон, устгах ёстой хөдөлмөр эрхлэлтийн хүрээний ойлголт юм. ОУХБ-ын ойлголт, аргачлалын дагуу хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэд хуулиар зөвшөөрөгдсөн 15-17 насны хүүхдийн аюултай биш хөдөлмөр эрхлэлт болон 13-14 насны аюултайд тооцогдоогүй, хөнгөн ажлыг харуулдаггүй.

Аргачлал

- Монгол Улсын хөдөлмөрийн статистикт болон энэхүү судалгаанд Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А-09/08 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал"-ыг мөрдөнө. Энэхүү аргачлалыг 2013, 2018 онуудад болсон Олон улсын хөдөлмөрийн статистикчдын 19, 20-р бага хурлуудын тогтоолын дагуу боловсруулсан.
- Энэ удаагийн Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа нь өмнөх онуудын судалгаануудаас өөр, шинэ аргачлал, ойлголт, тодорхойлолт ашигласан тул мэдээллийн харьцуулахуйц байх чанар алдагдаж, хүүхдийн хөдөлмөртэй тэмцэхэд чиглэсэн үйл ажиллагааны үр нөлөөнд дүгнэлт өгөх боломжгүй юм. Иймээс чиг хандлагыг зөвхөн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох хандлагыг тусгасан болно.

1.2. Үндсэн үр дүн

5-17 насны Хүүхэд

- Тайланд хүүхдийн сургуульд хамрагдалтыг Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 "Монгол Улсын иргэн суурь боловсрол заавал эзэмших үүрэгтэй" гэж заасны дагуу 6-14 насны хүүхдээр тооцсон.
- Хүүхдийн хөдөлмөрийн судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо нь 2022 онд 852.4 мянга байгаа нь хүн амын мэдээтэй харьцуулахад 96.2 хувийн хамралттай байна. Мөн хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшнээр тооцсон түүрийн алдаа нь 3.7 хувь байгаа нь судалгааны үр дүнгийн төлөөлөх чадвар өндөр байгааг илэрхийлж байна.
- Судалгаагаар 6-14 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын түвшин 96.6 хувь байна. Насаар авч үзэхэд 6 болон 7 настай хүүхдийн сургуульд хамрагдалт бага байгаа нь сүүлийн жилүүдэд үүссэн цар тахлын улмаас эцэг, эхчүүд хүүхдээ сургуульд элсүүлэх нь буурсантай холбоотой байна. Үүнийг Боловсрол, шинэлэх ухааны яамны мэдээллээрх нэгдүгээр ангид элсэгчдийн цэвэр жинтэй уялдуулж харахад, 2020 онд 97.0 хувь, 2021 онд 94.7 хувь, 2022 онд 91.6 хувь бол буурсан байна. Энэ нь сүүлийн жилүүдэд үүссэн цар тахлын улмаас эцэг, эхчүүд хүүхдээ сургуульд хамруулах, цахимаар сургах нь буурсантай холбоотой.

Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа дахь оролцоо

- Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа нь хүүхдийн хөдөлмөр болон хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөр эрхлэх насны хүүхдийн эрхэлж байгаа хөнгөн хэлбэрийн ажлыг багтаасан өргөн хүрээний ойлголт юм. Өөрөөр хэлбэл ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээний ажлыг эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох гэж үзсэн. Хүүхдийн өөрийн өрхийн эцсийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэж буй гэрийн ажлыг ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээний дагуу эдийн засгийн үйл ажиллагаанд хамааруулсан. Харин судалгаагаар сайн дурын ажлын хэлбэрийн мэдээллийг цуглуулаагүй.
- Судалгаагаар улсын хэмжээнд нийт 5-17 насны хүүхдийн 208.0 мянга буюу 24.4 хувь нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон байна.
- Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон 5-17 насны хүүхдийн 60.7 хувь нь хөвгүүд, 39.3 хувь нь охид байна.
- Насны бүлгийн хувьд хүүхдийн нас нэмэгдэх тусам тэдний эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох оролцоо нэмэгдэж байна. Харин байршлын хувьд адил буюу ялгаа ажиглагдахгүй байна.
- Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон арван хүүхэд тутмын долоо нь зөвхөн өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажилд оролцсон байна.

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт

- Хүүхдийн хөдөлмөрийн тодорхойлохдоо насны онцлогийг авч үздэг. Тухайлбал, хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг (а) хөнгөн ажил хийж болохуйц наснаас доош буюу 5-12 настай эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хүүхэд, б) аюултай ажил эрхэлж байгаа хүүхэд, в) аюултайд тооцогдоогүй ч хөнгөн биш ажил эрхэлж байгаа 13-14 насны хүүхдээр тодорхойлсон.
- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг нийт 5-17 насны хүүхдэд тухайн насны хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн эзлэх хувийн жингээр илэрхийлсэн.
- Судалгаагаар улсын хэмжээнд хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 16.3 хувь буюу 5-17 насны 138.5 мянган хүүхэд хөдөлмөр эрхэлсэн байна.

- Хүйсийн хувьд хөвгүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 19.9 хувь, охидынх 12.5 хувь байна. Насны бүлгээр авч үзэхэд, 5-12 насанд 16.8 хувь, 13-14 насанд 12.7 хувь, 15-17 насанд 17.0 хувь байна. Харин байршлын хувьд хот суурин газарт амьдардаг 5-17 насны хүүхдийн 10.2 хувь нь хөдөлмөр эрхэлсэн бол хөдөөд энэ үзүүлэлт 30.0 хувьтай байна.
- Хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн 78.2 мянга (56.5%) нь хөнгөн ажлыг хийж болохуйц наснаас доош буюу 5-12 нас (а)-ны, 58.2 мянга (42.0%) нь аюултай ажил эрхэлсэн (б), 2.1 мянга (1.5%) нь аюулгүй ч хөнгөж бус хөдөлмөр эрхэлж байгаа 13-14 насны хүүхэд (г)-үүд байна.
- Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн 133.2 мянга (96.2%) нь өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлсэн, мөн 11.6 мянга (8.4%) нь цалин хөлс, орлого олох зорилготой ажил эрхэлсэн, 212 (0.2%) нь цалин хөлсгүй дадлагажих ажил эрхэлсэн байна.
- ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээнд “өрхийн хэрэглээнд зориулж байгалийн болон нийтийн эх үүсвэрээс ус зөөх, түлээ бэлтгэх үйл ажиллагаа” нь хүүхдийн хөдөлмөрт тооцогдох бөгөөд хөдөлмөр эрхэлсэн 5-17 насны арван хүүхэд тутмын тав нь уг үйл ажиллагаанд, мөн гурав нь мал аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд, нэг нь газар тариалан эрхлэх үйл ажиллагаанд оролцсон байна. Манай орны эдийн засагт мал аж ахуй чухал үүрэг гүйцэтгэдэг учраас малчин өрхийн хүүхдүүд багаасаа мал аж ахуйн ажилд идэвхтэй оролцож гэр бүлдээ тусалж байдаг нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн тоо өндөр гарахад нөлөөлдөг.
- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн бүх ажлын хэлбэрүүдэд зарцуулсан нийт цагийн хувьд долоо хоногт дунджаар 8 цаг, хөвгүүд 9 цаг, охид 7 цаг зарцуулсан бол хот, суурин газрын хүүхдүүд 6 цаг, хөдөө амьдарч буй хүүхдүүд 10 цаг зарцуулсан байна. Харин зөвхөн цалин хөлс, орлого олох ажилд долоо хоногт дунджаар 19 цаг, өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажилд 6 цаг, цалин хөлсгүй дадлагажих ажилд 22 цаг зарцуулсан байна.
- Хөдөлмөр эрхэлсэн 6-14 насны хүүхдийн сургуульд хамрагдалт 96.7 хувь байна.
- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин улирлаар хэлбэлзэж байна. Өөрөөр хэлбэл 1-ээс 3-р улиралд аажмаар өсөж 18.6 хувьд хүрч өсөж (хамгийн өндөр), 4 дүгээр улирал буурч 10.6 хувь (хамгийн бага)-д хүрсэн байна. Манай орны цаг уурын эрс тэс уур амьсгалтай бөгөөд 4 дүгээр улиралд ил задгай газар эсвэл гадаа ажиллахад тохиромжгүй хамгийн хүйтэн, хатуу ширүүн уур амьсгалтай улирал байдаг учраас хүүхдийн хөдөлмөр эрхлэх боломж бага байж болох талтай юм. Харин 3 дугаар улиралд хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоо хамгийн их байгаа нь эдийн засгийн ямар нэгэн үйл ажиллагаа эрхлэх хамгийн боломжтой дулаан уур амьсгалтай улиралд намар, өвлийн улиралд бэлтгэх олон төрлийн ажил хийгддэг, мөн бүх шатны сургалтын байгууллагын амралт эхэлдэгтэй холбоотой.

Аюултай ажил эрхлэлт

- Аюултай ажлыг хүүхдийн эрхэлж байгаа ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажлын үйл ажиллагаагаар тодорхойлсон. Үүнд (а) ууулиар хориглосон буюу “Насанд хүрсэн хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байр”-нд ажиллах, (б) хөдөлмөрийн ажлын нөхцөлд буюу хүүхдийн аюулгүй байдалд хор нөлөө үзүүлэх нөхцөлд ажиллах, (в) хэт их цагаар буюу ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээний ажлын үйл ажиллагаануудад нийт ажилласан цаг нь хуулиар тогтоосон дээд хэмжээ (7 хоногт 30 цаг)-нээс их цагаар ажиллахыг ойлгоно.
- Аюултай ажил эрхлэлтийн түвшнийг нийт 5-17 насны хүүхдэд тухайн насны аюултай ажил эрхэлж байгаа хүүхдийн эзлэх хувийн жингээр илэрхийлсэн.
- Судалгаагаар 5-17 насны нийт хүүхдийн 58.2 мянга нь аюултай ажил эрхэлж, хүүхдийн аюултай ажил эрхлэлтийн түвшин 6.8 хувь байна.
- Аюултай ажил эрхэлж буй 58.2 мянган хүүхдийн 68.2 хувь нь хөвгүүд, байршлын хувьд 68.5 хувь нь хөдөө амьдардаг хүүхдүүд байгаа нь хүйс, байршлын хувьд ихээхэн ялгаа байгаа нь харуулж байна.

- Судалгаагаар аюултай ажил хийж буй нийт хүүхдийн 4.8 мянга буюу 8.2 хувь нь “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-нд буй ажил мэргэжлийн ажлыг хийж байна. Насан хүрээгүй хүүхдийг ажиллуулахыг хориглосон ажил хийж буй таван хүүхэд тутмын хоёр нь барилгын салбарт дотоод засал, чимэглэлийн ажил, барилгын материал, багаж хэрэгсэл зөөх гэх мэт барилгын ажилд туслан гүйцэтгэх ажлыг хийж байна.
- Хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн 4.7 мянга буюу 3.4 хувь нь долоо хоногт 30-аас их цагаар буу хэт их цагаар ажилласан байна.
- Ажлын байрны нөхцөлийн хувьд хамгийн нийтлэг аюул нь хэт өндөр температур эсвэл чийгшил, тоос шороотой нөхцөл (27.5%) байна. Хүйсийн хувьд хөвгүүд, байршлын хувьд хөдөөд илүү ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлд илүү өртсөн байна.

Хүүхдийн хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн өрхийн нийгэм, эдийн засгийн байдал

- Судалгаагаар эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрхөд амьдардаг хүүхдүүдийн 14.1 хувь нь, эрэгтэй өрхийн тэргүүнтэй өрхөд амьдардаг хүүхдүүдийн 16.8 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. Харин ам бүлийн хувьд хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг авч үзэхэд 7-8 ам бүлтэй өрхөд амьдардаг хүүхдүүдийн 21.4 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.
- Өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин буурах тусам хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин өссөн байна.
- Өрхийн усан хангамжийн хувьд төвлөрсөн усан хангамжтай өрхийн хүүхдүүд хамгийн бага хөдөлмөр эрхэлсэн байгаа бол бусад төрөлд 17.0-49.4 хувь нь хөдөлмөр эрхэлсэн байна. Мөн өрхийн сууцны төрлөөр, орон сууцны байшинд эсвэл бие даасан тохилог сууцад амьдардаг өрхийн хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэлт 1.3-2.0 хувь байгаа бол бусад сууцны төрөлд 11.7-29.9 хувь байна.
- Өрхийн сарын дундаж орлогын хувьд, сард 1400.0 мянган төгрөгөөс дээш орлоготой өрхийн хүүхдүүдийн 9.1 хувь, 800.1-1400.0 мянга болон 140.0 мянга хүртэлх төгрөгийн орлоготой өрхийн хүүхдүүдийн 16.2-17.7 хувь, 140.1-600.0 мянган төгрөгийн орлоготой өрхийн хүүхдүүдийн 25.1-28.0 хувь нь хөдөлмөр эрхэлсэн байна.
- Хөдөлмөр эрхлэлтийн түвшний хувьд, байгалийн хүчин зүйлээс үүдэн хямрал үүссэн өрхийн хүүхдүүдийн 23.4 хувь нь хөдөлмөр эрхэлсэн бол нийгэм, эдийн засгийн хүчин зүйлээс үүдэн хямрал үүссэн өрхийн хүүхдүүдийн 21.0 хувь, өрхийн хэн нэг гишүүн нь өвдсөн өрхийн хүүхдүүдийн 12.1 хувь нь хөдөлмөр эрхэлсэн байна.

БҮЛЭГ II. ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Эрх зүйн баримт бичиг

Энэ бүлэгт хүүхдийн хөдөлмөрийн талаарх хууль эрх зүй, статистикийн ойлголтуудыг олон улсын болон үндэсний түвшинд тусгасан болно. Мөн энэхүү судалгаагаар хүүхдийн хөдөлмөрийг хэрхэн тооцоолсон талаар тайлбарласан.

Хүүхэд хөдөлмөр эрхлэх нь түүний суурь эрхийн зөрчилд тооцогдох бөгөөд хүүхдийн өсөлт хөгжилд сөргөөр нөлөөлж, цаашлаад насан туршид нь бие, сэтгэл зүйн хохирол үүсэж болзошгүй юм. Өөрөөр хэлбэл, хүүхдийн хөдөлмөр гэж хуулиар тогтоосон хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарт хүрээгүй хүүхдийн хийж буй ажил, мөн гүйцэтгэж буй ажил нь хүүхдэд бие махбодын болоод сэтгэл зүйн гэмтэл учруулж хүүхдийн эрүүл мэнд, аж байдалд нь нөлөөлөх ажлыг хэлнэ.

НҮБ-ын Ерөнхий Ассамбелаас албадан хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөрийг устгах хүчин чармайлтыг уриалж, 2021 оныг Хүүхдийн хөдөлмөрийг устгах жил болгон зарлаж байсан. Хүүхдийн хөдөлмөрийн тухай ОУХБ-ын эрх зүйн баримт нь дэлхий дахинаа хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх суурь баримт болдог. Тухайлбал,

1. Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц (1989 он, ХЭК)

Хүүхдийн эрхийн тухай конвенц нь хүүхдийн эдлэх эрхүүдийг тунхагласан олон улсын эрх зүйн баримт бичиг бөгөөд уг конвенцод 18 нас хүрээгүй хүн бүрийг "хүүхэд" гэж тодорхойлдог. Тус конвенцын тогтоосон олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу хүүхэд бүрийг ямар ч алагчлалгүйгээр хүүхэд хамгааллын тусламж, үйлчилгээ хүртэж, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж, бие хүн болж төлөвших, авьяас, чадвараа бүрэн дүүрэн нээн хөгжүүлэх боломжоор хангагдаж, аз жаргал, хайр энэрэл, ойлголцол бүрдсэн орчинд өсөн торниж, өөрсдийн эрхийн талаар мэдлэг, мэдээлэлтэй байж, эрхээ эдлэх үйл явцдаа идэвхтэй оролцох боломжоор хангагдах зэрэг нөхцөлийг бүрдүүлэх үүргийг конвенцын гишүүн орнууд хүлээсэн.

Монгол Улс 1990 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцод, 2003 онд Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Нэмэлт протоколд, 2004 онд Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Нэмэлт протоколд нэгдэн орсон. Түүнчлэн Хүүхэд хамгааллын тухай хуульд "Монгол Улсын иргэнийг төрсөн цагаас эхлэн 18 нас хүртэл, эсхүл Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд 18 наснаас дээш 21 нас хүртэл хүүхэд" гэж тооцон хамааруулахаар зохицуулж, Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11 дэх заалтад "хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална" гэж заажээ.

2. ОУХБ-ын Хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарын тухай конвенц (1973 он, №.138)

Энэ конвенцоор хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарыг 15 нас (хөнгөн ажил бол 13 нас), аюултай хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарыг 18 нас (зарим хатуу нөхцөлийн дор 16) гэж тогтоосон байдаг. Хэрвээ эдийн засаг, боловсролын тогтолцоо нь доогуур түвшинд байгаа бол хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарыг 14 (хөнгөн ажил бол 12) байж болохыг заажээ.

Монгол Улс нь 2002 онд "Насны доод хязгаарын тухай" 138 дугаар конвенцыг соёрхон баталсан бөгөөд Хөдөлмөрийн тухай хуулийн Аравдугаар бүлгээр хүүхдийн хөдөлмөрийн талаарх хууль эрх зүйн суурь зохицуулалтыг бий болгосон. Тухайлбал,

- 142 дугаар зүйлийн 142.1 дэх хэсэгт 15 насанд хүрээгүй хүнээр энэ хуулийн 142.3, 142.5¹-д зааснаас бусад тохиолдолд хөдөлмөр эрхлүүлэхийг хориглоно",
- 142 дугаар зүйлийн 142.3-т "Хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилд сөрөг нөлөө үзүүлэхгүй, сурч боловсроход саад учруулахгүй нөхцөлд 13-15 насны хүнийг хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх,

¹ 15 нас хүрээгүй хүнийг урлаг, спортын үзүүлбэр, зар сурталчилгаанд оролцуулахаар хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийн бичгээр гаргасан зөвшөөрөл, ажиллах цаг, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг үндэслэн хүүхдийн эрхийн улсын байцаагч тухай бүр зөвшөөрөл олгосон бол хөдөлмөр эрхлүүлж болно.

асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийн зөвшөөрөлтэйгөөр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд хөнгөн ажил эрхлүүлж болно”,

- 84 дүгээр зүйлийн 84.3 дахь хэсэгт “Насанд хүрээгүй хүний долоо хоногийн ажлын цаг 30-аас илүүгүй байна” гэж заасан.

3. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай конвенц (1999, №.182)

Энэхүү конвенцод нэгдэн орсон улсууд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг, тухайлбал, боолчлолын бүх хэлбэрүүд, боолчлолтой ижил төстэй үйл ажиллагаа, хүүхдийг худалдаалах, наймаалах, өрийн төлөөс болгох, хамжлага байдлаар ашиглах, хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд албадан, эсвэл заавал татан оролцуулах, хүүхдийн биеийг үнэлүүлэн бэлгийн мөлжлөгт өртүүлэх, садар самуунд ашиглах, хүүхдийг хууль бус үйл ажиллагаанд, ялангуяа мансууруулах бодис үйлдвэрлэх, худалдаалахад ашиглах, хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх үйл ажиллагааг устгахад чиглэсэн арга хэмжээг авна. Түүнчлэн, конвенцод нэгдэн орсон улс хүүхдийг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрөөс хөндийрүүлэх, өртсөн тохиолдолд нөхөн сэргээж, нийгмийн амьдралд дасаж, нийгмийн харилцаанд ороход нь тохиромжтой, шаардлагатай дэмжлэгийг шууд үзүүлэх үүрэгтэй.

Монгол Улс нь 2001 онд “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай” 182 дугаар конвенцыг соёрхон баталсан бөгөөд Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр 2011 онд батлагдсан. Мөн Эрүүгийн тухай хуульд хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэхийг гэмт хэрэгт тооцож, 16.10.1-д хүүхдээр аюултай ажил, эрүүл мэнд, бие бялдар, оюун санаанд нь хохирол учруулахуйц хориглосон ажил, үйлчилгээ зориуд эрхлүүлсэн бол хүлээлгэх хариуцлагыг зааж өгсөн.

2023 оны 6 сарын 1-ний өдрийн байдлаар дэлхийн 176 улс Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай 138 дугаар конвенцод, 187 улс Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай 182 дугаар конвенцод тус тус нэгдэн орсон байна. Монгол Улсын Хүүхдийн хөдөлмөрийн талаарх хууль эрх зүйн орчин, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны мэдээллийг Хавсралт 3-т тусгав.

4. Олон улсын хөдөлмөрийн статистикчдын бага хурлын тогтоол

Хөдөлмөрийн статистикийн олон улсын стандартыг тогтоох механизм нь 5 жил тутамд зохион байгуулдаг Олон улсын хөдөлмөрийн статистикчид /ОУХС/-ын бага хурлын тогтоол, зөвлөмж байдаг. Олон улсад Хөдөлмөрийн статистикийн аргачлалыг 2013 он хүртэл 1982 оны ОУХС-ын 13-р бага хурлын тогтоолоор, 2014 оноос 2013 онд болсон 19-р бага хурлын “Ажил, хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн дутуу ашиглалт” бүхий олон улсын статистикийн стандарт арга зүйн баримт бичиг бүхий тогтоолыг мөрдлөг болгож байна.

Харин Хүүхдийн хөдөлмөрийн статистикийн аргачлалын хувьд 2008 он хүртэл ОУХС-ын 13-р бага хурлын тогтоолын дагуу насанд хүрсэн хүний хөдөлмөр эрхлэлттэй адил авч үзэж байсан бол 2008 оны ОУХС-ын 18-р бага хурлаар хүүхдийн хөдөлмөрийг насанд хүрсэн хүний хөдөлмөр эрхлэлтийн ойлголт, аргачлалаас тусад нь авч үзэх хэрэгтэйг сануулж, “Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн статистикийн тухай” анхны бие даасан тогтоолыг гаргасан. Үүний дараа ОУХС-ын 19-р бага хурлын тогтоолоор ерөнхий ажил, хөдөлмөр гэдэг ойлголт шинэчлэгдсэн тул 2018 онд болсон 20-р бага хурлаар Хүүхдийн хөдөлмөрийн статистикийн аргачлал шинэчлэгдээд байна.

Монгол Улсын Хөдөлмөрийн статистикт Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А-09/08 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг 2019 оноос эхлэн үндсэн аргачлал болгон мөрдөж байна. Энэхүү аргачлалыг 2013, 2018 онуудад болсон Олон улсын хөдөлмөрийн статистикчдын 19, 20-р бага хурлуудын тогтоолын дагуу боловсруулсан.

Шигтгээ 1. Хүүхдийн хөдөлмөрийн талаарх хууль эрх зүйн болон статистикийн үзүүлэлтүүд

ОУХБ-ын Хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарын тухай 1973 оны конвенц (№ 138) нь гишүүн орнуудад хандан хүний хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарыг тэдний бүрэн бус дунд боловсрол эзэмших наснаас доошгүй байхаар буюу 15-аас доошгүй байхаар (Зүйл 2, Хэсэг 3), түүнчлэн өсвөр үеийнхний эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй ажлын онцлог

болон нөхцөл байдлаас шалтгаалж ийм төрлийн хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарыг 18-аас доошгүй байхаар (Зүйл 3, Хэсэг 1) тогтоож мөрдөхийг уриалсан.

Гэсэн хэдий ч олон улсын хэмжээнд аюултай ажлын жагсаалт байдаггүй бөгөөд 18 хүртэлх насны хүн ажиллахыг хориглосон аюултай хөдөлмөрийн хэлбэрийг ажил олгогч, ажилчдын холбогдох байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр үндэсний эрх бүхий байгууллага тогтоох ёстой (Зүйл 3, Хэсэг 2). Энэхүү конвенцод мөн ажилчид болон ажил олгогчдын байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр эрх бүхий үндэсний байгууллага нь улс орныхоо нөхцөл байдалд нийцүүлэн шийдвэрлэх хэд хэдэн заалт орсон. Тухайлбал, хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар, хөнгөн ажлын тухай заалтууд юм.

(a) *Хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар.* Энэ зүйлийн 3 дахь хэсгийн заалтад харшлахгүйгээр, эдийн засаг, боловсролын салбар нь төдийлөн сайн хөгжөөгүй гишүүн улс ажил олгогч, ажилчдын холбогдох байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр эхний үед насны доод хязгаарыг 14 насаар тогтоож болно (Зүйл 2, Хэсэг 4), гэхдээ зарим орнууд 16 насаар тогтоосон байдаг;

(b) *Хөнгөн ажил.* 13-15 насны хүүхдийг хөлсний эсхүл өөр төрлийн хөнгөн хөдөлмөр эрхлүүлэхийг үндэсний хууль тогтоомж, журмаар зөвшөөрч болно. Гэхдээ ийм төрлийн хөдөлмөр нь: (a) эрүүл мэнд, өсөлт хөгжилд хортой нөлөө үзүүлэхгүй, (ii) хичээлдээ суух, эрх бүхий байгууллагаас баталсан мэргэжлийн чиг олгох, мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрт хамрагдах болон олсон мэдлэгээ ашиглах явцад нь саад учруулахгүй байх (Зүйл. 7) зэрэг шаардлагыг хангасан байх ёстой. Хөнгөн ажил хийх насны доод хязгаар нь хөгжиж буй орнуудын хувьд 12 байж болно (Зүйл 7. 4 дэх хэсэг).

ОУХБ-ын **Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 1999 оны конвенц (№ 182)** нь K138-д нэмэлт болгон Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг тодорхойлж нэн даруй таслан зогсоох, улмаар хүүхдийн хөдөлмөрийг устгахыг зорилт болгохыг уриалсан. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдэд:

(a) Хүүхдийг худалдах, өрийн барьцаанд өгөх, боолчлох, албадан хөдөлмөр эрхлүүлэх, зэвсэгт мөргөлдөөнд дайчлах, хүчээр элсүүлэх зэрэг боолчлолын бүх хэлбэрүүд, түүнтэй төстэй практикууд;

(b) Хүүхдийн биеийг үнэлүүлэн бэлгийн мөлжлөгт өртүүлэх, садар самуун агуулга бүхий материал үйлдвэрлэх, садар самууны үзвэр, үйлчилгээнд ашиглах, татан оролцуулах, уг ажлыг санал болгох;

(c) Холбогдох олон улсын гэрээнд заасанчлан мансууруулах бодис үйлдвэрлэх, хил дамнуулан худалдах зэрэг хууль бус үйл ажиллагаанд ашиглах, зуучлах, эсвэл санал болгох;

(d) Үйл ажиллагааны мөн чанар үр дагаврын хувьд хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, зан суртахуунд хохирол учруулахуйц ажлууд орно (Зүйл. 3 "аюултай ажил").

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай ОУХБ-ын Зөвлөмж №190 аюултай ажлыг тодорхойлохдоо анхаарах тодорхой зааврыг улс орнуудад хандан гаргасан.

НҮБ-ын **1989 оны Хүүхдийн эрхийн тухай конвенц**од оролцогч улсууд хүүхдийн эдийн засгийн мөлжлөгөөс хамгаалуулах эрх, хүүхдийн эрүүл мэнд, бие бялдар, оюун ухаан, сэтгэл санаа, ёс суртахуун, нийгмийн хөгжилд аюултай, боловсрол эзэмшихэд нь саад болох ажил эрхлэхээс хамгаалуулах эрхийг хүлээн зөвшөөрнө (Зүйл. 32.1). Энэ зүйлийг хэрэгжүүлэх үүднээс НҮБ-ын Хүний эрхийн комисс оролцогч улсууд олон улсын бусад баримт бичгийн холбогдох заалтыг удирдлага болгон хүний хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарыг тогтоохыг уриалсан (Зүйл 32.2).

Олон улсын хөдөлмөрийн статистикчдын 20 дугаар бага хурлаар баталсан IV Тогтоол нь Хүүхдийн хөдөлмөрийн статистикийн арга зүйн удирдамж юм. Өөрөөр хэлбэл уг баримт нь хүүхдийн хөдөлмөрийн хэмжилтийн олон улсын эрх зүйн хэм хэмжээг *хүүхдийн хөдөлмөрийг шинжлэн судлах* зорилгоор статистикийн ойлголт, үзүүлэлт болгон хөрвүүлэх аргачилсан удирдамж юм. Хүүхдийн хөдөлмөрийг Үндэсний тооцооны систем (ҮТС)-ийн үйлдвэрлэлийн ерөнхий хүрээний буюу **НҮБ-ын Үндэсний тооцооны систем (ҮТС)**-д тодорхойлсон үйлдвэрлэлийн хүрээний ажлын үйл ажиллагаанд оролцож буй хүүхдийн талаарх үзүүлэлтийг тооцож болохыг тогтоосон.

Энэ удаагийн тайланд ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээний ажлын үйл ажиллагаанд оролцож байгаа хүүхдийн хөдөлмөрийг шинжилж судалсан. Олон улсын хөдөлмөрийн статистикчдын 20 дугаар бага хурлаар баталсан IV Тогтоолын заалтыг үндэс болгон "өөрийн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлт, цалин хөлсгүй дадлагажигч, зах зээлийн эсвэл зах зээлийн бус нэгж дэх сайн дурын ажил (өөрөөр хэлбэл, өрхөд үйлчилдэг төрийн болон ашгийн бус байгууллагууд) болон бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг өрхүүдэд сайн дурын ажил зэрэг нь хийх ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээний ажлын хэлбэрүүд" болно. ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээний ажлыг эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох гэж үзсэн.

2.2. Статистикийн ойлголт, тооцоолол

Үндэсний хууль тогтоомж, хүүхдийн хөдөлмөрийн талаарх олон улсын эрх зүйн болоод статистикийн тодорхойлолт, үзүүлэлтүүдийг үндэслэн энэ удаагийн тайланд хүүхдийн хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг дараах байдлаар ангилж судалсан болно. Үүнд:

1. 5-аас 12 насны өөрийн эцсийн хэрэглээнд зориулан бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажилд оролцож эсвэл цалин хөлс, орлогын төлөө бусдад зориулан ажил хийж байгаа хүүхэд;
2. Зөвшөөрөгдөх хөнгөн ажил эрхэлж байгаа хүүхдүүдээс бусад өөрийн эцсийн хэрэглээнд зориулан бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажилд оролцож байгаа эсвэл цалин хөлс, орлогын төлөө бусдад зориулан ажил хийж байгаа 13-14 насны хүүхдүүд. Олон улсын статистикийн удирдамжийн дагуу зөвшөөрөгдөх хөнгөн ажил гэж долоо хоногт 14 цагаас доош хугацаагаар гүйцэтгэсэн аюултайд тооцогдоогүй ажлыг ойлгоно.
3. 15-17 насны аюултай гэж тодорхойлсон салбар, ажил мэргэжлийн ажлыг хийж байгаа эсвэл аюултай гэж тодорхойлогдоогүй салбар, ажил мэргэжлийн ажлыг хэт их цагаар эрхэлж байгаа эсвэл шөнийн цагаар ажил эрхэлж байгаа хүүхэд. Хэт их цагийг тодорхойлохдоо тухайн улсын статистикийн үзүүлэлтийг тодорхойлох зорилгоор тогтоосон босго хэмжээ бүхий цагаар тооцно.

Хүснэгт 2.1. Насны доод хязгаарыг тооцох шалгуур

	Ерөнхий	Хөгжиж байгаа улс орнуудад зөвшөөрч болох хэм хэмжээ
Насны доод хязгаар (заавал мөрдөх)	15 нас (Бүрэн бус дунд боловсрол эзэмших наснаас доошгүй байна)	14 нас
Аюултай ажил (заавал мөрдөх)	18 нас (16 нас, нөхцөлтэйгөөр)	Өөр сонголт, хувилбар байхгүй
Хөнгөн ажил (сонголттой)	13-14 нас	12-13 нас

Хүүхдийн хөдөлмөрийн талаарх үзүүлэлтийг тооцох өргөн хүрээний ойлголт бол ажил хийж байгаа нийт хүүхдийн тоо буюу 2008 оны Үндэсний тооцооны систем (ҮТС)-д тодорхойлсон үйлдвэрлэлийн ерөнхий хүрээнд орж байгаа ямар нэгэн үйл ажиллагаанд оролцож байгаа хүүхэд юм. Хүүхдийн ажил эрхлэлтийн хэлбэрийг Зураг 2.1-т харуулснаар ангилна.

Зураг 2.1. Ажил, түүний хэлбэр



Тайлбар: G – Үйлдвэрлэл
S – Үйлчилгээ

Зураг 2.2. Хүүхдийн ажил эрхлэлт, хэлбэрээр



Статистикийн шинжилгээ судалгаанд хөдөлмөр эрхэлж буй хүүхэд гэдэгт тодорхой хугацаанд дараах төрлийн нэг буюу хэд хэдэн үйл ажиллагаанд оролцож байгаа 5-17 насны хүүхдүүдийг хамруулна. Үүнд:

- А. Тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд (ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээний аюултай ажил);
- Б. ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээний ажил эрхэлж буй хөдөлмөр эрхлэх насны доод хязгаараас доош насны хүүхдүүд;
- В. Үйлдвэрлэлийн ерөнхий хүрээнд цалин хөлсгүй өрхийн үйлчилгээний аюултай ажил хийж буй хүүхдүүд.

Судалгаагаар Зураг 2.1-т харуулсан ажлын хэлбэрүүдээс зөвхөн өөрийн эцсийн хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа, цалин хөлс, орлого олох зорилготойгоор бусдад зориулж хийж байгаа үйл ажиллагаа, цалин хөлсгүй дадлагажих үйл ажиллагааны мэдээллийг цуглуулсан. Харин сайн дурын ажлын хэлбэрийг хамруулаагүй. Иймд Үндэсний тооцооны систем (ҮТС)-д тодорхойлсон үйлдвэрлэлийн хүрээний (зөвхөн өөрийн эцсийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, цалин хөлс, орлого олох зорилготойгоор бусдад зориулж хийж байгаа болон цалин хөлсгүй дадлагажих үйл ажиллагаа) буюу **эдийн засгийн үйл ажиллагаа**ны хүрээнд тайлагнасан.

Хүүхдийн хөдөлмөрийг тодорхойлохдоо тухайн хугацаанд нэг буюу түүнээс дээш хэлбэрийн ажлын үйл ажиллагаанд оролцсон 5-17 насны бүх хүүхдийг хамруулсан. Үүнд:

- Аюултай ажил эрхэлсэн хүүхэд,
- Хөнгөн ажил хийж болохуйц наснаас доош буюу 5-12 настай эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хүүхэд,
- 13-14 насны хүүхдийн аюулгүй ч хөнгөн бус ажил.

Аюултай ажлыг хүүхдийн эрхэлж байгаа ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажлын үйл ажиллагаагаар тодорхойлсон. Үүнд:

- Хуулиар хориглосон буюу “Насанд хүрсэн хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байр”-нд ажиллах,
- Хөдөлмөрийн ажлын нөхцөлд буюу хүүхдийн аюулгүй байдалд хор нөлөө үзүүлэх нөхцөлд ажиллах. Ажлын нөхцөлүүдээс хүнд ачаа өргөх, зөөхийг “Насанд хүрсэн хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-д тусгагдсан “Насанд хүрээгүй хүний гараар өргөх, зөөх ачааны массын зөвшөөрөгдөх дээд хэмжээ”-ээр тооцсон.
- Хэт их цагаар буюу ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээний ажлын үйл ажиллагаануудад нийт ажилласан цаг нь хуулиар тогтоосон дээд хэмжээ (7 хоногт 30 цаг)-нээс их цагаар ажиллах. Хэт их цагаар ажилласан эсэхийг долоо хоногийн жинхэнэ ажилласан цагаар тооцсон.

Хөнгөн ажлыг тодорхойлохдоо 13-14 насны хүүхдийн ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээнд эрхэлж байгаа ажлуудын нийт цаг долоо хоногт 14 цагаас бага байхаар тооцсон.

Хөдөлмөрийн ажлын нөхцөлийг тодорхойлохдоо аюултай машин механизм, тоног төхөөрөмж, багаж зэвсэг, химийн бодистой харьцах, хүнд ачаа гараараа өргөж зөөх болон тээвэрлэх, том мал, амьтантай харьцах, их халуун, хүйтэн, харанхуй, үзэгдэх орчин муу, газар доор, усны гүнд, аюултай өндөрт эсвэл дуу чимээ ихтэй, тоос шороо, утаатай, хэтэрхий давчуу орон зайд ажиллах шалгуураар тодорхойлсон.

3.2. Эдийн засгийн өсөлт, бүтцийн өөрчлөлт

Монгол Улсын эдийн засаг 2000 оноос жил бүр тогтмол өсөж байсан ба 2004 оноос түүхий эдийн үнэ өсөж, хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр ГШХО-ыг нээлттэй болгосноор тус онд эдийн засгийн огцом сэргэлт ажиглагдсан. Харин 2008 оны дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын нөлөөгөөр огцом буурч, 2009 онд ДНБ-ий өсөлт -1.3 хувьд хүрч байсан.

Монгол Улс 2008 оны хямралыг хохирол багатайгаар даван гарсан гэж үздэг бөгөөд энэхүү хямралын дараа дэлхийн зах зээл дээр уул уурхайн түүхий эдийн үнэ огцом өсөж, манай улсын экспорт нэмэгдэн, эдийн засгийн өсөлт 2011 онд хамгийн өндөр буюу 17.3 хувьд хүрсэн. Дэлхийн санхүү, эдийн засгийн хүндрэл, уул уурхай, олборлох салбарын түүхий эдийн үнийн тасралтгүй уналт, ГШХО-ын бууралт зэргээс шалтгаалан 2012-2016 онуудад эдийн засгийн өсөлт 12.3-аас 1.5 хувь хүртэл буурсан.

2019 онд эдийн засгийн өсөлт 5.6 хувьтай байсан бол Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 2020 онд эдийн засаг 4.6 хувиар буурч, харин 2022 онд 5.0 хувиар өслөө.


Зураг 3.4. Эдийн засгийн өсөлт, бууралт, хувиар



Манай Улсын нэг хүнд ногдох ДНБ, 2000 онд 485 ам.доллар, нэг хүнд ногдох ҮНӨ 448 ам.доллар байсан бол 2022 онд нэг хүнд ногдох ДНБ 5033 ам.доллар, нэг хүнд ногдох ҮНӨ 3953 ам.долларт хүрч, нэг хүнд ногдох ДНБ 10.4 дахин, нэг хүнд ногдох ҮНӨ 8.8 дахин нэмэгдсэн байна.

Харин 2014-2017 оны хооронд уг үзүүлэлтүүд тасралтгүй буурсан ба нэг хүнд ногдох ҮНӨ илүү хурдтай буурсан байна.

Зураг 3.5. Нэг хүнд ногдох ДНБ, ҮНӨ, ам. доллароор



3.3. Тэгш бус байдал

Уул уурхайн салбарын хамаарал, эдийн засгийн тогтворгүй өсөлт нь тэгш бус байдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй гэж судлаачид үздэг. Тэгш бус байдлыг Үндэсний статистикийн хороо Жини коэффициент болон Тейлийн индексээр хэмжиж байна.

Жини коэффициент нь хүн амын хэрэглээний зардлын тэгш бус хуваарилалтыг илэрхийлсэн үзүүлэлт юм. Уг үзүүлэлт нь 0-1-ийн хооронд утга авах ба "0" утга руу ойртоход хүн амын хэрэглээний ялгаа багасаж, "1" утгад ойртоход хэрэглээний тэгш бус байдал өндөр байгааг илэрхийлнэ.

Хүн амын хэрэглээний тэгш бус байдлыг тодорхойлох Жини коэффициент улсын дунджаар 2020 онд 0.32 болж 2018 оноос 0.01 нэгжээр буурсан байна. Гэхдээ хүн амын хэрэглээний тэгш бус байдалд сүүлийн 10 жилд дорвитой өөрчлөлт гараагүй байна.

Орлогын ялгаатай бүлэг доторх болон бүлэг хоорондох тэгш бус байдлыг харуулах Тейлийн индекс 2020 онд 0.17 болж, 2018 оноос 0.02 нэгжээр буурсан байна.

Хүснэгт 3.1. Тэгш бус байдал


	2010	2012	2014	2016	2018	2020
Жини коэффициент						
Улсын дундаж	0.33	0.34	0.32	0.32	0.33	0.32
Хот	0.33	0.34	0.33	0.33	0.34	0.33
Хөдөө	0.32	0.31	0.28	0.30	0.29	0.29
Тейлийн индекс						
Улсын дундаж	0.19	0.20	0.19	0.19	0.19	0.17
Хот	0.19	0.21	0.20	0.20	0.21	0.19
Хөдөө	0.18	0.16	0.15	0.15	0.15	0.14

Эх үүсвэр: ӨНЭЗС 2010-2020

Тэгш бус байдлыг хэмжих өөр нэг арга бол хүн амыг хэрэглээний түвшнээр нь тэнцүү 5, 10 бүлэгт хуваах (хүн амыг нэг хүнд сард ногдох хэрэглээний хэмжээгээр нь багаас их рүү нь эрэмбэлэн, улмаар 10, 20-н хувиар буюу тэнцүү 5, 10-н бүлэгт хуваана) арга юм.

Хүн амын хамгийн чинээлэг (V) 20 хувийн хэрэглээний дундаж хэмжээ 2020 онд хамгийн бага хэрэглээтэй (I) 20 хувийнхнаас 5.2 дахин өндөр байна.

Зураг 3.6. Хүн амын хэрэглээний бүтэц, тэнцүү 5 бүлгээр, дүнд эзлэх хувиар



Харин хэрэглээний 10 тэнцүү бүлгийн хувьд хүн амын чинээлэг 10 хувийн хэрэглээний дундаж хэмжээ хамгийн бага хэрэглээтэй 10 хувийнхнаас 7.7 дахин өндөр байна.

Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогыг бүлэглэн үзэхэд, орлогын хэмжээ нэмэгдэх тусам мөнгөн орлогод цалин хөлсний орлогын хэмжээ өсөж байна.

3.4. Өрхийн амьжиргаа

Өрхийн сарын дундаж орлого нэрлэсэн дүнгээр 2010-2014 он хүртэл тасралтгүй өсөж, мөн үеэс хойш 2016 он хүртэл буурч, 2017-2022 онд өссөн дүнтэй байна. Өрхийн орлого 2022 онд нэрлэсэн дүнгээр 1.9 сая төгрөгт хүрсэн нь 2010 оноос 1.4 сая төгрөгөөр буюу 4.1 дахин их байна. Харин үнийн нөлөөллийг арилган 2015 оны зэрэгцүүлэх үнээр илэрхийлж үзэхэд, 2022 онд өрхийн сарын дундаж бодит нийт орлого 1.2 сая төгрөг болж байгаа нь 2010 онтой харьцуулахад 62.9 хувиар, 2021 оноос 1.1 хувиар өссөн байна.

Зураг 3.7. Өрхийн сарын дундаж нэрлэсэн болон бодит орлого, мянган төгрөгөөр



Зураг 3.8. Өрхийн сарын дундаж бодит орлогын өөрчлөлт, хувиар



Өрхийн сарын дундаж бодит орлого 2010 оноос хойших хугацаанд ихээхэн тогтворгүй байсан байна. Өрхийн сарын дундаж бодит орлогын жилийн дундаж өсөлтийн хувь нь 1990 оноос хойших Монгол Улсын нийгэм, эдийн засгийн шилжилтийн он жилүүдэд эдийн засаг хамгийн өндөр өсөлттэй (17.3%) байсан 2011 оны дараах 2012 онд хамгийн өндөр үзүүлэлттэй (25.4%) байжээ. Харин эдийн засгийн өсөлт бага (1.5%) байсан 2016 онд (-11.0%) буурсан нь хамгийн доогуур үзүүлэлтэд тооцогдож байна. Мөн 2021 онд өрхийн сарын дундаж бодит орлогын жилийн дундаж өсөлтийн хувь нь (-5.3%) буурсан нь 2016 оноос хойших 2 дахь бууралт байсан бол 2022 онд өрхийн орлогын өсөлт 1.1 хувь, эдийн засгийн өсөлт 2022 онд 5.0 хувьтай байна.

Зураг 3.9. Өрхийн сарын дундаж бодит орлогын өсөлт, эдийн засгийн өсөлт, хувиар



Өрхийн нийт орлогын бараг тал хувийг цалин хөлсний орлого бүрдүүлдэг бөгөөд 2022 онд нийт орлогын 46.1 хувийг бүрдүүлж байгаа нь 2010 оноос 1.4 нэгж хувиар, 2021 оноос 3.3 нэгж хувиар өссөн байна.

3.5. Ядуурлын түвшин


Монгол Улсын хувьд ядуурлын түвшин (ядуурлын хамралтын хүрээ)-г тооцохдоо хүн амын хэрэглээний зардалд үндэслэсэн мөнгөн хэмжигдэхүүнээр тодорхойлдог.

Хүснэгт 3.2. Ядуурлын шугам, төгрөгөөр

	2010	2012	2014	2016	2018	2020
Ядуурлын шугам	92 072	118 490	146 650	146 145	166 580	184 747
Хүнсний ядуурлын шугам	48 223	65 374	79 855	75 034	84 993	99 803
Хүнсний бус ядуурлын шугам	43 849	53 116	66 795	71 111	81 587	84 944

Эдийн засгийн сэргэлтийн үе буюу 2010-аас 2014 онд ядуурал эрчимтэй буурч 38.8 хувиас 21.6 хувь болсон бол эдийн засгийн хямралын улмаас 2016 онд эргээд 29.6 хувь болж өсжээ. Ядуурлын хамралтын хүрээ 2020 онд 27.8 хувь болж 2018 оноос 0.6 нэгж хувиар буурч, ойролцоогоор нийт хүн амын 903.4 мянга нь ядуу амьдарч байна. Ерөнхий дүр зургаар нь авч үзвэл, 2010-аас 2020 оны хооронд Монгол Улсын хүн амын ядуурал 11.0 нэгж хувиар буурчээ.


Зураг 3.10. Ядуурлын хамралтын хүрээ, хувиар, ядуу хүн амын тоо, мянган хүнээр, улсын дунджаар




Ядуурлын шугам болон ядуурлын шугамыг 25 хувиар өсгөсөн үзүүлэлтийн хооронд байгаа хүн амыг эмзэг буюу ядууралд өртөхөд ойрхон хүн ам гэж тодорхойлсон. Тодруулбал, 2020 оны ядуурлын шугамыг 25 хувиар өсгөхөд нийт хүн амын 14.4 хувь буюу 467.4 мянган хүн ядуурлын шугам болон ядуурлын шугамыг 25 хувиар өсгөсөн үзүүлэлтийн хооронд орж нийт хүн амын 42.2 хувь буюу 1370.8 мянган ядуу хүн болохоор байна. Эдгээр “бараг л ядуу” хүмүүс үнийн өсөлт, ажилгүйдэл, өвчин, байгалийн гамшигт нэрвэгдэх зэрэг цочролд өртөхөд л ядууралд орох эмзэг байдалтай байна.

Зураг 3.11. Ядууралд өртөхөд ойрхон хүн амын хамралтын хүрээ, хувиар, ядууралд өртөхөд ойрхон хүн амын тоо, мянган хүнээр, улсын дунджаар

(а) Ядууралд өртөхөд ойрхон хүн амын хамралтын хүрээ, хувиар, ядууралд өртөхөд ойрхон хүн амын тоо, мянган хүнээр




(б) Ядуу, ядууралд өртөхөд ойрхон хүн амын хамралтын хүрээ, хувиар




Ядуурлын түвшин 2018-аас 2020 оны хооронд хот, хөдөөд өөрчлөлт багатай байна. 2010 онд хөдөөгийн хүн амын арван хүн тутмын тав нь ядуу амьдарч байсан бол 2020 онд арван хүн тутмын гурав нь ядуу байна. Хот, хөдөөгийн ядуурлын хамралтын хүрээний зөрүү багассан, гэхдээ хот суурин газарт ядуу хүн амын төвлөрөл харьцангуй их байна. Хот суурин газарт амьдарч байгаа ядуу хүн амын эзлэх хувь нийт ядуу хүн амын 55.2 хувь (2010 онд) байснаа 63.9 (2020 онд) хувь болон өсжээ.

Зураг 3.12. Ядуурлын байдал, хот, хөдөөгөөр

(а) Хамралтын хүрээ, хувиар, ядуу хүн амын тоо, мянган хүнээр



(б) Ядуу хүн амын дүнд эзлэх хувь



3.6. Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид 2022 онд 2.6 сая болж, өмнөх оноос 62.0 (2.4%) мянган хүнээр өссөн байна. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээнд хамрагдагчдын 48.1 хувь нь хүүхдийн мөнгөн тэтгэмж авсан 18 хүртэлх насны хүүхдүүд, 10.8 хувь нь эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж авагчид, 12.4 хувь нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ авагчид, 28.7 хувь нь бусад төрлийн нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид байна.

Хүснэгт 3.3. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид, төрлөөр, мянган хүн

Үзүүлэлт	2019	2020	2021	2022
Бүгд	2359.4	2554.0	2460.9	2614.2
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ	431.5	429.8	373.3	324.0
Нийгмийн халамжийн тэтгэвэр	60.7	59.1	74.6	65.6
Нийгмийн халамжийн тэтгэмж	120.1	121.7	123.9	125.8
Нийгмийн халамжийн үйлчилгээ	250.8	249.0	174.9	132.6
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	242.3	264.4	167.3	122.0
Эхийн алдар одонгийн мөнгөн урамшуулал	224.1	230.2	239.2	246.7
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	1000.0	1186.3	1220.2	1258.2
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	194.5	236.7	135.9	279.5
Алдар цолтон ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	2.8	2.5	2.4	3.2
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	57.9	38.4	33.1	50.8
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	321.6	287.9	298.9	283.2
Насны хишиг	135.5	141.8	157.6	168.2
Цаатан иргэний тэтгэмж	0.4	0.4	0.4	0.4

¹Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн дүнд "Ирээдүйн өв сангийн тухай хууль"-ийн дагуу Сангийн яамнаас 2022 онд олгогдсон хүүхдийн мөнгөний зарцуулалтыг нэмж тусгасан.

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Монгол Улсын Сангийн яам

3.7. Хөдөлмөр

Манай улсын хөдөлмөрийн зах зээлд сүүлийн 5 жилийн байдлаар нэлээдгүй өөрчлөлтүүд ажиглагдаж байна. Ажиллах хүч 2022 онд 1.3 сая болж 2018 оныхоос 93.4 (6.9%) мянган хүнээр буурч, ажиллах хүчнээс гадуурх хүн ам 894.4 мянга болж 26.4 (3.0%) мянган хүнээр өссөн байна. Хөдөлмөрийн насны хүн амд ажиллах хүчний эзлэх хувь болох ажиллах хүчний оролцооны түвшин 58.6 хувь болж 2018 оныхоос 2.4 нэгж хувиар, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 54.7 хувь болж 1.6 нэгж хувиар буурсан нь хөдөлмөрийн насны хүн амын бүтцийн өөрчлөлтөөс гадна хөдөлмөрийн зах зээлийн идэвхжил суларсан байгааг харуулж байна

Хүснэгт 3.4. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд, мянган хүн

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Ажиллах хүч	1147.1	1124.7	1151.1	1198.3	1206.6	1243.9	1275.6
Ажиллагчид	1033.7	1037.7	1056.4	1103.6	1110.7	1151.2	1147.8
Ажилгүй хүн	113.4	87.0	94.7	94.7	95.9	92.7	127.8
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	716.2	673.7	661.0	738.8	735.0	779.0	831.4
Ажиллах хүчний оролцооны түвшин, %	61.6	62.5	63.5	61.9	62.1	61.5	60.5
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %	55.5	57.7	58.3	57.0	57.2	56.9	54.5
Ажилгүйдлийн түвшин, %	9.9	7.7	8.2	7.9	7.9	7.5	10.0

Үзүүлэлт	2017	2018	2019*	2020	2021	2022
Ажиллах хүч	1357.4	1358.6	1273.9	1250.6	1225.4	1265.2
Ажиллагчид	1238.3	1253.0	1146.2	1162.9	1125.6	1180.5
Ажилгүй хүн	119.1	105.6	127.7	87.7	99.8	84.7
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	863.0	868.0	832.2	877.5	926.8	894.4
Ажиллах хүчний оролцооны түвшин, %	61.1	61.0	60.5	58.8	56.9	58.6
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %	55.8	56.3	54.4	54.6	52.3	54.7
Ажилгүйдлийн түвшин, %	8.8	7.8	10.0	7.0	8.1	6.7

* Аргачлал шинэчлэгдсэн.

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2010 онд 55.5 хувь, эдийн засгийн өсөлтийн жилүүд болох 2011-2014 онд дунджаар 57.6 хувьд хүрч байсан бол 2022 онд 54.7 хувь болж 2010 онтой харьцуулахад 0.8 нэгж хувиар буурчээ.

Ажилгүйдлийн түвшнийг хүйсээр авч үзвэл, эмэгтэйчүүдийнх 2010-2022 онд дунджаар 7.6 хувь, эрэгтэйчүүдийнх 8.8 хувь байгаа нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү их ажил хөдөлмөр эрхлэх хандлагатай байгаа гэж харагдаж байгаа боловч эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин эрэгтэйчүүдийнхээс 2010-2022 онд дунджаар 11.4 нэгж хувиар бага, 2010 онтой харьцуулахад 2022 онд 2.6 нэгж хувиар буурсан байна.


Зураг 3.13. Хөдөлмөр эрхлэлтийн болон ажилгүйдлийн түвшин, хүйсээр, хувиар



Хөдөлмөрийн зах зээл дэх жендерийн асуудлын үндсэн шалтгаан нь гэрлэлт, гэр орны ажил болон бусдыг асран халамжлах үүрэг, хариуцлага, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажил үүргийн


талаарх нийгэмд тогтсон ойлголт, хэм хэмжээ, хүлээлт зэрэгтэй холбоотой байна. Түүнчлэн улс төрийн орчин нөхцөл, өндөр настнуудын болон хүүхэд асрах үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй байгаа нь эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтэд нөлөөлж байгаа юм.

Зураг 3.14. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, дүнд эзлэх хувиар



Сүүлийн 12 жилийн хугацаанд хөдөө аж ахуйн салбарт ажиллагчдын нийт ажиллагчдад эзлэх хувь 33.5-аас 24.9 хувь болж, 8.6 нэгж хувиар буурч, аж үйлдвэр, барилгын салбарын ажиллагчид 5.6 нэгж хувиар, уул уурхайн салбарынх 1.8 нэгж хувиар, үйлчилгээний салбарынх 1.2 нэгж хувиар өссөн байна. Ажиллах хүч цалин хөлс, хөдөлмөрийн бүтээмж харьцангуй бага уламжлалт хөдөө аж ахуй салбараас аж үйлдвэр, үйлчилгээний салбарт шилжиж байна.

Зураг 3.15. Хөдөлмөрийн үзүүлэлт, аймгаар, 2022 он




3.8. Хүний хөгжлийн индекс

Хүний хөгжлийн индекс 2018 онд 0.759 байсан бол 2022 онд 0.781 болж, 0.022 нэгжээр нэмэгдэхэд боловсролын индекс 0.033 нэгжээр өссөн нь голлон нөлөөлсөн. Хүний хөгжлийн тэгш бус байдлаар засварласан индекс 2018 онд 0.670 байсан бол 2022 онд 0.703 болж, 0.033 нэгж хувиар нэмэгджээ. Тэгш бус байдлын улмаас алдагдсан боломж 2022 онд 10.0 хувь болж, 2018 оноос 0.033 нэгж хувиар нэмэгдсэн байна. Жендэрийн тэгш бус байдлын индекс 2022 онд 0.276 болж, 2018 оноос 0.012 нэгжээр буурсан байна.

Хүснэгт 3.5. Хүний хөгжлийн индекс

Индекс	2018	2019	2020	2021	2022
Хүн амын дундаж наслалтын индекс	0.772	0.776	0.780	0.785	0.789
Хүн амын боловсролын түвшний индекс	0.721	0.725	0.761	0.761	0.754
ҮНӨ-ын индекс	0.784	0.790	0.784	0.784	0.801
Хүний хөгжлийн индекс	0.759	0.763	0.775	0.776	0.781
Дундаж наслалтын тэгш бус байдлаар засварласан индекс	0.685	0.688	0.694	0.698	0.703
Боловсролын тэгш бус байдлаар засварласан индекс	0.661	0.664	0.733	0.733	0.726
Орлогын тэгш бус байдлаар засварласан индекс	0.664	0.668	0.664	0.665	0.680
Хүний хөгжлийн тэгш бус байдлаар засварласан индекс (ХХТБЗИ)	0.670	0.674	0.696	0.698	0.703
Жендэрийн тэгш бус байдлын индекс	0.288	0.274	0.286	0.367	0.276

Зураг 3.16. Хүний хөгжлийн индекс




БҮЛЭГ IV. ХҮҮХДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал нь тайлангийн гол сэдэв хэдий ч тайланд тэдний оролцож байгаа бүхий л хүрээний үйл ажиллагааг хамруулахыг зорилоо. Иймд энэ бүлэгт хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа болон сургуульд хамрагдалттай холбоотой үр дүнг багтаалаа.


Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа нь хүүхдийн хөдөлмөр болон хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөр эрхлэх насны хүүхдийн эрхэлж байгаа хөнгөн хэлбэрийн ажлыг багтаасан өргөн хүрээний ойлголт юм. Өөрөөр хэлбэл эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож буй хүүхэд гэдгийг ҮТС-ийн хүрээнд авч үзэж байгаа бөгөөд энэ нь арилжааны зорилгоор бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэж буй бүх үйл ажиллагаа болон хувийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэж байгаа үйл ажиллагаагаар тодорхойлогддог.

Зураг 4.1. 5-17 насны хүүхдийн эдийн засгийн оролцоо



Нийт хүүхдийн тодорхой хэсэг болох эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн тоог Веннийн энгийн дүрслэлийг ашиглан зураглалаа (Зураг 4.1).

Схем 4.1. 5-17 насны хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа



Судалгаагаар 5-17 насны хүүхдийн 208.0 мянга буюу 24.4 хувь нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон, тэдгээрийн 138.5 мянга буюу 66.6 хувь нь хөдөлмөр эрхэлсэн, 69.4 мянга буюу 33.4 хувь нь хөдөлмөр эрхлээгүй байна.


Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож байгаа 5-17 насны хүүхдүүдийн 126.1 мянга буюу 60.7 хувь нь хөвгүүд, 81.8 мянга буюу 39.3 хувь нь охид байна. Харин байршлын хувьд 105.7 мянга (50.8%) нь хотод, суурин газарт, 102.2 мянга (49.2%) нь хөдөөд амьдарч байна.

Хүснэгт 4.1. Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон 5-17 насны хүүхэд, насны бүлгээр, хүйс, байршил, бүсээр

Үзүүлэлтүүд		Насны бүлэг							
		5-12 насны хүүхэд		13-14 насны хүүхэд		15-17 насны хүүхэд		Бүгд	
		%	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо
Бүгд		99139	100.0%	48710	100.0%	60102	100.0%	207951	100.0%
Хүйс	Хөвгүүд	60029	60.6%	28745	59.0%	37367	62.2%	126141	60.7%
	Охид	39110	39.4%	19965	41.0%	22735	37.8%	81810	39.3%
Байршил, Хүйс	Хот	47428	100.0%	26635	100.0%	31673	100.0%	105736	100.0%
	Хөвгүүд	30859	65.1%	16280	61.1%	19881	62.8%	67020	63.4%
	Охид	16569	34.9%	10355	38.9%	11792	37.2%	38716	36.6%
	Хөдөө	51711	100.0%	22075	100.0%	28429	100.0%	102215	100.0%
	Хөвгүүд	29170	56.4%	12465	56.5%	17486	61.5%	59121	57.8%
	Охид	22541	43.6%	9610	43.5%	10943	38.5%	43094	42.2%
	Бүс								
Бүс	Баруун бүс	29800	30.1%	11167	22.9%	13292	22.1%	54259	26.1%
	Хангайн бүс	18606	18.8%	10493	21.5%	13467	22.4%	42566	20.5%
	Төвийн бүс	11291	11.4%	5983	12.3%	9215	15.3%	26489	12.7%
	Зүүн бүс	7444	7.5%	3917	8.0%	4163	6.9%	15524	7.5%
	Улаанбаатар	31998	32.3%	17150	35.2%	19965	33.2%	69113	33.2%


Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон 5-17 насны хүүхдийн эзлэх хувь улсын хэмжээнд 24.4%, хүйсийн хувьд хөвгүүдийнх 28.9%, охидынх 17.7% байна. Насны бүлгийн хувьд нас нэмэгдэх тусам хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох оролцоо нэмэгдэж байна.

Зураг 4.2. Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн эзлэх хувь, насаар, хүйс, байршлаар




Байршлын хувьд хөдөөд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн хувь өндөр байна. Хот, суурин газрын хүүхдүүдийн сургуульд хамрагдалт илүү өндөр (хотод 95.2 хувь, хөдөөд 94.8 хувь) байгаа бөгөөд зөвхөн сургуульд суралцдаг хүүхдийн хувь хөдөөгийнхөөс өндөр (хотод 79.3 хувь, хөдөөд 59.2 хувь) байна.

Зураг 4.3. Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн эзлэх хувь, хүйсээр, байршил, насны бүлгээр



Нийт 5-17 насны хүүхдэд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн эзлэх хувийн жин бүс нутгаар ихээхэн ялгаатай буюу Баруун бүсэд 48.7%, Хангайн бүсэд 27.7%, Зүүн бүсэд 26.9% байгаа нь улсын дунджаас дээгүүр үзүүлэлттэй байгаа бол Төвийн бүсэд 20.3%, Улаанбаатар хотод 17.3% байгаа нь улсын дунджаас доогуур үзүүлэлттэй байна. Харин аймгийн түвшин авч үзэхэд, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий аймагт 51.3-55.2 хувь, Өвөрхангай, Увс аймагт 41.5-42.7 хувь, Завхан, Сэлэнгэ, Дундговь, Булган, Архангай аймагт 30.2-39.7 хувь, Хэнтий, Баянхонгор, Дорнод, Орхон аймагт 24.8-28.8 хувь байгаа нь улсын дунджаас дээгүүр байна.


Зураг 4.4. Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон 5-17 насны хүүхэд, насны бүлгээр, аймгаар



Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдүүдийг эрхэлсэн ажлын хэлбэрээр нь авч үзэх, эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон арван хүүхэд тутмын гурав нь зөвхөн өөрийн эцсийн хэрэглээний ХАА-н бус үйлдвэрлэл эрхэлсэн, хоёр нь өөрийн эцсийн хэрэглээний ХАА-н болон ХАА-н бус үйлдвэрлэлийг хамтад нь эрхэлсэн, хоёр нь зөвхөн өөрийн эцсийн хэрэглээний

ХАА-н үйлдвэрлэл эрхэлсэн байна. Энэ хандлага хүйс болон насны бүлэгт хадгалагдаж байгаа бол байршлын хувьд нэлээд ялгаатай байна. Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож буй хот, суурин газрын таван хүүхэд тутмын дөрөв нь зөвхөн өөрийн эцсийн хэрэглээний ХАА-н бус үйлдвэрлэлийн ажил эрхэлсэн бол хөдөөд өөрийн эцсийн хэрэглээний ХАА-н болон ХАА-н бус үйлдвэрлэлийг хамтад нь, зөвхөн өөрийн эцсийн хэрэглээний ХАА-н бус үйлдвэрлэл эсвэл зөвхөн өөрийн эцсийн хэрэглээний ХАА-н үйлдвэрлэлийг тус бүр арван хүүхэд тутмын гурав нь эрхэлсэн байна.


Зураг 4.5. 5-17 насны эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхэд, ажлын хэлбэрээр, хүйс, байршил, насны бүлгээр



Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 “Монгол Улсын иргэн суурь боловсрол заавал эзэмших үүрэгтэй” гэж заасны дагуу энэхүү тайланд сургуульд хамрагдалтыг 6-14 насны хүүхдээр онцлон авч, харин 15-17 насны хүүхдийн сургуульд хамрагдалтыг харьцуулах зорилгоор тусгасан болно.


6-14 насны нийт хүүхдийн 21.8 хувь нь суралцахын зэрэгцээ эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон байхад зөвхөн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, сургуульд суралцдаггүй хүүхдүүд 0.6 хувийг, зөвхөн сургууль суралцагчид 73.3 хувийг, сургуульд ч сурдаггүй, эдийн засгийн үйл ажиллагаанд ч оролцдоггүй хүүхэд 4.3 хувийг эзэлж байна.

Зураг 4.6. Хүүхдийн сургуульд хамрагдалт болон эдийн засгийн үйл ажиллагааны оролцоо, насны бүлгээр



6-14 насны хүүхдүүдтэй харьцуулахад 15-17 насны хүүхдүүд зөвхөн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох оролцоо болон эдийн засгийн үйл ажиллагаанд оролцохын зэрэгцээ сургуульд суралцах нь нэмэгдэж, харин зөвхөн сургуульд суралцах хувь буурч байна.

Зураг 4.7. Хүүхдийн цэцэрлэг, сургуульд хамрагдалт болон эдийн засгийн үйл ажиллагаа, насаар



Хүснэгт 4.2. 6-14 насны хүүхдийн сургуульд хамрагдалт болон эдийн засгийн үйл ажиллагаа, хүйс, байршлаар

Үзүүлэлтүүд		Үйл ажиллагаагаар:									
		6-14 насны хүүхэд		Зөвхөн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон		Зөвхөн сургуульд суралцдаг		Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцохын зэрэгцээ сургуульд суралцсан		Аль нь ч биш	
		Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Бүгд		644796	100.0%	3871	100.0%	472617	100.0%	140544	100.0%	27764	100.0%
Хүйс	Хөвгүүд	329639	51.1%	2423	62.6%	227239	48.1%	84469	60.1%	15508	55.9%
	Охид	315157	48.9%	1448	37.4%	245378	51.9%	56075	39.9%	12256	44.1%
Байршил, хүйс	Хот	452849	100.0%	934	100.0%	358917	100.0%	72336	100.0%	20662	100.0%
	Хөвгүүд	229975	50.8%	552	59.1%	171229	47.7%	46084	63.7%	12110	58.6%
	Охид	222874	49.2%	382	40.9%	187688	52.3%	26252	36.3%	8552	41.4%
	Хөдөө	191947	100.0%	2937	100.0%	113700	100.0%	68208	100.0%	7102	100.0%
	Хөвгүүд	99664	51.9%	1871	63.7%	56010	49.3%	38385	56.3%	3398	47.8%
	Охид	92283	48.1%	1066	36.3%	57690	50.7%	29823	43.7%	3704	52.2%


БҮЛЭГ V. ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хүүхдийн хөдөлмөр нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдүүд гэсэн ойлголтоос илүү нарийвчилсан өөр ойлголт юм. Өөрөөр хэлбэл, хүүхэд хэт их цагаар эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох, тэдний оролцож байгаа эдийн засгийн үйл ажиллагаа нь нийгмийн болон ёс суртахууны хувьд зохимжгүй гэж үзэн хориглосон, эсвэл хөдөлмөрийн насны доод хязгаараас бага настай хүүхэд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон тухай ойлголт юм. Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн тоон мэдээллийг бий болгосноор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож байгаа хүүхдийн хэд нь “эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсоноор тэдний эрүүл мэнд, өсөлт хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх, сурч боловсроход саад учруулах нөхцөлд байна” вэ гэдэг асуултад хариулах боломж бүрдэх юм.


Энэ бүлэгт хөдөлмөр эрхэлж байгаа, тэдгээрээс аюултай ажил эрхэлж буй хүүхэд, тэдний эдийн засгийн үндсэн үйл ажиллагааны шинж чанар, ямар ажлын хэлбэрүүдэд хэдэн цагаар оролцож байгаа талаар тусгалаа. Ингэснээр хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх бодлого нь аль бүлэгт, ямар онцлогийг чиглүүлэх ёстойг мэдэхэд чухал ач холбогдолтой.

Улсын хэмжээнд 138.5 мянган хүүхэд хөдөлмөр эрхэлж байгаа нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож байгаа хүүхдийн 66.6 хувийг эзэлж байна. Харин 5-17 насны нийт хүүхдэд хөдөлмөр эрхэлж байгаа тухайн насны хүүхдийн эзлэх хувь буюу хүүхдийн хөдөлмөрийн эрхлэлтийн түвшин улсын хэмжээнд 16.3 хувь байна. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин хүйсийн хувьд хөвгүүд охидоос 7.4 нэгж хувиар их байна. Харин байршил, бүсийн хувьд ихээхэн ялгаатай буюу хөдөө хот, суурин газрын хүүхдүүдээс 19.8 нэгж хувиар их, Баруун бүсэд 16.1-26.3 нэгж хувиар их байна.

Зураг 5.1. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, насны бүлэг, хүйс, байршил, бүсээр



Зураг 5.2. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, ангиллаар



Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг олон улсын аргачлал болон үндэсний хууль эрх зүйн заалтад тулгуурлан тооцсон ангиллын дагуу авч үзэхэд, тэдний 78.2 мянга (56.5%) нь хөнгөн ажлыг хийж болохуйц наснаас доош нас (5-12)-ны, 58.2 мянга (42.0%) нь аюултай ажил эрхэлж байгаа, 2.1 мянга (1.5%) нь аюулгүй ч хөнгөн бус хөдөлмөр эрхэлж байгаа 13-14 насны хүүхдүүд байна.


Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн 86.7 мянга (62.6%) хөвгүүд, 51.8 мянга (37.4%) нь охид, насны хувьд 99.1 мянга (71.6%) нь 5-12 насныхан, 15.9 мянга (11.4%) нь 13-14 насныхан, 23.5 мянга (17.0%) нь 15-17 насныхан байна.

Хүснэгт 5.1. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, насны бүлгээр, хүйс, байршил, бүсээр

Үзүүлэлтүүд		Насны бүлэг							
		5-12 насны хүүхэд		13-14 насны хүүхэд		15-17 насны хүүхэд		Бүгд	
		%	%	%	%	%	%	%	%
Бүгд		99140	100.0%	15882	100.0%	23503	100.0%	138525	100.0%
Хүйс	Хөвгүүд	60029	60.5%	9994	62.9%	16701	71.1%	86724	62.6%
	Охид	39111	39.5%	5888	37.1%	6802	28.9%	51801	37.4%
Байршил, Хүйс	Хот	47428	100.0%	4614	100.0%	8702	100.0%	60744	100.0%
	Хөвгүүд	30859	65.1%	2878	62.4%	6504	74.7%	40241	66.2%
	Охид	16569	34.9%	1736	37.6%	2198	25.3%	20503	33.8%
	Хөдөө	51712	100.0%	11268	100.0%	14801	100.0%	77781	100.0%
	Хөвгүүд	29170	56.4%	7116	63.2%	10197	68.9%	46483	59.8%
	Охид	22542	43.6%	4152	36.8%	4604	31.1%	31298	40.2%
Бүс	Баруун бүс	29801	30.1%	4753	29.9%	5966	25.4%	40520	29.3%
	Хангайн бүс	18606	18.8%	4090	25.8%	6393	27.2%	29089	21.0%
	Төвийн бүс	11291	11.4%	2545	16.0%	3803	16.2%	17639	12.7%
	Зүүн бүс	7444	7.5%	1877	11.8%	2289	9.7%	11610	8.4%
	Улаанбаатар	31998	32.3%	2617	16.5%	5052	21.5%	39667	28.6%

Хөдөлмөр эрхэлж байгаа таван хүүхэд тутмын гурав нь хөдөөд амьдарч байгаа бол бүсийн хувьд арван хүүхэд тутмын гурав нь Улаанбаатар хотод, мөн гурав нь Баруун бүсэд амьдарч байна. Хэдийгээр хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн дүнд Улаанбаатар хотод амьдарч байгаа хүүхдийн эзлэх хувь өндөр буюу 32.3 хувьтай байгаа ч Улаанбаатар хотын 5-17 насны нийт хүүхдэд эзлэх хувь буюу хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшнээр хамгийн бага (10.0%) дүнтэй байна. Энэ нь Монгол Улсын нүүдлийн мал аж ахуй эрхлэлт, ахуйн соёл болон дэд бүтцийн асуудалтай холбоотой гэж тайлбарлаж болох юм.


Зураг 5.3. Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд, нас, хүйсээр дүнд эзлэх хувиар




Дээрх зургаас харахад 5-12 насны хүүхдийн хувьд нас нэмэх тусам хөдөлмөр эрхлэх нь нэмэгдэж байгаа бөгөөд 95.7 мянга нь буюу 96.5 хувь нь зөвхөн өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд оролцсон байна (Хүснэгт 5.2). Үүнтэй холбоотойгоор уг насны бүлгийн хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин өндөр байна.

Хүүхдийн хөдөлмөрийн түвшин 13-17 насны бүлэгт 11.9-19.2 хувь болж нэмэгдсэн нь тэдний өсөлт, хөгжилд сөргөөр нөлөөлөх аюултай ажил, 13-14 насанд аюултайд тооцогдохгүй ч хөнгөн бус ажил эрхлэх нэмэгдэж байгааг илэрхийлж байна. Хүйсийн хувьд уг хандлага ажиглагдаж байгаа ч охидын хувьд 15 насанд 1.7 нэгж хувиар буурч, 17 нас хүртэл дахин нэмэгдсэн байна. Харин байршлаар хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг авч үзэхэд бүх насанд хөдөөд хот, суурин газраас өндөр байгаа бөгөөд 12 насанд хамгийн их буюу 29.6 нэгж хувиар, 5 насанд хамгийн бага буюу 11.8 нэгж хувиар их байна.

Зураг 5.4. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, нас, хүйсээр




Зураг 5.5. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, байршлаар



Хөдөлмөр эрхлэлтийн түвшин Ховд (45.4%), Баян-Өлгий (43.1%), Говь-Алтай (42.3%) аймагт хамгийн өндөр байна. Харин Сэлэнгэ, Булган, Өвөрхангай аймагт 5-17 насны дөрвөн хүүхэд тутмын нэг нь, Завхан, Увс, Архангай, Дорнод, Дундговь, Хэнтий, Баянхонгор, Сүхбаатар аймагт 5-17 насны таван хүүхэд тутмын нэг нь хөдөлмөр эрхэлж байна.


Зураг 5.6. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, аймаг, нийслэлээр



Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд хэд хэдэн ажлын хэлбэрт давхар оролцох боломжтой. Өөрөөр хэлбэл цалин хөлс, орлого олох зорилготой ажил эрхэлж буй зарим хүүхдүүд өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эсвэл бусад үйл ажиллагааны аль алинд нь давхар оролцсон байх боломжтой. Иймд нийт хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн үндсэн үйл ажиллагааг хамгийн их цаг зарцуулсан ажлын хэлбэрээр нь тодорхойлж, зөвхөн үндсэн ажлынх нь хүрээнд эдийн засгийн үйл ажиллагаагаар дараах зурагт харууллаа.

Хөдөлмөр эрхэлсэн 5-17 насны хоёр хүүхэд тутмын нэг нь өрхийн хэрэглээнд зориулж байгалийн болон нийтийн эх үүсвэрээс ус зөөх, түлээ бэлтгэх үйл ажиллагаанд, арван хүүхэд тутмын гурав нь мал аж ахуй эрхлэх, нэг нь газар тариалан эрхлэх үйл ажиллагаанд оролцсон байна.

Зураг 5.7. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн үндсэн үйл ажиллагааны салбараар, дүнд эзлэх хувиар



5.1. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн ажлын хэлбэр

Хүүхдийн хөдөлмөрийг ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээний ажлын хэлбэр (Зураг 2.1) - үүдийн үйл ажиллагаанд оролцсон байдлаар тодорхойлсон бөгөөд ажлын хэлбэрүүдийг Олон улсын хөдөлмөрийн статистикчдын 19 дүгээр Бага хурлаар (2013)-аар баталсан “Ажил, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн дутуу ашиглалт”-ын тухай тогтоолд тусгасан ойлголт болон тодорхойлолттой нийцүүлсэн /тайлангийн Бүлэг 2 болон хавсралт 2-оос дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү/. Ингэснээр хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүд өөрийн өрхийн эцсийн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэлд оролцохоос эхлүүлээд зах зээлд чиглэсэн үйлдвэрлэл, бусад үйл ажиллагаанд хэр хэмжээгээр оролцож байгааг олж тогтоох ач холбогдолтой.

Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн 126.6 мянга (91.4%) нь зөвхөн өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, 5.1 мянга (3.7%) нь зөвхөн цалин хөлс, орлого олох үйл ажиллагаа, 212 (0.2%) нь зөвхөн цалин хөлсгүй дадлагажих үйл ажиллагаа эрхэлсэн бол 6.5 мянга (4.7%) нь эдгээр үйл ажиллагааг давхар эрхэлсэн байна.

Хүснэгт 5.2. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, ажлын хэлбэрээр, насны бүлэг, хүйс, байршлаар

		Зөвхөн цалин хөлс, орлого олох ажил эрхэлсэн		Зөвхөн өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлсэн		Зөвхөн цалин хөлсгүй дадлагажих ажил эрхэлсэн		Цалин хөлс, орлого олох болон өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажлыг хамт эрхэлсэн		Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил болон цалин хөлсгүй дадлагажих ажлыг хамт эрхэлсэн		Бүгд	
		Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Бүгд		5061	100.0%	126617	100.0%	212	100.0%	6508	100.0%	127	100.0%	138525	100.0%
Хүйс	Хөвгүүд	3135	61.9%	78488	62.0%	145	68.4%	4873	74.9%	83	65.4%	86724	62.6%
	Охид	1926	38.1%	48129	38.0%	67	31.6%	1635	25.1%	44	34.6%	51801	37.4%
Насны бүлэг	5 – 12 нас	1829	36.1%	95702	75.6%	-	-	1597	24.5%	12	9.4%	99140	71.6%
	13 – 14 нас	1133	22.4%	13311	10.5%	-	-	1438	22.1%	-	-	15882	11.5%
	15 – 17 нас	2099	41.5%	17604	13.9%	212	100.0%	3473	53.4%	115	90.6%	23503	17.0%
Байршил	Хот	3530	69.7%	53811	42.5%	163	76.9%	3125	48.0%	115	90.6%	60744	43.9%
	Хөдөө	1531	30.3%	72806	57.5%	49	23.1%	3383	52.0%	12	9.4%	77781	56.1%
Бүс	Баруун бүс	304	6.0%	39435	31.1%	-	-	781	12.0%	-	-	40520	29.3%
	Хангайн бүс	1124	22.2%	25621	20.2%	123	58.0%	2167	33.3%	54	42.5%	29089	21.0%
	Төвийн бүс	962	19.0%	16191	12.8%	-	-	486	7.5%	-	-	17639	12.7%
	Зүүн бүс	840	16.6%	9710	7.7%	-	-	1060	16.3%	-	-	11610	8.4%
	Улаанбаатар	1831	36.2%	35660	28.2%	89	42.0%	2014	30.9%	73	57.5%	39667	28.6%

хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн 133.2 мянга (96.2%) нь өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлсэн (судалгааны хугацаанд энэ үйл ажиллагаанаас гадна ажлын бусад хэлбэрт оролцсон хүүхэд орсон дүн), мөн 11.6 мянга (8.4%) нь цалин хөлс, орлого олох зорилготой ажил эрхэлсэн, 212 (0.2%) нь цалин хөлсгүй дадлагажих ажил эрхэлсэн байна.

Зураг 5.8. Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд



Ажлын аль ч хэлбэр нь бие биеэсээ үл хамаарах үйл ажиллагаа огт биш бөгөөд цалин хөлс, орлого олох зорилготой ажил эрхэлж буй зарим хүүхдүүд өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эсвэл бусад үйл ажиллагааны аль алинд нь давхар оролцсон байх боломжтой. Иймд ерөнхий дүр зургийг бүхэлд нь харуулахын тулд Веннийн энгийн диаграм ашиглан хөдөлмөр эрхэлж буй нийт хүүхэд, тэдгээрийн ямар ажлын хэлбэрт оролцож байгааг харууллаа.

5.1.1. Цалин хөлс, орлого олох зорилготой хөдөлмөр эрхэлж буй хүүхэд

Энэ хэсэгт хөдөлмөр эрхэлж буй хүүхдээс цалин хөлс, орлого олох зорилгоор ажил эрхэлж байгаа хүүхдийн талаар танилцуулж байна.

Хөдөлмөр эрхэлж буй нийт хүүхдийн 11.6 мянга нь цалин хөлс, орлого олох зорилгоор бусдад зориулж ажил эрхэлсэн, тэдний 5.1 мянга нь зөвхөн уг үйл ажиллагааг эрхэлсэн бол 6.5 мянга нь давхар өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлд зориулж ажил эрхэлсэн байна.

Цалин хөлс, орлого олох зорилготой хөдөлмөр эрхэлсэн арван хүүхэд тутмын долоо нь хөвгүүд байна. Байршлын хувьд хот, суурин газарт илүү байгаа бол бүсээр авч үзэхэд Улаанбаатар болон Хангайн бүсэд бусад бүсээс өндөр байна.

Насны хувьд хоёр хүүхэд тутмын нэг нь 5-14 насны хүүхдүүд байгаа ба тэдний ихэнх нь хөдөө аж ахуйн салбарт ажил эрхэлж, 13-14 насанд мөн үйлчилгээний салбарт ажил эрхлэх нь нэмэгдсэн байна. Харин 15-17 насны хүүхдүүд аж үйлдвэр, барилгын салбарт ихээр ажил эрхэлж байна.


Хүснэгт 5.3. Цалин хөлс, орлого олох зорилготой хөдөлмөр эрхэлсэн хүүхэд, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, насны бүлэг, хүйс, байршил, бүсээр

Суурь үзүүлэлт		Бүгд		Эдийн засгийн салбараар:				Дүн
		Тоо	%	Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ	Хүүхэд асрах, гэрийн үйлчлэгч	
Бүгд		11 569	100%	50.5%	22.7%	25.0%	1.8%	100.0%
Хүйс	Хөвгүүд	8 008	69.2%	52.7%	26.1%	20.2%	1.0%	100.0%
	Охид	3 561	30.8%	45.7%	15.1%	35.7%	3.5%	100.0%
Насны бүлэг	5 - 12 нас	3 427	29.6%	75.4%	9.0%	12.4%	3.2%	100.0%
	13 - 14 нас	2 571	22.2%	58.1%	10.0%	32.0%	-	100.0%
	15 - 17 нас	5 571	48.2%	31.8%	37.0%	29.5%	1.7%	100.0%
Байршил	Хот	6 655	57.5%	26.0%	33.9%	37.0%	3.1%	100.0%
	Хөдөө	4 914	42.5%	83.7%	7.5%	8.7%	-	100.0%
Бүс	Баруун бүс	1 085	9.4%	55.9%	9.1%	34.9%	-	100.0%
	Хангайн бүс	3 292	28.5%	61.0%	23.5%	14.1%	1.4%	100.0%
	Төвийн бүс	1 448	12.5%	66.0%	13.1%	20.9%	-	100.0%
	Зүүн бүс	1 900	16.4%	79.6%	7.7%	12.7%	-	100.0%
	Улаанбаатар	3 845	33.2%	19.9%	36.9%	39.1%	4.2%	100.0%

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарыг дэлгэрүүлж авч үзэхэд цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн 4.7 мянга (40.9%) нь мал аж ахуйн салбарт, 2.0 мянга (17.3%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 1.6 мянга (14.1%) боловсруулах үйлдвэрлэлийн, 1.1 мянга (9.6%) нь газар тариалан, ойн аж ахуйн, 1.0 мянга (8.4%) нь барилгын салбарт ажилласан байна. Хүйсийн хувьд уг хандлага адил ажиглагдаж байгаа ч цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа охид (3.6 мянга)-ын 0.4 мянга (11.8%) нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт ажилласан байна.


Цалин хөлс, орлого олох зорилготой хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагааны салбар нь байршлын хувьд нэлээд ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал хөдөөд цалин хөлс, орлого олохоор хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн ихэнх нь мал аж ахуй эрхэлж байгаа бол хот, суурин газарт бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ажилласан байна.

Зураг 5.9. Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, дүнд эзлэх хувиар




Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа арван хүүхэд тутмын дөрөв нь энгийн ажил мэргэжлээр, дөрөв нь хөдөө аж ахуй, ойн аж ахуйн мэргэжлээр, нэг нь худалдаа үйлчилгээний мэргэжлээр ажилласан байна.

Зураг 5.10. Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд, ажил мэргэжлээр, дүнд эзлэх хувиар




Хөдөлмөр эрхлэлтийн статусын хувьд тэдгээр хүүхдийн 9.5 мянга (81.8%) нь гэр бүлийн гишүүдэд хувь нэмэр оруулагч, 2.0 мянга (17.0%) нь цалин хөлстэй ажиллагч байна. Байршлаар авч үзэхэд хот, суурин газарт бие даасан үйл ажиллагаа эрхлэгч байгаа бөгөөд насны хувьд бүгд 15-17 насны хүүхдүүд байна.

Зураг 5.11. Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, хүйс, байршил, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар




Цалин хөлс, орлого олох зорилготой хөдөлмөр эрхэлсэн хүүхдүүд сард дунджаар 661.3 мянган төгрөгийн цалин хөлс, орлого олсон байна. Салбарын хувьд хөдөө аж ахуйн салбарт 764.9 мянга, аж үйлдвэр, барилгын салбарт 699.3 мянга байгаа нь улсын дунджаас 38.0-103.6 мянган төгрөгөөр их байна. Хүйсийн хувьд хөвгүүд охидоос илүү цалин хөлс, орлого олж байгаа нь охид хөвгүүдтэй харьцуулахад үйлчилгээний салбарт ихээр ажиллаж байгаатай холбоотой.

Зураг 5.12. Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн сарын дундаж цалин, орлого, хүйс, байршил, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар



Цалин хөлс, орлого олох зорилготой ажиллаж байгаа 5-17 насны хүүхдүүд уг үйл ажиллагаандаа долоо хоногт дунджаар 19 цаг зарцуулж байна. Хүйсийн хувьд охид хөвгүүдээс их цаг зарцуулж байна. Байршлын хувьд ихээхэн ялгаатай байгаа бөгөөд хот, суурин газарт өрхийн секторт буюу хүүхэд асрах, гэрийн үйлчлэгчээр ажиллаж байгаа хүүхдүүд долоо хоногт дунджаар 25 цаг зарцуулж байна.

Зураг 5.13. Хүүхдийн цалин хөлс, орлого олох ажилд зарцуулсан цаг, салбараар, хүйс, байршил, насны бүлгээр



Зураг 5.14. Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн сургуульд хамрагдалт, дүнд эзлэх хувиар



Тэдний 6.0 мянга (51.8%) нь суурь боловсрол эзэмшин насны буюу 6-14 насны хүүхэд байгаагийн 2.3 хувь нь сургуульд сурдаггүй, зөвхөн хөдөлмөр эрхэлж байна. Хүйсийн хувьд зөвхөн хөвгүүд байна.

5.1.2. Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлж буй хүүхэд

Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн 133.2 мянга (96.2%) нь өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажилд оролцсон, тэдгээрийн 6.6 мянга (5.0%) нь уг үйл ажиллагааг цалин хөлс, орлого олох ажилтай давхар эрхэлсэн байна. Мөн эдгээр хүүхэд өөрийн эцсийн хэрэглээний хэд хэдэн төрлийн үйл ажиллагаанд давхар оролцсон ба дараах хүснэгт, зургуудын дүнд эзлэх хувийг давхардсан дүнгээр тооцсон болно.

Нөгөөтээгүүр өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэл эрхэлсэн хүүхэд бүрийг хөдөлмөр эрхэлсэн гэж үзэхгүй бөгөөд энэхүү тайлангийн Бүлэг-2-т танилцуулсан тооцооллын дагуу аюулгүй болон хөнгөн хэлбэрийн ажил эрхэлж байгаа 13-14 насны хүүхэд, аюулгүй ажил эрхэлж байгаа 15-17 насны хүүхдийг хөдөлмөр эрхэлтэд тооцоогүй болно. Иймд энэ хэсэгт зөвхөн хөдөлмөр эрхэлтийн хүрээний өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлж байгаа хүүхдүүдийн талаар танилцуулж байна.

Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлж буй хүүхдүүдийн 62.6 хувь нь хөвгүүд, 37.4 хувь нь охид, байршлын хувьд 42.8 хувь нь хот, суурин газарт, 57.2 хувь нь хөдөө амьдарч байна.

Хүснэгт 5.4. Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлж буй хүүхэд, үйл ажиллагааны төрлөөр, хүйс, байршлаар, дүнд эзлэх хувиар

Үйл ажиллагаа	Бүгд	Хөвгүүд	Охид	Хот	Хөдөө
Бүгд	133 252	83 444	49 808	57 050	76 202
Газар тариалан	0.8%	0.6%	1.2%	0.8%	0.8%
Мал, тэжээвэр амьтан өсгөх	35.8%	35.8%	35.8%	9.1%	55.9%
Ойн аж ахуй, мол бэлтгэл	0.6%	0.7%	0.4%	0.0%	1.0%
Байгалаас жимс, мөөг зэрэг бусад хүнсний бүтээгдэхүүн цуглуулах	0.9%	0.6%	1.4%	1.2%	0.7%
Ан агнах	0.1%	0.0%	0.2%	0.1%	0.1%
Хоол хүнсийг хадгалах, нөөцлөх зориулалтаар бэлтгэх	2.6%	2.2%	3.3%	1.5%	3.4%
Ахуйн зориулалттай байгууламж шинээр барих, засварлах	2.9%	3.6%	1.9%	1.0%	4.4%
Ахуйн хэрэглээний бусад зүйлсийг шинээр хийх, засварлах	2.3%	2.1%	2.6%	0.8%	3.4%
Байгалийн болон нийтийн эх үүсвэрээс ус зөөх	66.0%	69.0%	61.0%	85.5%	51.4%
Түлээ бэлтгэх	38.0%	38.2%	37.7%	29.1%	44.7%

Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлсэн хүүхдүүдийн 88.0 мянга (66.0%) нь өрхийн хэрэглээндээ зориулж байгалийн болон нийтийн эх үүсвэрээс ус зөөсөн, мөн 50.7 мянга (38.0%) нь өрхийн хэрэглээндээ зориулж түлээ бэлтгэсэн, мөн 47.7 мянга (35.8%) нь өрхийн хэрэгцээндээ зориулан мал, тэжээвэр амьтан өсгөх, үржүүлэх үйл ажиллагаанд оролцсон байна. Энэ хандлага хүйсийн хувьд хадгалагдаж байгаа ч байршлын хувьд хөдөөд хот, суурин газраас

мал аж ахуйн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн эзлэх хувь 46.8 нэгж хувиар, түлээ бэлтгэх үйл ажиллагааных 15.6 нэгж хувиар их байна. Харин байгалийн эсвэл нийтийн эх үүсвэрээс ус зөөсөн хүүхдийн эзлэх хувь хот, суурин газарт хөдөөгийнхөөс 34.1 нэгж хувиар их байна. Энэ нь хот, суурин газрын дэд бүтэц, насанд хүрэгчдийн ажлын цаг урт байгаа гэх мэт хүчин зүйлс нөлөөлсөн байх талтай. Харин хөдөөд ердийн хөсөг эсвэл авто машинаар насанд хүрэгчид ус зөөх хандлага илүү байдаг бол хот, суурин газар хүүхэд, багачууд нийтийн эх үүсвэрээс ус авахаар үүссэн дараалалд багагүй хугацаа зарцуулан ус авах хандлага их байдаг.

Хэдийгээр өрхийн болон өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил (Хүснэгт 5.4-д дурдсан үйл ажиллагаа)-д оролцсон хэдий ч хүүхдийн хөгжилд сөргөөр нөлөөлдөг гэж үздэг тул хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэд хамааруулдаг.

Ус зөөх, мал амьтан өсгөх, түлээ бэлтгэх үйл ажиллагаа нь өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлсэн хүүхдийн үйл ажиллагааны төрөл нь насны бүлгүүдэд мөн ажиглагдаж байна.

Зураг 5.15. Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлж буй хүүхэд, үйл ажиллагааны төрлөөр, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар




Хүснэгт 5.5. Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлж буй хүүхдийн долоо хоногт зарцуулсан дундаж цаг, үйл ажиллагааны төрлөөр, хүйс, байршил, насны бүлгээр

	Бүгд	Хөвгүүд	Охид	Хот	Хөдөө	5-12 нас	13-14 нас	15-17 нас
Бүгд	6	7	6	3	9	5	11	11
Газар тариалан, ойн аж ахуй	11	12	9	12	10	9	13	14
Мал, тэжээвэр амьтан өсгөх	11	12	9	13	10	9	13	14
Байгалаас жимс, мөөг зэрэг бусад хүнсний бүтээгдэхүүн цуглуулах	4	3	4	4	4	3	7	2
Ан агнах	2	2	2	2	2	2	2	2
Хоол хүнсийг хадгалах, нөөцлөх зориулалтаар бэлтгэх	4	3	5	3	4	3	5	4
Ахуйн зориулалттай байгууламж шинээр барих, засварлах	4	4	5	7	4	4	4	5
Ахуйн хэрэглээний бусад зүйлсийг шинээр хийх, засварлах	4	5	3	4	4	3	4	7
Байгалийн болон нийтийн эх үүсвэрээс ус зөөх	2	2	2	2	2	2	2	2
Түлээ бэлтгэх	2	2	3	2	3	2	3	3

Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдээс өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлж байгаа хүүхдүүд уг ажилдаа долоо хоногт дунджаар 6 цаг зарцуулж байна. Хүйсийн хувьд хөвгүүд илүү цаг зарцуулж байна.

Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлд оролцож байгаа 6-14 насны 108.6 мянган хүүхэд байгаагийн 96.6 хувь нь сургуульд сурдаг, 3.4 хувь нь сургуульд сурдаггүй хүүхдүүд байна. Уг хандлага хүйсийн хувьд хадгалагдаж, харин байршлын хувьд хөдөөд 4.6 хувь, хот, суурин газарт 1.9 хувь нь сургуульд сурдаггүй хүүхэд байна. Эдгээр сургуульд сурдаггүй хүүхдийн 58.9 хувь нь зургаан настай, 11.8 хувь нь 7 настай хүүхдүүд байна.

Зураг 5.16. Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлж буй хүүхдийн сургуульд хамрагдалт, хүйс, байршил, насны бүлгээр




5.2. Ажлын цаг

Энэ хэсэгт хүүхдийн хөдөлмөрт зарцуулсан цагтай холбоотой мэдээллийг хүргэж байна. Хүүхэд хөдөлмөр эрхлэх цаг хугацаа нэмэгдэх тусам ажлаас үүдсэн өвчлөл, осол гэмтэлд өртөх эрсдэл нэмэгдэх, сургуульд явах, хичээлээ давтах, чөлөөт цагаа өнгөрөөх, хангалттай амрах эрхээ хязгаарлуулах гэх мэт маш олон сөрөг үр дагавартай тул цагийн мэдээлэл нь чухал юм.

Судалгаагаар хөдөлмөр эрхлэлтийн бүх ажлын хэлбэрийн хувьд сүүлийн долоо хоногт жинхэнэ ажилласан цагийн мэдээллийг цуглуулсан тул ажлын цагийн үр дүнг жинхэнэ ажилласан цагаар тооцсон. Харин тогтмол ажилладаг цагийн мэдээллийг зөвхөн цалин хөлс, орлого олох ажлын хувьд л цуглуулсан.

Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд цалин хөлс, орлого олох ажилд долоо хоногт дунджаар 19 цаг, өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажилд 6 цаг, цалин хөлсгүй дадлагажих ажилд 22 цаг зарцуулсан байна.

Зураг 5.17. Хүүхдийн хөдөлмөрт зарцуулсан цаг, ажлын хэлбэрээр, хүйс, байршлаар




Хөдөлмөр эрхлэлтийн бүх ажлын хэлбэрүүдэд зарцуулсан нийт цагийн хувьд долоо хоногт дунджаар 8 цаг, хөвгүүд 9 цаг, охид 7 цаг зарцуулсан бол хот, суурин газрын хүүхдүүд 6 цаг, хөдөө амьдарч буй хүүхдүүд 10 цаг зарцуулсан байна.

Хүснэгт 5.6. Хүүхдийн хөдөлмөрт зарцуулсан цаг, насны бүлэг, ажлын хэлбэрээр, хүйс, байршлаар

Суурь үзүүлэлтүүд		5-12 насны хүүхэд				13-14 насны хүүхэд				15-17 насны хүүхэд			
		Зөвхөн өөрийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил	Зөвхөн цалин, орлого олох зорилготой ажил	Өөрийн хэрэглээний үйлдвэрлэл болон цалин, орлого олох зорилготой ажил	Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт (бүх ажил)	Зөвхөн өөрийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил	Зөвхөн цалин, орлого олох зорилготой ажил	Өөрийн хэрэглээний үйлдвэрлэл болон цалин, орлого олох зорилготой ажил	Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт (бүх ажил)	Зөвхөн өөрийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил	Зөвхөн цалин, орлого олох зорилготой ажил	Өөрийн хэрэглээний үйлдвэрлэл болон цалин, орлого олох зорилготой ажил	Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт (бүх ажил)
Нийт		5	10	22	5	12	25	30	14	12	23	31	15
Хүйс	Хөвгүүд	5	8	23	6	11	25	27	13	13	19	30	16
	Охид	5	12	20	5	12	25	34	15	9	31	37	13
	Хот	3	10	16	3	9	26	23	13	6	26	33	16
Байршил, хүйс	Хөвгүүд	3	9	16	3	7	27	23	12	7	21	31	15
	Охид	2	12	15	3	11	26	-	15	5	37	39	17
	Хөдөө	7	8	24	8	13	19	33	14	14	12	29	15
	Хөвгүүд	8	7	26	8	13	19	32	14	15	14	28	17
	Охид	6	12	22	7	13	17	34	15	11	8	35	12

Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн 6.4 хувь нь уг ажлын хэлбэртээ долоо хоногт 30-аас дээш зарцуулж байна.

Зураг 5.18. Хүүхдийн хөдөлмөрт зарцуулсан цаг, цагийн интервалиар, дүнд эзлэх хувиар



Сургуульд суралцангаа хөдөлмөр эрхэлж байгаа 6-14 насны хүүхдүүд долоо хоногт дунджаар 7 цаг зарцуулж байгаа бол сурдаггүй, зөвхөн хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд 10 цаг зарцуулж байна.

Хүснэгт 5.7. Хүүхдийн хөдөлмөрт зарцуулсан цаг, сургуульд хамрагдалтын байдлаар

	Суралцангаа хөдөлмөр эрхэлдэг				Зөвхөн хөдөлмөр эрхэлдэг			
	Бүгд	Зөвхөн өөрийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил	Зөвхөн цалин, орлого олох зорилготой ажил	Уг хоёр ажлыг хамтад нь эрхэлсэн	Бүгд	Зөвхөн өөрийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил	Зөвхөн цалин, орлого олох зорилготой ажил	Уг хоёр ажлыг хамтад нь эрхэлсэн
Бүгд	7	16	6	24	10	26	9	29
Хөвгүүд	7	13	6	23	12	26	11	29
Охид	7	19	6	25	6	-	6	-
Хот	4	18	3	16	5	-	3	37
Хөвгүүд	4	16	3	16	6	-	3	37
Охид	4	20	3	14	3	-	3	-
Хөдөө	9	10	8	27	11	26	11	23
Хөвгүүд	10	9	9	27	14	26	13	23
Охид	8	13	8	27	7	-	7	-

5.3. Ажлын байрны нөхцөл


Хүүхдийн хөдөлмөрийг хүүхдийн нас, ажилласан цагаар нь тодорхойлохоос гадна хүүхэд ямар нөхцөлд ажиллаж байгаа, тухайн хүүхдийн эрүүл мэнд, бие бялдарт нь ямар хор хохирол учруулж болохуйц байгаа зэргийг харгалзан үзэх шаардлагатай байдаг.

Ажлын байрны нөхцөл гэдэг нь хүүхэд эсвэл насанд хүрэгчдийн ажиллаж буй ажлын байрны орчин тойрон, нийгмийн бодит байдлыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, тодорхой ажлын байран дээрх хөдөлмөрийн үйл явц, ажлын байрны байршилд хамаарах нөхцөл юм.

Иймд хүүхдийн хөдөлмөрөөс үүдэн осол, гэмтэлд өртсөн, эсвэл дарамт, хүчирхийллээс үүдэн бие махбод, сэтгэл зүйн хувьд гэмтэл авч байсан талаарх мэдээллийг судалгаагаар цуглуулсан.


Судалгаагаар хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн 44.8 мянга буюу 32.4 хувь нь хөдөлмөр эрхлэх явцдаа ажлын байрандаа айдас, аюултай байдлыг мэдэрч, 6.5 мянга буюу 4.7 хувь нь хөдөлмөр эрхлэх явцдаа осолд өртөж, гэмтэл авч, 5.4 мянга буюу 3.9 хувь нь хөдөлмөр эрхлэх явцдаа бусдад дээрэлхүүлж байсан, 0.4 мянга буюу 0.3 хувь нь ажлын байрны хүчирхийллээс үүдэн гэмтэл авчээ.

Зураг 5.19. Ажлын нөхцөл, тулгарсан хүндрэлээр



Хөдөлмөр эрхлэх бусдад дээрэлхүүлж байсан тохиолдлын хэлбэрийг нарийвчлан судлахад, нийт хөдөлмөр эрхэлсэн хүүхдүүдийн дүнд эзлэх хувиар дараах зургаар харууллаа.

Зураг 5.20. Хөдөлмөр эрхлэх явцдаа алдаа гаргаж шийтгүүлсэн тохиолдол




Хөдөлмөр эрхлэх явцдаа осол, гэмтэл авч байсан хүүхдүүдийг осол, гэмтлийн төрлөөр авч үзэхэд, нийт хөдөлмөр эрхэлсэн хүүхдүүдийн 1.7 хувь нь эд зүйлд цохигдсан, 1.3 хувь нь мал, амьтанд хазуулсан, 1.0 хувь нь өндрөөс эсвэл эд зүйл дээрээс унасан байна.

Зураг 5.21. Хөдөлмөр эрхлэх явцдаа осол, гэмтэл авсан тохиолдол, төрлөөр



Мөн хөдөлмөр эрхэлсэн хүүхдүүдийн 1.3 хувь нь хөдөлмөрлөх явцдаа бэртэж яс нь хугарсан байсан төдийгүй багагүй хүүхэд биеийн аль нэг хэсгийг тайруулж байжээ. Энэ нь хэдийгээр бага тоо мэт харагдаж байгаа ч хүүхэд хөдөлмөр эрхэлснээс үүдэн бэртэж, гэмтэх асуудал байсаар байгаа нь хүүхэд хамгааллын чиглэлээр анхаарах асуудлыг нэг хэвээр байна.

Зураг 5.22. Хөдөлмөр эрхлэх явцдаа өвдсөн тохиолдол, үүссэн өвчнөөр



5.3. Аюултай ажил хийж буй хүүхэд

ОУХБ-ын 182 дугаар конвенцын 3 дугаар зүйлд заасны дагуу хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт дараах хэлбэрийн ажил хамаарна. Үүнд:

1. Боолчлолын бүх хэлбэр эсвэл хүүхдийг худалдаалах, дамжуулан худалдаалах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр, албадан хөдөлмөр эрхлүүлэх зэрэг боолчлолтой төстэй үйл ажиллагаа,
2. Хүүхдийн биеийг үнэлүүлж бэлгийн мөлжлөгт өртүүлэх, садар самуун сурталчилгаа, үзүүлбэрт ашиглах, зуучлах, санал болгох,
3. Олон улсын холбогдох гэрээнд тодорхойлсноор хүүхдийг мансууруулах бодис үйлдвэрлэх үйл ажиллагаанд оролцуулах, хил дамжуулан худалдаалах зэрэг хууль бус үйл ажиллагаанд ашиглах, зуучлах, санал болгох,
4. Ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажил.

Дээрх 1-3-т дурдсан үйл ажиллагааг 4-т тусгагдсан аюултай ажлаас бусад хүүхдийн тэвчишгүй хэлбэрүүд буюу “хүүхдийн хөдөлмөрийн үл тэвчих хэлбэрүүд” гэж нэрлэдэг. Олон улсад хүүхдийн хөдөлмөрийн үл тэвчих хэлбэрийн статистикийн ойлголт, тодорхойлолт одоогоор бүрэн боловсруулагдаагүй, ийм статистикийн үзүүлэлтийг тодорхойлох ажил туршилтын шатандаа байна. Иймд энэхүү судалгаагаар хүүхдийн тэвчишгүй хэлбэрийг аюултай ажлын хүрээнд, үндэсний хууль тогтоомжтой уялдуулан холбогдох мэдээлэл цуглуулсан.

Судалгаагаар хөдөлмөр эрхэлж байгаа таван хүүхэд тутмын хоёр нь эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахууны хөгжилд шууд аюул учруулах аюултай ажил эрхэлж байна.


Аюултай ажил эрхэлж буй 58.2 мянган хүүхдийн 68.2 хувь нь хөвгүүд, байршлын хувьд 68.5 хувь нь хөдөө амьдардаг хүүхдүүд байгаа нь хүйс, байршлын хувьд ихээхэн ялгаа байгаа нь харуулж байна.

Хүснэгт 5.8. Аюултай ажил эрхэлж байгаа хүүхэд, хүйс, насны бүлэг, байршил, бүсээр


		Бүгд		Зөвхөн хуулиар хориглосон ажлын байранд ажиллаж байгаа хүүхэд		Зөвхөн хэт их цагаар ажиллаж байгаа хүүхэд		Зөвхөн хөдөлмөрийн аюултай нөхцөлд ажиллаж байгаа хүүхэд		Аль аль нөхцөлд нь хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд	
		Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Бүгд		58233	100.0%	1742	100.0%	1060	100.0%	49384	100.0%	6047	100.0%
Хүйс	Хөвгүүд	39744	68.2%	1483	85.1%	736	69.4%	32646	66.1%	4879	80.7%
	Охид	18489	31.8%	259	14.9%	324	30.6%	16738	33.9%	1168	19.3%
Насны бүлэг	5 - 12 нас	20897	35.9%	821	47.1%	273	-	18668	37.8%	1135	18.8%
	13 - 14 нас	13833	23.8%	213	12.2%	158	-	12348	25.0%	1114	-
	15 - 17 нас	23503	40.4%	708	40.6%	629	59.3%	18368	37.2%	3798	62.8%
Байршил	Хот	18327	31.5%	1009	57.9%	376	35.5%	14043	28.4%	2899	47.9%
	Хөдөө	39906	68.5%	733	42.1%	684	64.5%	35341	71.6%	3148	52.1%
Бүс	Баруун бүс	16180	27.8%	56	3.2%	319	-	14795	30.0%	1010	-
	Хангайн бүс	14871	25.5%	472	27.1%	201	19.0%	12428	25.2%	1770	29.3%
	Төвийн бүс	9454	16.2%	527	30.3%	72	-	8290	16.8%	565	-
	Зүүн бүс	6422	11.0%	111	6.4%	272	-	4919	10.0%	1120	-
	Улаанбаатар	11306	19.4%	576	33.1%	196	18.5%	8952	18.1%	1582	26.2%

Судалгаагаар 5-17 насны нийт хүүхдэд аюултай ажил эрхэлж байгаа хүүхдийн эзлэх хувь буюу аюултай ажил эрхлэлтийн түвшин 6.8 хувь байна.


Зураг 5.23. Аюултай хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хүйс, насны бүлэг, байршлаар



Зураг 5.24. Аюултай ажил эрхлэлтийн түвшин, аймаг, нийслэлээр



Зураг 5.25. Аюултай ажил эрхэлсэн хүүхэд, хэлбэрээр, дүнд эзлэх хувиар




Аюултай ажил эрхэлж байгаа хүүхдүүдийн 49.4 мянга буюу 84.8 хувь нь зөвхөн хөдөлмөрийн аюултай нөхцөлд, 1.7 мянга буюу 3.0 хувь нь зөвхөн аюултайд тооцогдох салбар, мэргэжлээр, 1.0 мянга буюу 1.8 хувь нь зөвхөн хэт их цагаар ажилласан бол 6.0 мянга буюу 10.4 хувь нь эдгээр ажлыг давхар эрхэлсэн байна.

Судалгаагаар аюултай ажил эрхэлж буй нийт хүүхдийн 4.8 мянга (аюултай ажлын бусад хэлбэрүүдэд хамаарагдах буюу холимог гэж тодорхойлогдсон хүүхэд орсон дүн) буюу 8.2 хувь нь Хөдөлмөрийн сайд (хуучнаар)-ын 2016 онд баталсан "Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг

хориглосон ажлын байрны жагсаалт"-нд буй ажил мэргэжлийн ажлыг хийж байна. Насан хүрээгүй хүүхдийг ажиллуулахыг хориглосон ажил хийж буй таван хүүхэд тутмын хоёр нь барилгын салбарт дотоод засал, чимэглэлийн ажил туслах, барилгын материал, багаж хэрэгсэл зөөх гэх мэт барилгын ажилд тусан гүйцэтгэх ажлыг хийж байна.

Зураг 5.26. Хориглосон ажлын байранд ажиллаж байгаа хүүхэд, салбар, мэргэжлээр, хүйсээр



Хориглосон ажлын байранд хөдөлмөр эрхэлж буй 4.8 мянган хүүхдийн 4.2 мянга буюу 88.0 хувь нь хөвгүүд байна. Охидын хувьд барилгын салбарт дотоод засал чимэглэлийн туслан гүйцэтгэх ажил, худалдааны салбарт ачаа өргөж зөөх, буулгах ажил, шувуу, зөгий үржүүлэх аж ахуйн ажил болон хурдны морь унах ажил эрхэлсэн байна.


Хориглосон ажлын байранд ажиллаж буй хүүхдүүдийн насны бүлэг болон байршлаарх ялгааг дараах зургаар харууллаа.

Зураг 5.27. Хориглосон ажлын байранд ажиллаж байгаа хүүхэд, салбар, мэргэжлээр, насны бүлэг, байршлаар, дүнд эзлэх хувиар



Сүүлийн долоо хоногт 30-аас их цагаар ажилласан (аюултай ажлын бусад хэлбэрүүдэд хамаарагдах буюу холимог гэж тодорхойлогдсон хүүхэд орсон дүн) 5-17 насны 4.7 мянган хүүхэд байна. Хэт их цагаар ажилласан хүүхдүүдийн 2.1 мянга буюу 45.6 хувь нь зөвхөн өөрийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлсэн, 0.5 мянга буюу 11.5 хувь нь зөвхөн цалин хөлс, орлого олох ажил эрхэлсэн бол 2.0 мянга буюу 42.9 хувь нь эдгээр ажлыг хавсран/давхар эрхэлсэн байна. Нийт хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн 3.4 хувь нь хэт их цагаар ажиллаж байгаа бол хүйсийн хувьд хөвгүүд өндөр, байршлын хувьд хөдөөд өндөр хувьтай байна.

Зураг 5.29. Хэт их цагаар ажиллаж байгаа хүүхдүүд, ажлын хэлбэрээр, дүнд эзлэх хувиар




Зураг 5.28. Хэт их цагаар ажиллаж байгаа хүүхдийн хөдөлмөр эрхэлж буй хүүхдэд эзлэх хувь



Ажлын байрны нөхцөлийн хувьд хамгийн нийтлэг аюул нь хэт өндөр температур эсвэл чийгшил, тоос шороотой нөхцөл (27.5%) байна. Хүйсийн хувьд хөвгүүд, байршлын хувьд хөдөөд илүү ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлд илүү өртсөн байна.

Зураг 5.30. Хөдөлмөрийн аюултай нөхцөлд ажиллаж байгаа хүүхэд, ажлын нөхцөлөөр



5.5. Хүүхдийн хөдөлмөрийн улирлын хэлбэлзэл

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт улирлаар хэрхэн хэлбэлзэл байгааг гаргах зорилгоор судалгааны түүврийн хэмжээг дөрвөн улирлаар бүлэглэн тэнцүү хувааж, түүврийн сонголтыг 3 сар тутам буюу улирал бүрээр хийсэн.


Судалгаагаар хүүхдийн хөдөлмөр эрхлэлт улирлын дүнгээр хэлбэлзэж байгаа бөгөөд 3 дугаар улирал буюу 7-9 сард хамгийн их буюу 158.5 мянган хүүхэд, 4 дүгээр улирал буюу 10-12 сард хамгийн бага буюу 90.1 мянган хүүхэд хөдөлмөр эрхэлсэн байна. Судалгааны 4 дүгээр улирал нь ил задгай газар эсвэл гадаа ажиллахад тохиромжгүй хамгийн хүйтэн, хатуу ширүүн уур амьсгалтай улирал байдаг учраас хүүхдийн хөдөлмөр эрхлэх боломж бага байж болох талтай юм. Харин 3 дугаар улиралд хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоо хамгийн их байгаа нь эдийн засгийн ямар нэгэн үйл ажиллагаа эрхлэх хамгийн боломжтой дулаан уур амьсгалтай улиралд намар, өвлийн улиралд бэлтгэх олон төрлийн ажил хийгддэг, мөн бүх шатны сургалтын байгууллагын амралт эхэлдэгтэй холбоотой байж болно.

Хүснэгт 5.9. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, улирлаар, хүйс, насны бүлэг, байршлаар


Суурь үзүүлэлт		1-р улирал		2-р улирал		3-р улирал		4-р улирал	
		Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Бүгд		108431	100.0%	141881	100.0%	158464	100.0%	90105	100.0%
Хүйс	Хөвгүүд	68567	63.2%	89580	63.1%	100040	63.1%	56205	62.4%
	Охид	39864	36.8%	52301	36.9%	58424	36.9%	33900	37.6%
Насны бүлэг	5 - 12 нас	80760	74.5%	108555	76.5%	111912	70.6%	61596	68.4%
	13 – 14 нас	9823	9.1%	12955	9.1%	18939	12.0%	10726	11.9%
	15 - 17 нас	17848	16.5%	20371	14.4%	27613	17.4%	17783	19.7%
Байршил	Хот	64544	59.5%	88960	62.7%	81715	51.6%	48296	53.6%
	Хөдөө	43887	40.5%	52921	37.3%	76749	48.4%	41809	46.4%

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин улирлын дүнгээр мөн хэлбэлзэж 1-ээс 3-р улирал хүртэл өсөн 18.6 хувь (хамгийн их)-д хүрч, 4 дүгээр улиралд бууран 10.6 хувь (хамгийн бага) байна.


Зураг 5.31. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, аюултай ажил эрхлэлтийн түвшин, улирлаар



Зураг 5.32. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хүйсээр, улирлаар



Зураг 5.33. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, байршлаар, улирлаар



Хөдөө орон нутагт 3 дугаар улиралд хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин хамгийн өндөр буюу 44.8 хувь байгаа бол хот, суурин газарт 2 дугаар улиралд хамгийн өндөр буюу 13.2 хувь байна. Хот, суурин газарт 1-ээс 2 дугаар улиралд өсөж, 3 дугаар улирлаас буурсан Зураг 5.34-т харуулснаар нь өрхийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэл ус авах, түлээ, түлш бэлтгэх үйл ажиллагаанд оролцох нь буурсантай холбоотой байна.


Монгол орны жилийн дөрвөн улирлын онцлогоос шалтгаалан ажил эрхэлсэн хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудад ялгаатай байгаа нь дараах зургаас харагдаж байна.

Зураг 5.34. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, мянган хүүхдээр




Судалгааны дүнгээс харахад бүх улирлуудад хөдөлмөр эрхэлсэн хүүхдүүдэд ус зөөх, түлээ бэлтгэх гэрийн ажил эрхэлсэн, хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдийн эзлэх хувь өндөр байна. Энэ нь Монгол орны онцлог шинж байдал буюу Монголчуудын эрт дээр үеэс таван хошуу малыг жилийн дөрвөн улиралд маллаж, ашиг шимээр нь амьдарч ирсэн уламжлалт ахуйтай холбоотой.

Зураг 5.35. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, ажлын хэлбэрээр, улирлаар, мянган хүүхдээр



Хүүхдийн өөрийн эцсийн хэрэглээний ажил 1-ээс 3 дугаар улиралд өссөн байгаа ч түүний дэд үйл ажиллагаа болох ус зөөх, түлээ бэлтгэх ажил эрхэлсэн хүүхэд 1-ээс 2 дугаар улиралд өсөж, 3 дугаар улирлаас бууран (Зураг 5.34) байна. Энэ нь байгалийн цаг уур, улирлын шинж байдалтай холбоотой.

Зураг 5.36. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, ангиллаар, улирлаар, мянган хүүхдээр



БҮЛЭГ VI. ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БУЙ ХҮҮХЭД, ТЭДНИЙ ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ, СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ

Энэ бүлэгт хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн өрхийн нийгэм, эдийн засгийн байдал, өрхийн бүтцийн талаар тусгасан. Ингэснээр эдгээр шинж чанарууд болон хүүхдийн хөдөлмөр хоорондын хамаарлыг ойлгох нь хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх бодлого нь аль бүлэг, ямар онцлогийг чиглүүлэх ёстойг мэдэхэд чухал ач холбогдолтой юм. Мөн энэ хэсэгт хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн сургуульд хамрагдалтын талаар авч үзсэн.

6.1. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн өрхийн нийгэм, эдийн засгийн байдал

Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн арван хүүхэд тутмын хоёр нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрхөд, мөн хоёр хүүхдийн нэг нь 5-6 ам бүлтэй өрхөд амьдарч байна.

Хүснэгт 6.1. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, өрхийн тэргүүлэгчийн хүйс, ам бүлийн тоогоор

Байршил, бүс, аймаг	Өрхийн тэргүүлэгчээр		Ам бүлийн тоо					Бүгд
	Эрэгтэй	Эмэгтэй	< 3	3 - 4	5 - 6	7 - 8	9 +	
Хот	45018	15726	2632	19879	30200	7061	972	60744
Хөдөө	70672	7109	1366	16433	46304	12009	1669	77781
Баруун бүс	37097	3422	447	7356	22954	8302	1460	40519
Хангайн бүс	25053	4037	1292	7556	16739	3200	303	29090
Төвийн бүс	14913	2726	402	4320	11315	1411	191	17639
Зүүн бүс	9486	2124	579	3665	5874	1276	216	11610
Улаанбаатар	29141	10526	1278	13415	19622	4881	471	39667
Бүгд	115690	22835	3998	36312	76504	19070	2641	138525

Зураг 6.1. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, өрхийн тэргүүлэгч, ам бүлээр




Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин буюу нийт 5-17 насны хүүхдэд хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн эзлэх хувийг авч үзэхэд, эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхөд амьдардаг хүүхдүүдийн 14.1 хувь нь, эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхөд амьдардаг хүүхдүүдийн 16.8 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. Харин ам бүлийн хувьд 7-8 ам бүлтэй өрхөд амьдардаг хүүхдүүдийн 21.4 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа нь ам бүлийн тооны хувьд хамгийн өндөр хувийг эзэлж байна.


Хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн хувьд, өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин буурах тусам хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 10.2 хувиас 33.2 хувь болж өссөн байна.

Өрхийн усан хангамжийн хувьд төвлөрсөн усан хангамжтай өрхийн хүүхдүүд хамгийн бага хөдөлмөр эрхэлсэн байгаа бол бусад төрөлд 17.0-49.4 хувь нь хөдөлмөр эрхэлсэн байна. Мөн өрхийн сууцны төрлөөр, орон сууцны байшинд эсвэл бие даасан тохилог сууцад амьдардаг өрхийн хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэлт 1.3-2.0 хувь байгаа бол бусад сууцны төрөлд 11.7-29.9 хувь байна.

Зураг 6.2. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшнээр, аав, ээжтэйгээ амьдардаг эсэхээр



Зураг 6.3. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, өрхийн сууц, усан хангамжийн төрлөөр



Өрхийн сарын дундаж орлогын хувьд, сард 1400.0 мянган төгрөгөөс дээш орлоготой өрхийн хүүхдүүдийн 9.1 хувь, 800.1-1400.0 мянга болон 140.0 мянга хүртэлх төгрөгийн орлоготой өрхийн хүүхдүүдийн 16.2-17.7 хувь, 140.1-600.0 мянган төгрөгийн орлоготой өрхийн хүүхдүүдийн 25.1-28.0 хувь нь хөдөлмөр эрхэлсэн байна.

Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн 22.3 хувийнх нь өрхийнх нь орлого сүүлийн 12 сарын хугацаанд буурсан байна. Байршлаар авч үзэхэд хот, суурин газарт 26.8 хувь, хөдөөд 18.7 хувь байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшний хувьд, байгалийн хүчин зүйлээс үүдэн хямрал үүссэн өрхийн хүүхдүүдийн 23.4 хувь нь хөдөлмөр эрхэлсэн бол нийгэм, эдийн засгийн хүчин зүйлээс үүдэн хямрал үүссэн өрхийн хүүхдүүдийн 21.0 хувь, өрхийн аль нэг гишүүн нь өвдсөн өрхийн хүүхдүүдийн 12.1 хувь нь хөдөлмөр эрхэлсэн байна.

Зураг 6.4. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин




6.2. Хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн сургуульд хамрагдалт

Энэхүү тайланд хүүхдийн сургуульд хамрагдалтыг Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 “Монгол Улсын иргэн суурь боловсрол заавал эзэмших үүрэгтэй” гэж заасны дагуу 6-14 насны хүүхдийг онцлон авч үзсэн.

Судалгаагаар 6-14 настай хүүхдүүдийн 96.6 хувь нь сургуульд хамрагдсан, 3.4 хувь нь сургуульд хамрагдаагүй байна. Насаар авч үзэхэд, 6 настай хүүхдүүдийн сургууль хамрагдалт нэлээн бага байгаа нь судалгаа авах тухайн хугацаанд хүүхэд 6 нас хүрсэн ч хичээлийн шинэ жил эхлээгүй байх талтай. Нөгөөтээгүүр Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллээр, нэгдүгээр ангид элсэгчдийн цэвэр жин 2020 онд 97.0 хувь, 2021 онд 94.7 хувь, 2022 онд 91.6 хувь бол буурсан байна.


Хөдөлмөр эрхэлсэн, эрхлээгүй хүүхдүүдийн сургуульд хамрагдалтыг хүйсээр авч үзэхэд, 6 настай охидын хувьд хөдөлмөр эрхэлсэн, эрхлээгүй хүүхдүүдийн сургуульд хамрагдалт 16.7 нэгж хувийн зөрүүтэй байгаа нь хамгийн их ялгаатай байгаа бол хөвгүүдийнх 2.3 нэгж хувийн зөрүүтэй байна.

Зураг 6.5. Сургуульд хамрагдалтын хувь, хүйсээр, насаар




6-14 насны хүүхдүүдийн 111.6 мянга буюу 17.3 хувь нь хөдөлмөр эрхэлсэн байна. Эдгээр хүүхдийн сургуульд хамрагдалтыг эрхэлж буй ажлын хэлбэрээр нь авч үзэхэд өөрийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлсэн охидын 96.6 хувь нь, бусад ажлын хэлбэрт бүх охид суралцсан бол хөвгүүдийн хувьд бүх ажлын хэлбэрт 95.4-97.3 хувь нь суралцсан байна.

Зураг 6.6. Сургуульд хамрагдалтын хувь, эрхэлж буй ажлын хэлбэрээр, хүйс, байршлаар



Нийт хөдөлмөр эрхэлж байгаа 6-14 насны хүүхдийн 1.5 мянга буюу 1.3 хувь нь өмнөх хичээлийн жилд суралцаагүй байна. Эдгээр суралцаагүй хүүхдүүдийн шалтгааныг тодруулахад таван хүүхэд тутмын гурав нь сургууль хол, арван хүүхэд тутмын нэг нь мал маллахаар гэж хариулсан байна.

Зураг 6.7. Өмнөх хичээлийн жилд суралцаагүй шалтгаан




БҮЛЭГ VII. ХҮҮХДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГ ХАНДЛАГА, НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Энэ бүлэгт хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагааны динамик өөрчлөлт болон хүүхдийн хөдөлмөр, аюултай ажил эрхлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлийн талаар тусгасан.


Энэ удаагийн Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа нь өмнөх онуудын судалгаануудаас өөр, шинэ аргачлал, ойлголт, тодорхойлолт ашигласан тул мэдээллийн харьцуулахуйц байх чанар алдагдаж, хүүхдийн хөдөлмөртэй тэмцэхэд чиглэсэн үйл ажиллагааны үр нөлөөнд дүгнэлт өгөх боломжгүй юм. Иймээс чиг хандлагыг зөвхөн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох хандлагыг тусгасан болно.

Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдүүдийг судалгаа явуулсан оноор харьцуулахад, 2002-2003 онд 5-17 насны хүүхдийн 10.1 хувь, 2006-2007 онд 11.5 хувь, 2011-2012 онд 16.0 хувь байсан бол энэ удаагийн судалгаагаар 24.4 хувь болж өссөн байна. Уг өсөлтийг насны бүлгээр авч үзэхэд, 10-17 насанд өндөр өссөн нь нөлөөлжээ. Тухайлбал, өмнөх онуудад 10-14 насанд 7.3-18.0 хувьтай байсан бол энэ удаагийн судалгаагаар 32.2 хувь, 15-17 насанд 16.1-22.3 хувь байсан бол 43.5 хувь бол өссөн байна.

Зураг 7.1. Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа, нийт хүүхдэд эзлэх хувиар, судалгаа явуулсан оноор



Зураг 7.2. Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, судалгаа явуулсан оноор



Хүснэгт 7.1. Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа, судалгаа явуулсан оноор

		2002-2003	2006-2007	2011-2012	2021-2022
Бүгд	Бүгд	68580	71330	93968	207951
	5-9	15320	18116	17677	41918
	10-14	21407	25016	42569	105932
	15-17	31853	28198	33722	60101
Хөвгүүд	Бүгд	41874	43037	50870	126141
	5-9	9005	10332	9648	25425
	10-14	13762	14929	22653	63350
	15-17	19107	17776	18569	37366
Охид	Бүгд	26706	28293	43098	81810
	5-9	6315	7784	8029	16493
	10-14	7645	10087	19916	42582
	15-17	12746	10422	15153	22735

Энэ хэсэгт хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, аюултай хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлийн шинжилгээг хийж хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлөх өрхийн болон хувь хүний хүчин зүйлийг тодорхойлохыг зорьсон. Хүүхдийн хөдөлмөрт эдийн засаг, нийгмийн өргөн хүрээтэй макро хүчин зүйлүүд нөлөөлөх боловч түүнээс илүүтэй тухайн гэр бүлийн орчин дах микро хүчин зүйлс хэрхэн нөлөөлдөг бас сонирхол татсан асуудал юм. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг бууруулах бодлого, хөтөлбөр боловсруулахад хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй макро болон микро хүчин зүйлсийг оновчтой тодорхойлох нь чухал үүрэгтэй. Бид стэпвайс ложистик регрессийн шинжилгээний арга зүйг ашиглаж микро хүчин зүйлийн нөлөөллийг энэ хэсэгт тооцсон. Тус стэпвайс арга зүйн онцлогоос хамааран хувьсагчид нөлөөтэй гэж сонгож авсан тайлбарлагч хувьсагчдыг статистик ач холбогдлын түвшнээр ялгаж ач холбогдолтой хувьсагчдыг авч үлдэхэд оршдог. Хүүхдийн хөдөлмөр нь хамааран хувьсагч бөгөөд өрхийн амьжиргаа, сууцны нөхцөл, өрхийн тэргүүлэгчийн болон хүүхдийн хувь хүний хүчин зүйлсийг тайлбарлагч хувьсагчаар сонгож загварт ашигласан. Хүүхдийн хөдөлмөрт нөлөөлөх тайлбарлагч хувьсагчдыг сонгохдоо судалгаа шинжилгээний үр дүн болон практикаар хүүхдийн хөдөлмөрт нөлөөлдөг гэж үздэг хүчин зүйлсийг сонгосон.

Хүснэгт 7.2. Ложистик регрессийн шинжилгээнд ашигласан хувьсагч, түүний тайлбар

№	Хувьсагч	Тайлбар	Төрөл
1	childlab	ОУХБ-ын аргачлалаар тодорхойлсон 5-17 насны хүүхдийн хөдөлмөр эрхэлдэг эсэх (Хүүхдийн хөдөлмөр эрхэлдэг бол 1, эрхэлдэггүй бол 0)	Дамми
2	age	Хүүхдийн бүтэн нас	Тоо
3	age2	Хүүхдийн бүтэн насны квадрат	Тоо
4	male	Хүүхдийн хүйс (Эрэгтэй бол 1, эмэгтэй бол 0)	Дамми
5	rural	Хүүхдийн суурьшил (Хөдөө бол 1, хот бол 0)	Дамми
6	dwel	Хүүхдийн амьдардаг сууцны төрөл (гэр, сууцны тусдаа байшин, нийтийн байр, бусад сууцад амьдардаг бол 1, бие даасан тохилог сууц, орон сууцад амьдардаг бол 0)	Дамми
7	loan	Хүүхдийн амьдардаг өрх зээлтэй эсэх (Зээлтэй бол 1, зээлгүй бол 0)	Дамми
8	disab	Хүүхэд хөдөлмөрийн бэрхшээлтэй эсэх (Хөгжлийн бэрхшээлтэй бол 1, хөгжлийн бэрхшээлгүй бол 0)	Дамми
9	hhhead_gender	Өрхийн тэргүүлэгчийн хүйс эмэгтэй бол 1, эрэгтэй бол 0	Дамми
10	head_edu_high	Өрхийн тэргүүлэгчийн боловсролд түвшин дипломын дээд болон түүнээс дээш бол 1, доош бол 0	Дамми
11	withparents	Эцэг, эхтэйгээ хоёртойгоо нь амьдардаг эсэх (Хоёуланттай нь амьдардаг бол 1, аль нэгэнтэй болон алинтайн ч амьдардаггүй бол 0)	Дамми
12	hsize	Өрхийн хамт амьдардаг ам бүлийн тоо	Тоо
13	sifund	Сүүлийн 12 сарын хугацаанд тухайн өрхөөс аль нэг хүн нь Нийгмийн даатгалын сангаас орлого олсон эсэх (олсон бол 1 олоогүй бол 0)	Дамми
14	swfund	Сүүлийн 12 сарын хугацаанд тухайн өрхөөс аль нэг хүн нь Нийгмийн халамжийн сангаас хүүхдийн мөнгөнөөс бусад орлого олсон эсэх (олсон бол 1 олоогүй бол 0)	Дамми
15	lsfund	Сүүлийн 12 сарын хугацаанд тухайн өрхөөс аль нэг хүн нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас орлого олсон эсэх (олсон бол 1 олоогүй бол 0)	Дамми
16	dec_inc	Сүүлийн 12 сард тухайн өрхийн орлого буурсан эсэх (буурсан бол 1, өссөн болон өөрчлөгдөөгүй бол 0)	Дамми
17	quarter1	1 дүгээр улирал эсэх (1 дүгээр улирал бол 1, бусад улирал бол 0)	Дамми
18	quarter2	2 дугаар улирал эсэх (2 дугаар улирал бол 1, бусад улирал бол 0)	Дамми
19	Quarter3	3 дугаар улирал эсэх (3 дугаар улирал бол 1, бусад улирал бол 0)	Дамми
20	Income1	Өрхийн орлогын тэнцүү таван бүлгийн 1 дүгээр хэсэгт багтсан эсэх (Багтсан бол 1, бусад бол 0)	Дамми
21	Income2	Өрхийн орлогын тэнцүү таван бүлгийн 2 дугаар хэсэгт багтсан эсэх (Багтсан бол 1, бусад бол 0)	Дамми
22	Income3	Өрхийн орлогын тэнцүү таван бүлгийн 3 дугаар хэсэгт багтсан эсэх (Багтсан бол 1, бусад бол 0)	Дамми
23	Income4	Өрхийн орлогын тэнцүү таван бүлгийн 4 дүгээр хэсэгт багтсан эсэх (Багтсан бол 1, бусад бол 0)	Дамми

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлсөн хүчин зүйлийг дээрх хувьсагчдаар үнэлэхэд хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэд хүүхдийн нас нэмэгдэх (нас нэмэгдэхэд ахиу хандлага буурах), эрэгтэй, хөдөө амьдардаг, гэр, сууцны тусдаа байшин, нийтийн байр, бусад сууцад амьдардаг, хүүхдийн өрх нь зээлтэй, өрхийн аль нэг гишүүн нь сүүлийн 12 сард хүүхдийн мөнгөнөөс бусад халамжийн орлого олсон, сүүлийн 12 сард өрхийн орлого буурсан зэрэг хүчин зүйлс нь хүүхдийн хөдөлмөрийг статистик ач холбогдол бүхий нэмэгдүүлж байна. Мөн 1, 2, 3 дугаар улиралд аль аль нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлт статистик ач холбогдол нэмэгдүүлэх нөлөөтэй байгаа бөгөөд энэ нь 1-3 улирал руу өсөх хандлагатай байна. Харин тухайн хүүхэд өрхийн орлогын 4 бүлэгт буюу өрхийн орлогоор нь 5 тэнцүү бүлэг хуваасны 4 дөх өндөр орлоготой өрхөд амьдарч байвал хүүхдийн хөдөлмөр эрхлэх магадлал буурах хандлагатай байна. Бусад сонгож авсан тайлбарлагч хувьсагчдын хувьд хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэд статистик ач холбогдол бүхий нөлөөгүй байна.

Хүснэгт 7.3. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлсөн хүчин зүйлсийн стэпвайс ложистик регрессийн шинжилгээний маржинал эффект

Тайлбарлагч хувьсагч	Маржинал эффект	Стандарт алдаа	z	Р утга	95 хувийн итгэх интервал	
					Доод	Дээд
age	0.109	0.006	19.48	0.000	0.098	0.120
age2	-0.005	0.000	-17.50	0.000	-0.005	-0.004
male	0.071	0.005	13.56	0.000	0.061	0.082
rural	0.096	0.006	17.09	0.000	0.085	0.107
dwell	0.298	0.015	19.68	0.000	0.269	0.328
loan	0.010	0.006	1.73	0.084	-0.001	0.021
income4	-0.028	0.008	-3.60	0.000	-0.043	-0.013
quarter2	0.071	0.009	8.34	0.000	0.054	0.088
quarter3	0.119	0.008	15.15	0.000	0.104	0.135
swfund	0.028	0.005	5.14	0.000	0.017	0.038
quarter1	0.024	0.009	2.70	0.007	0.007	0.041
dec_inc	0.036	0.007	5.05	0.000	0.022	0.050

Стэпвайс ложистик регрессийн шинжилгээг хүүхдийн хөдөлмөр дотроо аюултай хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн хөдөлмөрт хэрхэн нөлөөлж буй шинжилж үзэхэд ихэнх хувьсагчид ижил байгаа боловч статистик ач холбогдолтой зарим хувьсагчид нэмэгдсэн байна. Тодруулбал хүүхдийн аюултай хөдөлмөр эрхлэлтийг бууруулах магадлалтай хувьсагч нэмэгдсэн байна. Тухайн хүүхдийн амьдарч буй өрхийн тэргүүлэгч нь эмэгтэй, тухайн өрх нь нийгмийн даатгалын сангаас сүүлийн 12 сард орлого олсон байх нь хүүхдийн аюултай хөдөлмөр эрхлэлтийг бууруулагч хүчин зүйл болж байна. Бусад хүчин зүйлийн хувьд хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлсөн хүчин зүйлтэй ижил хандлагатай байна. Бусад сонгож авсан тайлбарлагч хувьсагчдын хувьд хүүхдийн аюултай хөдөлмөр эрхлэлтэд статистик ач холбогдол бүхий нөлөөгүй байна.

Хүснэгт 7.4. Хүүхдийн аюултай хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлсөн хүчин зүйлсийн стэпвайс ложистик регрессийн шинжилгээний маржинал эффект

Тайлбарлагч хувьсагч	Маржинал эффект	Стандарт алдаа	z	Р утга	95 хувийн итгэх интервал	
					Доод	Дээд
age	0.033	0.004	7.96	0.000	0.025	0.042
age2	-0.001	0.000	-4.52	0.000	-0.001	0.000
male	0.045	0.004	11.97	0.000	0.038	0.052
rural	0.069	0.004	16.59	0.000	0.061	0.077
Dwell	0.106	0.010	10.18	0.000	0.086	0.126

Тайлбарлагч хувьсагч	Маржинал эффект	Стандарт алдаа	z	Р утга	95 хувийн итгэх интервал	
					Доод	Дээд
loan	0.012	0.004	3.10	0.002	0.005	0.020
hhhead_gender	-0.014	0.008	-1.89	0.059	-0.029	0.001
income4	-0.012	0.006	-2.01	0.045	-0.023	0.000
withparents	-0.012	0.007	-1.68	0.093	-0.025	0.002
sifund	-0.010	0.005	-2.14	0.032	-0.019	-0.001
swfund	0.020	0.004	5.36	0.000	0.012	0.027
quarter3	0.051	0.004	12.53	0.000	0.043	0.059
income1	0.015	0.004	3.64	0.000	0.007	0.022
dec_inc	0.033	0.005	6.96	0.000	0.023	0.042
quarter2	0.019	0.005	4.16	0.000	0.010	0.028

Шинжилгээний үр дүн дараах байдлаар тайлбарлагдаж байна. Үүнд:

- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйлс:
 - Тухайн хүүхдийн нас нэмэгдэх нь хөдөлмөр эрхлэх магадлалыг нэмэгдүүлдэг боловч нас нэмэгдэх тусам хөдөлмөр эрхлэх ахиу хандлага буурдаг
 - Эрэгтэй хүүхэд эмэгтэй хүүхдээс хөдөлмөр эрхлэх магадлал өндөр
 - Хөдөө амьдарч байгаа хүүхэд хотод амьдарч байгаа хүүхдээс хөдөлмөр эрхлэх магадлал өндөр
 - Гэр, сууцны тусдаа байшин, нийтийн байр, бусад сууцад амьдардаг хүүхэд, бие даасан тохилог сууц, орон сууцад амьдардаг хүүхдээс хөдөлмөр эрхлэх магадлал өндөр
 - Зээлтэй өрхөд амьдарч байгаа хүүхэд зээлгүй өрхөд амьдарч буй хүүхдээс хөдөлмөр эрхлэх магадлал өндөр
 - 1, 2, 3 дугаар улиралд аль аль нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлт статистик ач холбогдол нэмэгдүүлэх нөлөөтэй байгаа бөгөөд энэ нь 1-3 улирал руу өсөх хандлагатай
 - Сүүлийн 12 сард хүүхдийн мөнгөнөөс бусад нийгмийн даатгалын сангаас орлого олсон өрхөд амьдарч буй хүүхэд, тус орлогыг олоогүй өрхөд амьдарч байгаа хүүхдээс хөдөлмөр эрхлэх магадлал өндөр
 - Сүүлийн 12 сард өрхийн орлого буурсан гэж мэдэгдсэн өрхөд амьдарч буй хүүхэд, орлого өссөн, өөрчлөгдөөгүй гэж хариулсан өрхөд амьдарч байгаа хүүхдээс хөдөлмөр эрхлэх магадлал өндөр байна.
- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг бууруулахад нөлөөлж буй хүчин зүйл
 - Өрхийн орлогын тэнцүү таван бүлэг хуваасны 4 дүгээр өндөр орлоготой өрхөд амьдарч буй хүүхэд, бусад бүлэгт амьдарч буй хүүхдээс хөдөлмөр эрхлэх магадлал бага байна.
- Хүүхдийн аюултай хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйл
 - Хүүхдийн аюултай хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэгч хүчин зүйлс нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлтэй ижил хандлагатай байна.
- Хүүхдийн аюултай хөдөлмөр эрхлэлтийг бууруулахад нөлөөлж буй хүчин зүйл
 - Тухайн хүүхдийн амьдарч буй өрхийн тэргүүлэгч нь эмэгтэй бол эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхөд амьдарч буй хүүхдээс аюултай хөдөлмөр эрхлэх магадлал бага
 - Сүүлийн 12 сард нийгмийн даатгалын сангаас орлого олсон өрхөд амьдарч байгаа хүүхэд, тус сангаас орлого олоогүй өрхөд амьдарч байгаа хүүхдээс аюултай хөдөлмөр эрхлэх магадлал бага байна.


БҮЛЭГ VIII. ХҮҮХДИЙН ӨРХИЙН ЦАЛИН ХӨЛСГҮЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРИЙН АЖИЛ, ЧӨЛӨӨТ ЦАГ

Энэ бүлэгт хүүхдийн хийж байгаа гэрийн ажлын талаарх үр дүнг танилцуулсан. Гэрийн ажлыг өөрийн эцсийн хэрэглээнд зориулан гэртээ хийдэг төлбөргүй үйлчилгээний ажлын хүрээнд тодорхойлсон. Гэрийн ажил нь ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээнээс гадуурх, харин үйлдвэрлэлийн ерөнхий хүрээнд багтдаг.

8.1. Гэрийн ажлын оролцоо

Улсын хэмжээнд 5-17 насны нийт хүүхдийн 618.0 мянга буюу 72.5 хувь нь гэрийн ажилд оролцсон байна. Хүйсийн хувьд охидын оролцоо, хөвгүүдийнхээс 7.5 нэгж хувиар илүү байгаа бол байршлын хувьд ялгаа ажиглагдахгүй байна. Харин бүсээр авч үзэхэд, Баруун бүсэд 74.5 хувь, Хангайн бүсэд 76.0 хувь, Төвийн бүсэд 69.3 хувь, Зүүн бүсэд 68.3 хувь, Улаанбаатарт 72.2 хувь байна.

Зураг 8.1. Гэрийн ажил эрхэлсэн хүүхэд, нийт хүүхдэд эзлэх хувиар



Гэрийн зарим ажил нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй байдаг тул аюултай байж болзошгүй гэр орны ажилд оролцож байгаа хүүхдийн мэдээллийг энэ хэсэгт тусгасан. Ингэхдээ дараах шалгуурын дагуу тооцоолсон. Үүнд:

- Долоо хоногт 21 болон түүнээс дээш цагийг гэрийн ажилд зарцуулсан. Энэ шалгуурыг 5-14 насны хүүхдийн хувьд тооцсон. Хүүхэд гэрийн ажилд хэт их цагаар оролцох нь тухайн хүүхдийн сургуульд явах, гэрийн даалгавраа хийх, сурч боловсрох боломж нь хязгаарлагдаж, сөргөөр нөлөөлнө гэж үздэг.
- Аюултай нөхцөл. Аюултай байж болзошгүй гэрийн ажлын ямар ч хэлбэр (Зураг 8.4) нь анхаарах асуудлуудыг нэг юм.

Хүснэгт 8.1. Гэрийн ажил эрхэлсэн, аюултай байж болзошгүй гэрийн ажил эрхэлсэн хүүхэд, хүйсээр, насны бүлэг, байршлаар

	Гэрийн ажил эрхэлсэн хүүхэд			Аюултай байж болзошгүй гэрийн ажил эрхэлсэн хүүхэд		
	Бүгд	Хөвгүүд	Охид	Бүгд	Хөвгүүд	Охид
Бүгд	617998	300584	317414	316943	138942	178001
5 - 12 нас	378163	181205	196958	130504	54513	75991
13 - 14 нас	113419	56504	56915	82822	37365	45457
15 - 17 нас	126416	62875	63541	103617	47064	56553
Хот	428651	209153	219498	210866	94407	116459
Хөдөө	189347	91431	97916	106077	44535	61542


Нийт 5-17 насны хүүхдэд гэрийн ажилд оролцож байгаа хүүхдийн эзлэх хувийг оролцсон үйл ажиллагаа тус бүрээр нь дараах зурагт харууллаа. 5-17 насны таван хүүхэд тутмын бараг дөрөв нь гэрээ цэвэрлэж, сав суулга угаасан, мөн гурав нь гэрийнхэндээ зориулж хоол унд хийж, бэлтгэн, тусалсан байна. Хүйсийн хувьд, гэрийнхэндээ зориулж хоол унд хийж, бэлтгэн, тусалсан, гэрийнхнийхээ хувцсыг угааж, угаалгын ажилд тусалсан, гэрээ цэвэрлэх, сав суулга угаах үйл ажиллагааг хийсэн охид хөвгүүдээс их буюу тэдний нийт охидын дүнд эзлэх хувь нь хөвгүүдийнхээс 10.4-14.1 нэгж хувиар их байна.

Зураг 8.2. Гэрийн ажил эрхэлсэн хүүхэд, үйл ажиллагаагаар, хүйсээр, хувиар



Судалгаагаар 5-17 насны нийт хүүхдийн 37.4 хувь нь аюултай нөхцөлд гэрийн ажил хийсэн бол 5-14 насны нийт хүүхдийн 37.4 хувь нь хэт их цагаар буюу долоо хоногт 21 болон түүнээс дээш цагаар гэрийн ажил хийсэн байна. Аюултай байж болзошгүй нөхцөлүүд аль аль нь нас нэмэгдэх тусам ихсэж байгаа бол хүйсийн хувьд охид хөвгүүдээс их, байршлын хувьд хөдөө амьдарч буй хүүхдүүд хот, суурин газар амьдарч буй хүүхдүүдээс илүү аюултай байж болзошгүй өөрийн эцсийн хэрэглээний үйлчилгээний гэрийн ажилд оролцсон байна.

Зураг 8.3. Хүүхдийн аюултай байж болзошгүй гэрийн ажил эрхлэлтийн түвшин, хүйс, нас, байршлаар



Аюултай нөхцөл бүхий гэрийн ажлыг Зураг 8.4-т тусгагдсан ОУХБ-ын зөвлөмжийн дагуу үйл ажиллагааны хүрээнд тодорхойлсон бөгөөд Зураг 8.3-т 5-17 насны гэрийн ажил хийсэн нийт хүүхдэд аюултай нөхцөл бүхий гэрийн ажилд оролцсон хүүхдийн эзлэх хувийн жинг харууллаа.

Зураг 8.4. Аюултай нөхцөлд гэрийн ажил эрхэлсэн хүүхэд, нийт гэрийн ажил эрхэлсэн хүүхдэд эзлэх хувиар, ажлын төрлөөр



Хүүхдүүд гэрийн ажилд долоо хоногт дунджаар 14 цаг зарцуулсан байна. Гэрийн ажилд охидын оролцоо их байгаа ба тэдний долоо хоногт зарцуулсан дундаж цаг нь 13 цаг байгаа нь хөвгүүдийнхээс 2 цагаар илүү байна. Хийсэн үйл ажиллагааны төрлөөр авч үзэхэд, хүүхдүүд дүү, хөгшид эсвэл гэр бүлийн аль нэгэн өвчтэй байгаа гишүүнийг асрах зэрэг гэр бүлийн гишүүдийг асрах ажилд хамгийн их цагийг буюу долоо хоногт дунджаар 8 цаг зарцуулсан бол гэр цэвэрлэх, хоол хийх ажилд аль алинд нь дунджаар 5 цаг зарцуулсан байна.

Зураг 8.5. Гэрийн ажилд зарцуулсан дундаж цаг, үйл ажиллагаагаар



8.2. Гэрийн ажилд оролцож буй хүүхдийн хөдөлмөр эрхлэлт

Энэ хэсэгт долоо хоногт багагүй хугацааг гэрийн ажилд зарцуулдаг хүүхдүүдийн хэд нь хөдөлмөр эрхэлсэн байгааг болон тэдний ажлын цагийг харуулахыг зорьсон.


Гэрийн ажил эрхэлсэн 5-17 насны 618.0 мянган хүүхдийн 118.9 мянга буюу 19.2 хувь нь хөдөлмөр эрхэлсэн байна.

Хүснэгт 8.2. Гэрийн ажил хийсэн хүүхэд, хөдөлмөр эрхэлсэн байдал

	Хөдөлмөр эрхэлдэг			Хөдөлмөр эрхэлдэггүй		
	Бүгд	Хөвгүүд	Охид	Бүгд	Хөвгүүд	Охид
Бүгд	118898	70403	48495	499100	230181	268919
5 - 12 нас	83498	47421	36077	294665	133784	160881
13 - 14 нас	14046	8377	5669	99373	48127	51246
15 - 17 нас	21354	14605	6749	105062	48270	56792
Хот	54441	34550	19891	374210	174603	199607
Хөдөө	64457	35853	28604	124890	55578	69312


Хүйсийн хувьд өөрийн эцсийн хэрэглээний үйлчилгээний гэрийн ажил хийсэн хөвгүүдийн 23.4 хувь нь хөдөлмөр эрхэлсэн байгаа нь охидынхоос 8.1 нэгж хувиар их байна. Харин байршлын хувьд хөдөөд гэрийн ажил хийхийг зэрэгцээ хөдөлмөр эрхэлсэн хүүхэд их байна.

Зураг 8.6. Гэрийн ажил хийсэн хүүхэд, хөдөлмөр эрхэлсэн эсэхээр, дүнд эзлэх хувиар



Хөдөлмөр эрхлэлт болон гэрийн ажилд аль алинд нь оролцсон хүүхдүүдийн уг хоёр үйл ажиллагаанд зарцуулсан нийт цагийн хувьд, долоо хоногт дунджаар 21 цаг зарцуулсан бол хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн зөвхөн гэрийн ажилд 14 цаг зарцуулсан байна. Харин хөдөлмөр эрхэлдэггүй хүүхдүүд гэрийн ажилд долоо хоногт дунджаар 13 цаг зарцуулсан байна.

Зураг 8.7. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт болон гэрийн ажил хийхэд зарцуулсан дундаж цаг



Хавсралт – 1 Статистик хүснэгт

1.1. Хүүхдийн хөдөлмөрийн стандарт алдаа ба итгэмжлэлт интервалууд

Хүснэгт 1. Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа, хүйсээр

Хүйс	Утга	Стандарт алдаа	Вариацийн коэффициент	95 хувийн итгэх интервал	
				Доод	Дээд
Эрэгтэй	0.289	0.010	0.033	0.270	0.308
Эмэгтэй	0.197	0.007	0.036	0.183	0.211
Нийт	0.244	0.008	0.031	0.229	0.259
Түүврийн хэмжээ	23,876				

Хүснэгт 2. Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа, байршлаар

Байршил	Утга	Стандарт алдаа	Вариацийн коэффициент	95 хувийн итгэх интервал	
				Доод	Дээд
Нийслэл	0.173	0.009	0.052	0.156	0.191
Аймгийн төв	0.188	0.016	0.085	0.157	0.220
Тосгон	0.230	0.031	0.135	0.169	0.290
Сумын төв	0.302	0.032	0.106	0.240	0.365
Хөдөө	0.453	0.019	0.042	0.416	0.491
Нийт	0.244	0.008	0.031	0.229	0.259
Түүврийн хэмжээ	23,876				

Хүснэгт 3. Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа, бүсээр

Бүс	Утга	Стандарт алдаа	Вариацийн коэффициент	95 хувийн итгэх интервал	
				Доод	Дээд
Баруун бүс	0.487	0.027	0.056	0.433	0.540
Хангайн бүс	0.277	0.020	0.071	0.238	0.316
Төвийн бүс	0.203	0.023	0.111	0.158	0.247
Зүүн бүс	0.269	0.028	0.104	0.214	0.324
Улаанбаатар	0.173	0.009	0.052	0.156	0.191
Нийт	0.244	0.008	0.031	0.229	0.259
Түүврийн хэмжээ	23,876				

Хүснэгт 4. Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	Утга	Стандарт алдаа	Вариацийн коэффициент	95 хувийн итгэх интервал	
				Доод	Дээд
Улаанбаатар	0.173	0.009	0.052	0.156	0.191
Дорнод	0.274	0.046	0.166	0.185	0.364
Сүхбаатар	0.238	0.059	0.246	0.123	0.353
Хэнтий	0.288	0.043	0.147	0.205	0.372
Төв	0.213	0.038	0.181	0.137	0.288
Говьсүмбэр	0.008	0.007	0.947	-0.007	0.022
Сэлэнгэ	0.349	0.046	0.133	0.258	0.440
Дорноговь	0.214	0.082	0.380	0.054	0.374
Дархан-Уул	0.070	0.021	0.305	0.028	0.112
Өмнөговь	0.125	0.030	0.244	0.065	0.184
Дундговь	0.334	0.041	0.121	0.254	0.413
Орхон	0.248	0.070	0.282	0.111	0.385
Өвөрхангай	0.427	0.031	0.072	0.366	0.487
Булган	0.332	0.069	0.208	0.196	0.467
Баянхонгор	0.275	0.043	0.156	0.191	0.359
Архангай	0.302	0.041	0.137	0.221	0.383
Хөвсгөл	0.132	0.026	0.195	0.081	0.183
Завхан	0.398	0.070	0.176	0.260	0.535
Говь-Алтай	0.552	0.071	0.129	0.413	0.692
Баян-Өлгий	0.513	0.058	0.113	0.399	0.627
Ховд	0.550	0.050	0.091	0.452	0.648
Увс	0.415	0.054	0.129	0.310	0.521
Нийт	0.244	0.008	0.031	0.229	0.259
Түүврийн хэмжээ	23,876				

Хүснэгт 5. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, хүйсээр

Хүйс	Утга	Стандарт алдаа	Вариацийн коэффициент	95 хувийн итгэх интервал	
				Доод	Дээд
Эрэгтэй	0.199	0.008	0.039	0.184	0.214
Эмэгтэй	0.125	0.006	0.045	0.114	0.136
Нийт	0.163	0.006	0.037	0.151	0.174
Түүврийн хэмжээ	23,876				

Хүснэгт 6. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, байршлаар

Байршил	Утга	Стандарт алдаа	Вариацийн коэффициент	95 хувийн итгэх интервал	
				Доод	Дээд
Нийслэл	0.100	0.006	0.064	0.087	0.112
Аймгийн төв	0.107	0.011	0.101	0.086	0.128
Тосгон	0.186	0.021	0.113	0.144	0.227
Сумын төв	0.212	0.025	0.120	0.162	0.262
Хөдөө	0.357	0.018	0.049	0.322	0.391
Нийт	0.163	0.006	0.038	0.151	0.175
Түүврийн хэмжээ	23,876				

Хүснэгт 7. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, бүсээр

Бүс	Утга	Стандарт алдаа	Вариацийн коэффициент	95 хувийн итгэх интервал	
				Доод	Дээд
Баруун бүс	0.363	0.026	0.070	0.313	0.414
Хангайн бүс	0.189	0.015	0.079	0.160	0.219
Төвийн бүс	0.135	0.019	0.137	0.099	0.171
Зүүн бүс	0.201	0.024	0.120	0.154	0.249
Улаанбаатар	0.100	0.006	0.064	0.087	0.112
Нийт	0.163	0.006	0.038	0.151	0.175
Түүврийн хэмжээ	23,876				

Хүснэгт 8. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, аймгаар

Аймаг, нийслэл	Утга	Стандарт алдаа	Вариацийн коэффициент	95 хувийн итгэх интервал	
				Доод	Дээд
Улаанбаатар	0.100	0.006	0.064	0.087	0.112
Дорнод	0.222	0.041	0.186	0.141	0.303
Сүхбаатар	0.172	0.045	0.259	0.085	0.260
Хэнтий	0.202	0.040	0.198	0.124	0.281
Төв	0.129	0.034	0.266	0.062	0.196
Говьсүмбэр	0.000	0.000	-	0.000	0.000
Сэлэнгэ	0.264	0.043	0.162	0.180	0.347
Дорноговь	0.162	0.061	0.375	0.043	0.281
Дархан-Уул	0.039	0.015	0.388	0.009	0.069
Өмнөговь	0.052	0.021	0.399	0.011	0.093
Дундговь	0.213	0.048	0.228	0.118	0.308
Орхон	0.151	0.040	0.267	0.072	0.230
Өвөрхангай	0.255	0.031	0.122	0.194	0.316
Булган	0.257	0.062	0.242	0.135	0.379
Баянхонгор	0.201	0.039	0.194	0.124	0.278
Архангай	0.233	0.038	0.161	0.159	0.307
Хөвсгөл	0.095	0.023	0.239	0.051	0.140
Завхан	0.243	0.057	0.236	0.130	0.356
Говь-Алтай	0.423	0.070	0.165	0.286	0.560
Баян-Өлгий	0.431	0.059	0.138	0.314	0.547
Ховд	0.454	0.048	0.105	0.360	0.548
Увс	0.238	0.033	0.140	0.173	0.303
Нийт	0.163	0.006	0.038	0.151	0.175
Түүврийн хэмжээ	23,876				

1.2. Статистик хүснэгтүүд

Хүснэгт 9. 5-17 насны хүүхэд

		5-9 настай	10-12 настай	3-14 настай	15-17 настай	Бүгд (5-17 настай)
Бүгд		384838	204028	125359	138160	852385
Хүйс	Хөвгүүд	196429	103591	64570	71999	436590
	Охид	188409	100437	60788	66160	415795
Байршил	Хот	272361	143509	86634	90199	592703
	Хөвгүүд	137097	72526	44991	46573	301188
	Охид	135263	70983	41642	43626	291515
	Хөдөө	112478	60519	38725	47960	259682
	Хөвгүүд	59332	31065	19579	25426	135402
	Охид	53146	29454	19146	22534	124280
Бүс	Баруун бүс	46382	27611	17711	19807	111512
	Хангайн	67808	35246	22209	28470	153733
	Төвийн бүс	58681	29819	18964	23336	130800
	Зүүн бүс	26024	13282	8552	9843	57701
	Улаанбаатар	185943	98070	57923	56703	398639
Аймаг, нийслэл	Архангай	11195	5827	3148	4063	24233
	Баян-Өлгий	14068	6622	4150	5771	30611
	Баянхонгор	10362	5101	3302	4303	23068
	Булган	6583	3768	1928	2670	14949
	Говь-Алтай	6076	3654	2323	2387	14440
	Дорноговь	9240	2986	2363	3965	18554
	Дорнод	9295	5629	3468	3263	21656
	Дундговь	4669	3433	1594	1599	11295
	Завхан	7056	5022	3189	3313	18580
	Өвөрхангай	13338	6415	4881	5381	30015
	Өмнөговь	8390	4474	2326	3025	18215
	Сүхбаатар	7358	3637	2104	2912	16011
	Сэлэнгэ	11370	6364	3967	5474	27175
	Төв	10680	6076	3496	3629	23882
	Увс	8948	5836	4125	4283	23192
	Ховд	10233	6477	3925	4054	24689
	Хөвсгөл	15321	7640	5180	7279	35421
	Хэнтий	9372	4015	2979	3668	20034
	Дархан-Уул	12058	5425	4326	4872	26680
	Орхон	11009	6495	3769	4774	26047
	Говьсүмбэр	2272	1060	893	773	4999
	Улаанбаатар	185943	98070	57923	56703	398639

Хүснэгт 10. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, ангиллаар

Ангилал	5-9 настай	10-12 настай	3-14 настай	15-17 настай	Бүгд (5-17 настай)
Нийт 5-17 насны хүүхэд	384838	204028	125359	138160	852385
Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон	41918	57223	48710	60101	207951
Хүүхдийн хөдөлмөр эрхэлсэн	41918	57223	15882	23503	138525
Аюултай ажил эрхэлсэн	7275	13622	13833	23503	58233

Хүснэгт 11. 6-14 насны хүүхдийн сургуульд хамрагдалт

	Бүгд	Үйл ажиллагааны ангилал				(a)&(c) Нийт эдийн засгийн үйл ажиллагаанд оролцдог	(b)&(c) Нийт суралцдаг	(a)&(d) Нийт сургуулиас гадуурх
		(a) Зөвхөн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцдог	(b) Зөвхөн суралцдаг	(c) Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцдог болон суралцдаг	(d) Аль нь ч биш			
6-14 насны хүүхэд	644797	3871	472618	140544	27765	144414	613162	31635
Хөвгүүд	329640	2423	227240	84469	15509	86891	311708	17931
Охид	315157	1448	245378	56075	12256	57523	301453	13704
Хот	452850	934	358918	72336	20663	73270	431253	21597
Хөвгүүд	229976	552	171229	46084	12110	46636	217313	12663
Охид	222875	382	187688	26252	8552	26634	213940	8934
Хөдөө	191947	2936	113700	68208	7102	71144	181908	10038
Хөвгүүд	99664	1871	56010	38385	3398	40255	94395	5269
Охид	92282	1066	57690	29823	3704	30889	87513	4770

Хүснэгт 12. Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхэд

		5-9 настай	10-12 настай	3-14 настай	15-17 настай	Бүгд (5-17 настай)
Бүгд		41918	57223	48710	60101	207951
Хүйс	Хөвгүүд	25425	34605	28746	37366	126141
	Охид	16493	22618	19964	22735	81810
Байршил	Хот	17201	30227	26635	31672	105736
	Хөвгүүд	11830	19029	16280	19881	67020
	Охид	5371	11198	10355	11792	38716
	Хөдөө	24716	26995	22074	28429	102215
	Хөвгүүд	13595	15575	12465	17486	59121
	Охид	11121	11420	9609	10943	43093
Бүс	Баруун бүс	15387	14414	11166	13291	54258
	Хангайн	8034	10572	10493	13467	42567
	Төвийн бүс	4433	6858	5983	9215	26489
	Зүүн бүс	3153	4291	3917	4163	15523
	Улаанбаатар	10911	21087	17150	19965	69113
Аймаг, нийслэл	Архангай	1677	1935	1561	2140	7312
	Баян-Өлгий	4844	3658	3015	4175	15691
	Баянхонгор	973	1311	1588	2477	6349
	Булган	1082	1471	1200	1205	4957
	Говь-Алтай	2622	2053	1567	1734	7977
	Дорноговь	1352	947	646	1034	3979
	Дорнод	1258	1766	1555	1362	5940
	Дундговь	292	1478	881	1119	3770
	Завхан	1244	2267	1853	2021	7385
	Өвөрхангай	1975	3413	3638	3779	12805
	Өмнөговь	410	533	369	956	2267
	Сүхбаатар	1017	949	790	1052	3807
	Сэлэнгэ	1376	2056	2406	3649	9487
	Төв	671	1431	1224	1752	5078
	Увс	2797	2520	2183	2130	9630
	Ховд	3879	3916	2549	3231	13575
	Хөвсгөл	544	892	1212	2033	4681
	Хэнтий	878	1577	1571	1750	5776
	Дархан-Уул	332	414	458	667	1870
	Орхон	1785	1551	1293	1834	6463
	Говьсүмбэр	0	0	0	38	38
	Улаанбаатар	10911	21087	17150	19965	69113

Хүснэгт 13. Хүүхдийн хөдөлмөр

		5-9 настай	10-12 настай	3-14 настай	15-17 настай	Бүгд (5-17 настай)
Бүгд		41918	57223	15882	23503	138525
Хүйс	Хөвгүүд	25425	34605	9994	16701	86724
	Охид	16493	22618	5888	6802	51801
Байршил	Хот	17201	30227	4614	8701	60744
	Хөвгүүд	11830	19029	2878	6503	40241
	Охид	5371	11198	1736	2198	20503
	Хөдөө	24716	26995	11268	14801	77781
	Хөвгүүд	13595	15575	7116	10197	46483
	Охид	11121	11420	4152	4604	31298
Бүс	Баруун бүс	15387	14414	4753	5966	40519
	Хангайн	8034	10572	4090	6393	29089
	Төвийн бүс	4433	6858	2545	3802	17639
	Зүүн бүс	3153	4291	1877	2289	11610
	Улаанбаатар	10911	21087	2617	5052	39667
Аймаг, нийслэл	Архангай	1677	1935	846	1190	5647
	Баян-Өлгий	4844	3658	2262	2415	13179
	Баянхонгор	973	1311	830	1521	4634
	Булган	1082	1471	508	778	3839
	Говь-Алтай	2622	2053	529	908	6113
	Дорноговь	1352	947	268	433	3000
	Дорнод	1258	1766	872	902	4798
	Дундговь	292	1478	276	355	2402
	Завхан	1244	2267	320	681	4512
	Өвөрхангай	1975	3413	993	1280	7661
	Өмнөговь	410	533	0	7	949
	Сүхбаатар	1017	949	375	419	2759
	Сэлэнгэ	1376	2056	1372	2363	7166
	Төв	671	1431	529	439	3070
	Увс	2797	2520	45	151	5513
	Ховд	3879	3916	1597	1811	11204
	Хөвсгөл	544	892	774	1163	3372
	Хэнтий	878	1577	630	969	4053
	Дархан-Уул	332	414	100	206	1051
	Орхон	1785	1551	139	461	3935
	Говьсүмбэр	0	0	0	0	0
	Улаанбаатар	10911	21087	2617	5052	39667

Хүснэгт 14. Аюултай ажил эрхэлж буй хүүхэд

		5-9 настай	10-12 настай	3-14 настай	15-17 настай	Бүгд (5- 17 настай)
Бүгд		7275	13622	13833	23503	58233
Хүйс	Хөвгүүд	4518	9632	8892	16701	39743
	Охид	2757	3990	4941	6802	18489
Байршил	Хот	1835	3618	4171	8701	18326
	Хөвгүүд	1208	2561	2823	6503	13096
	Охид	628	1057	1348	2198	5230
	Хөдөө	5440	10004	9662	14801	39907
	Хөвгүүд	3310	7071	6069	10197	26647
	Охид	2129	2933	3593	4604	13259
Бүс	Баруун бүс	7275	13622	13833	23503	58233
	Хангайн	2182	3992	4041	5966	16181
	Төвийн бүс	1620	3066	3791	6393	14871
	Зүүн бүс	1204	2356	2091	3802	9453
	Улаанбаатар	1088	1664	1380	2289	6422
Аймаг, нийслэл	Архангай	688	939	814	1190	3631
	Баян-Өлгий	578	1119	1890	2415	6002
	Баянхонгор	225	529	731	1521	3005
	Булган	298	614	508	778	2198
	Говь-Алтай	345	540	488	908	2281
	Дорноговь	134	163	180	433	911
	Дорнод	427	578	647	902	2554
	Дундговь	86	361	229	355	1031
	Завхан	124	393	269	681	1466
	Өвөрхангай	94	571	993	1280	2939
	Өмнөговь	36	0	0	7	43
	Сүхбаатар	216	437	255	419	1327
	Сэлэнгэ	835	1348	1372	2363	5918
	Төв	68	429	245	439	1181
	Увс	0	133	28	151	311
	Ховд	1135	1808	1366	1811	6120
	Хөвсгөл	148	245	635	1163	2192
	Хэнтий	445	649	479	969	2541
	Дархан-Уул	45	54	64	206	369
	Орхон	167	168	110	461	906
	Говьсүмбэр	0	0	0	0	0
	Улаанбаатар	1181	2544	2530	5052	11306

Хүснэгт 15. Хүүхдийн цалин хөлс, орлого олох ажилд зарцуулж буй дундаж цаг

		Ажлын цаг, дүнд эзлэх хувиар:						
		Бүгд	14 цаг хүртэл	15-29 цаг	30-34 цаг	35-39 цаг	40-48 цаг	48 цагаас их
Бүгд		11569	60.9%	12.8%	5.5%	4.1%	9.9%	6.9%
Хүйс	Хөвгүүд	8008	63.6%	12.1%	5.2%	2.9%	8.5%	7.7%
	Охид	3561	54.7%	14.4%	6.1%	6.8%	12.9%	5.2%
Насны бүлэг	5 - 12 нас	3427	78.3%	12.5%	2.8%	5.7%	0.6%	0.0%
	13 - 14 нас	2571	49.7%	20.8%	11.4%	6.5%	11.7%	0.0%
	15 - 17 нас	5571	55.3%	9.3%	4.4%	2.0%	14.7%	14.4%
Байршил	Хот	6655	57.5%	6.6%	8.6%	2.9%	14.4%	10.1%
	Хөдөө	4914	65.4%	21.2%	1.2%	5.8%	3.8%	2.6%

Хүснэгт 16. Хүүхдийн өөрийн эцсийн хэрэглээний ажилд зарцуулж буй дундаж цаг

	1-7 цаг	8-14 цаг	15-21 цаг	22-27 цаг	28-34 цаг	35-41 цаг	42 ба түүнээс дээш цаг	Дүн
Бүгд	92108	16154	7642	3020	3308	2607	4384	129223
Хөвгүүд	57446	9643	5340	2134	2102	1753	3221	81639
Охид	34662	6511	2303	886	1206	854	1163	47584
Хот	49504	3259	1170	710	783	914	1686	58026
Хөдөө	42603	12895	6472	2310	2526	1693	2698	71196
5 - 12	73897	8297	3850	1219	1397	857	756	90274
13 - 14	6870	3147	2145	934	1135	773	682	15685
15 - 17	11341	4710	1647	867	776	977	2946	23264

Хавсралт 2. Ойлголт, тодорхойлолт

АЖИЛ, АЖЛЫН ХЭЛБЭР	
Ажил	Ажил гэж аль ч нас, хүйсийн хүн амын бусдын эсвэл өөрийн хэрэглээнд зориулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх албан ёсны болон албан бус бүхий л үйл ажиллагааг ойлгоно. Ажил гэсэн ойлголтод бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхээс өөр үйлдэл (гуйлга гуйх, хулгай хийх), өөрийн биеийг арчлах (хувийн ариун цэвэр сахих, арьс арчилгаа хийх, өөрийгөө сувилах) болон тухайн хүний өмнөөс өөр хүн гүйцэтгэж үл чадах үйл ажиллагаа (унтах, суралцах, өөрийгөө хөгжүүлэх, амрах) хамаарахгүй (заалт 6, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).
Ажлын хэлбэр	Ажлын хэлбэр гэж харилцан ялгаатай зорилгоор хийж гүйцэтгэдэг, өөр хоорондоо адилгүй олон төрлийн ажлыг үйлдвэрлэлийнх нь зориулалтаар (өөрийн эцсийн хэрэглээ болон бусдын хэрэглээнд), үйл ажиллагааных нь зорилгоос нь (цалин хөлстэй, орлого олох эсэх) хамаарч тус тусад нь хэмжихийг ойлгоно (заалт 7, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).
Өөрийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил	Өөрийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил гэж ихэвчлэн өөрийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа юм (заалт 7а, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).
Хөдөлмөр эрхлэлт (цалин хөлс, орлого олох зорилготой ажил)	Хөдөлмөр эрхлэлт гэж цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа юм. Хөдөлмөр эрхлэлт гэсэн ажлын хэлбэр нь ажиллах хүчний статистикийн хамрах хүрээг тогтооно (заалт 7b, 11, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).
Цалин хөлсгүй дадлагажих ажил	Цалин хөлсгүй дадлагажих ажил гэж ажлын байрны болон мэргэжлийн хувьд дадлага, туршлага, ур чадвар эзэмших зорилгоор цалин хөлсгүйгээр бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа юм (заалт 7с, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).
Сайн дурын ажил	Сайн дурын ажил гэж заавал хийж гүйцэтгэх үүрэг хүлээгээгүй ч бусдын хэрэглээнд зориулан цалин хөлс, орлого олох зорилгогүйгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх албадлагын бус шинжтэй үйл ажиллагаа юм (заалт 7d, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).
Бусад ажил	Бусад ажил гэж цалин хөлсгүй нийтийг хамарсан ажил, шүүх, түүнтэй адилтгах эрх мэдэл бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр цалин хөлсгүйгээр хийж гүйцэтгэх хоригдлуудын ажил, цэрэг, цагдаагийн байгууллагаас цалин хөлсгүй гүйцэтгүүлж буй ажил (бусдад хөлсгүй хийж өгсөн албадлагын шинж чанартай ажил) юм (заалт 8, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).
Үндсэн ажлын байр	Үндсэн ажлын байр гэж тухайн хүн цалин хөлс, орлого олох зорилгоор хоёр болон түүнээс дээш ажлын байранд хөдөлмөр эрхэлж байгаа тохиолдолд тухайн хугацаанд хамгийн их цаг зарцуулсан ажил юм (заалт 12b, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

Эдийн засгийн үйл ажиллагаа	Эдийн засгийн үйл ажиллагаа гэж зах зээлд зориулж үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээ юм. Өөрөөр хэлбэл, үндэсний тооцооны системийн хүрээнд бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд худалдах, солилцох эсвэл өөрийн хэрэглээндээ зориулан өрхөд үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хамруулна. Харин өөрийн хэрэглээндээ зориулсан үйлчилгээ болон бусдын хэрэгцээнд зориулсан сайн дурын үйлчилгээг хамруулахгүй.
Эдийн засгийн бус үйл ажиллагаа	Эдийн засгийн бус үйл ажиллагаа гэж Үндэсний тооцооны системийн хүрээнээс гаднах хүүхэд, өндөр настан асрах, гэр цэвэрлэх, хоол унд бэлтгэх зэрэг цалин хөлс, орлого олох зорилгогүйгээр өөрийн хэрэглээний болон бусдын хэрэглээнд зориулж сайн дураар хийж гүйцэтгэсэн үйлчилгээ юм.
ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	
Хүүхэд	Хүүхэд гэж НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын 1 дүгээр зүйл болон ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 182 дугаар конвенцын 2 дугаар зүйлд зааснаар 18 насанд хүрээгүй хүнийг хүүхэд гэж тодорхойлно. Хүүхдийн хөдөлмөрийг хэмжих зорилтод хүн ам нь 5-17 насны бүлэгт багтах бүх хүүхэд байх бөгөөд хүүхдийн насыг түүний хамгийн сүүлчийн төрсөн өдрөөр тасалбар болгох буюу бүтэн насаар тодорхойлно (заалт 8, 9, ХСОУ-ын 18 бага хурлын II тогтоол энэ 20-р өөрчлөгдөөгүй).
Хүүхдийн ажил эрхлэлт	Хүүхдийн ажил эрхлэлт гэж хүүхдийн хөдөлмөрийг хэмжихтэй холбоотой хамгийн өргөн хүрээтэй ойлголт бөгөөд YTC-2008-д тодорхойлсноор YTC-ын үйл ажиллагааны ерөнхий хүрээнд хамаарч буй бусдын эсвэл өөрийн хэрэглээнд зориулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх аливаа үйл ажиллагааг тухайн хугацаанд нэг цагаас доошгүй эрхэлсэн 5-17 насны хүүхдийн үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл, өөрийн хэрэглээний үйлчилгээ эрхэлж байгаа болон өрхийн хэрэгцээнд зориулан сайн дураар үйлчилгээ үзүүлж буй хүүхдийн үйл ажиллагааг YTC-ийн үйлдвэрлэлийн хүрээнээс гадуурх ажлын хэлбэр гэж үзэх ч үйлдвэрлэлийн ерөнхий хүрээн доторх үйл ажиллагаа эрхэлж буй хүүхэд гэж үзнэ (заалт 11, 13 ХСОУ-ын 18 бага хурлын II тогтоолын шинэчилсэн төсөл).
Хүүхдийн хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар	Хүүхдийн хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар гэж ОУХБ-ын Ажилд авах насны доод хязгаарын тухай 138 дугаар конвенцын 2 дугаар зүйлд зааснаар ажил, хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар нь заавал эзэмших боловсрол буюу суурь боловсрол эзэмших хүүхдийн нас байх бөгөөд энэ нь ямар ч тохиолдолд 15 наснаас доошгүй байна.
Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт	Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт гэж дараах бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг эрхэлсэн 18 нас хүрээгүй хүүхдийн үйл ажиллагаа юм (заалт 12, 15, ХСОУ-ын 18 бага хурлын II тогтоолын шинэчилсэн төсөл). Үүнд: а) ажил эрхэлж буй хүүхэд (тодорхойлолт 22) болон хөнгөн ажил хийж болохуйц наснаас доош нас (5-12 нас)-ны хүүхдийн эрхэлж буй үйл ажиллагаа; b) YTC-ийн үйлдвэрлэлийн хүрээнд хөнгөн ажлыг тогтмол эрхэлж байгаа 13-17 насны хүүхдийн үйл ажиллагаа; c) тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд (тодорхойлолт 26) болон өрхөд цалин хөлсгүйгээр ажиллаж буй аюултай үйлчилгээг багтаасан аюултай ажил (тодорхойлолт 27) эрхэлж байгаа буй хүүхдийн үйл ажиллагаа орно.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр гэдэгт: a) боолчлолын бүх хэлбэрүүд болон хүүхдийг худалдах, дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх, түүний дотор зэвсэгт мөргөлдөөнд хүүхдийг хүчээр буюу албадан элсүүлэх зэрэг боолчлолтой төстэй үйл ажиллагаа; b) хүүхдийг бэлгийн мөлжлөгт өртүүлж буй үйл ажиллагаа, садар самууны сурталчилгаа болон садар самууны үзүүлбэрт хүүхдийг ашиглах, элсүүлэн авах эсвэл тийм үйл ажиллагаанд оролцохыг санал болгох; c) хүүхдийг мансууруулах бодис үйлдвэрлэх, нууцаар наймаалах зэрэг олон улсын холбогдох гэрээнүүдэд заагдсан хууль бус үйл ажиллагаанд оролцохыг санал болгох; d) мөн чанар, эсвэл хөдөлмөрийн нөхцөлөөрөө хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хохирол учруулахуйц ажлыг хамааруулна (заалт 17, ХСОУ-ын 18 бага хурлын II тогтоол).
Хүүхдийн аюултай ажил	Хүүхдийн аюултай ажил гэж хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуун, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх аюултай шинж чанар бүхий (аюултай орчин, тоног төхөөрөмж, салбар, ажил мэргэжил) аливаа ажил, үйл ажиллагаа юм. Уртасгасан цагаар эсвэл шөнийн цагаар ажиллаж байгаа бол аюултай ажил эрхэлж байна гэж үзнэ (заалт 20, ХСОУ-ын 18 бага хурлын II тогтоол).
Хөнгөн ажил	Хөнгөн ажил гэж ОУХБ-ын Ажилд авах насны доод хязгаарын тухай 138 дугаар конвенцын 7 дугаар зүйлд зааснаар доорх нөхцөл хангагдсан тохиолдолд ажил эрхэлж буй 13-17 насны хүүхдийн үйл ажиллагаа юм. Хангагдсан байх нөхцөлд: a) эрүүл мэнд, өсөлт хөгжилд хортой нөлөө үзүүлэхгүй байх; b) сургуульд суралцах, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрт хамрагдах болон олсон мэдлэгээ ашиглах явцад нь саад учруулахгүй байх шаардлагыг хангасан байх; c) хууль ёсны төлөөлөгч буюу эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлтэй байх ёстой.
Гэрийн ажилчин (domestic work)	Гэрийн үйлчилгээний ажилтны тухай ОУХБ-ын 189-р конвенцод “гэрийн ажил” гэж аливаа өрх, өрхүүдэд буюу тэдгээрийн хүсэлтээр гүйцэтгэсэн ажлыг, “гэрийн ажилчин” гэж хөдөлмөрийн харилцааны хүрээнд гэрийн ажил эрхэлж буй хүнийг хэлнэ. Хүүхдийн гэрийн ажил гэдэг нь гуравдагч этгээдийн, аль эсвэл ажил олгогчийн гэрт гэрийн ажил хийж буй хүүхдийн ажлыг хэлнэ. Энэхүү ерөнхий ойлголт нь ажлын зөвшөөрөгдөх болон үл зөвшөөрөгдөх нөхцөлийн аль алиныг нь багтаасан болно.²
Өрхийн цалин хөлсгүй үйлчилгээний гэрийн ажил	Өрхийн гишүүдийн өөрийн болон түүнтэй адилтгах хэрэгцээнд зориулан гүйцэтгэсэн үйлдвэрлэлийн ерөнхий хүрээний ахуйн болон хувийн үйлчилгээний ажил, үүнийг ихэвчлэн “өрхийн цалин хөлсгүй үйлчилгээний гэрийн ажил” гэж нэрлэдэг. Мөн үүнд өрхүүдэд бусдын хэрэгцээнд зориулан гүйцэтгэсэн сайн дурын ажил хамаарна.

² ОУХБ, [Хүүхдийн хөдөлмөр, гэрийн ажил](#)

Хавсралт 3. Судалгааны аргачлал

Үндэсний статистикийн хороо Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэй холбоотой мэдээллийг бий болгох, үзүүлэлтийг өргөжүүлэх, мэдээллийн давтамжийг нэмэгдүүлэх, боловсронгуй болгох зорилгоор Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа /ХХС/-г 2002-2003, 2006-2007, 2011-2012 онуудад “Ажиллах хүчний судалгаа”-нд нэмэлт модуль хэлбэрээр оруулж, олон улсын аргачлалын дагуу зохион байгуулж, үр дүнг тархааж байв. Дээрх судалгаануудын үр дүнгээр хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг тэр дундаа аюултай ажил, хөдөлмөр эрхлэлтийг устгахад чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, статистикийн суурь мэдээллийг бий болгосон ба цаашид судалгааны мэдээллийг баяжуулах, давтамжийг тогтмолжуулах, хүүхдийн ажил, хөдөлмөрийн статистикийг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдсаар ирсэн.

Энэ хүрээнд Үндэсний статистикийн хороо Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагатай хамтран “Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа”-г шинэ аргачлалын дагуу, анх удаа бие даасан түүвэр судалгаа хэлбэрээр 2021-2022 онд зохион байгууллаа.

Судалгааны үндсэн зорилго

Хүүхдийн ажил, хөдөлмөр эрхлэлтийн хэмжээ, бүтэц, тэдгээрт гарч буй өөрчлөлтийг тодорхойлж, дүн шинжилгээ хийхэд ашиглагдах тоон мэдээллийн багцыг бий болгоход оршино. Үүнд:

- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, тархалтыг газар зүйн байршлаар, өрхийн төрөл, шинж байдлаар, хүүхдийн сургуульд хамрагдалтын байдал, хүйс, насны бүлэг болон бусад хүчин зүйлсээр тооцох;
- Ажил эрхэлж байгаа хүүхэд, тэдгээрийн нөхцөл байдал, шинж чанар, үр дагаврыг судлах, тухайлбал, хүүхдүүдийн эрхэлж байгаа ажлын хэлбэр, ажлын нөхцөл нь тэдний боловсрол, эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгаа гэх мэт асуудлуудыг судлах болно.

Энэ зорилгын хүрээнд хүүхдийн амьдарч буй өрх, гэр бүлийг тодорхойлох, тэдний орон сууцны нөхцөл байдал, нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн онцлог шинж байдал, хүүхдийн боловсролын түвшин, тэдний ажил, хөдөлмөр эрхлэлт тэр тундаа аюултай ажил, хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийг тооцох, хүүхдийн ажил, хөдөлмөр эрхлэх болсон шалтгаан, үр дагаврыг үнэлэх зорилт тавьж судалгааг зохион байгуулсан.

Аргачлал, арга зүй

Хөдөлмөрийн статистикийн олон улсын стандартыг тогтоох механизм нь 5 жил тутамд зохион байгуулдаг Олон улсын хөдөлмөрийн статистикчид /ОУХС/-ын бага хурлын тогтоол, зөвлөмж байдаг. Олон улсад Хөдөлмөрийн статистикийн аргачлалыг 2013 он хүртэл 1982 оны ОУХС-ын 13-р бага хурлын тогтоолоор, 2014 оноос 2013 онд болсон 19-р бага хурлын “Ажил, хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн дутуу ашиглалт” бүхий олон улсын статистикийн стандарт арга зүйн баримт бичиг бүхий тогтоолыг мөрдлөг болгож байна.

Харин Хүүхдийн хөдөлмөрийн статистикийн аргачлалын хувьд 2008 он хүртэл ОУХС-ын 13-р бага хурлын тогтоолын дагуу насанд хүрсэн хүний хөдөлмөр эрхлэлттэй адил авч үзэж байсан бол 2008 оны ОУХС-ын 18-р бага хурлаар хүүхдийн хөдөлмөрийг насанд хүрсэн хүний хөдөлмөр эрхлэлтийн ойлголт, аргачлалаас тусад нь авч үзэх хэрэгтэйг сануулж, “Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн статистикийн тухай” анхны бие даасан тогтоолыг гаргасан. Үүний дараа ОУХС-ын 19-р бага хурлын тогтоолоор ерөнхий ажил, хөдөлмөр гэдэг ойлголт шинэчлэгдсэн тул 2018 онд болсон 20-р бага хурлаар Хүүхдийн хөдөлмөрийн статистикийн аргачлал шинэчлэгдсэн.

Монгол Улсын Хөдөлмөрийн статистикийн салбарт болон энэхүү судалгаанд Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А-09/08 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал"-ыг үндсэн аргачлал болгон мөрдсөн. Энэхүү аргачлалыг боловсруулахдаа 2013, 2018 онуудад болсон Олон улсын хөдөлмөрийн статистикчдын 19, 20-р бага хурлуудын тогтоолын дагуу боловсруулсан.

Давуу тал: Хүүхдийн хөдөлмөрийн өрхөд суурилсан, бие даасан түүвэр судалгаа явуулах нь өрх болон хүүхэд, тэдний гэр бүлийн, нийгэм эдийн засаг, хүн ам зүйн онцлог шинж, орон сууцны нөхцөл, хүүхдийн боловсролын түвшин, ажил эрхлэлт тэр тусмаа аюултай ажил эрхлэлтийг тодорхойлж, хүүхдийн ажил эрхлэх шалтгаан болон үр дагаврыг үнэлэхэд хамгийн оновчтой байдаг.

Сул тал: Хүүхдийн хөдөлмөрийн тоон судалгаагаар ажил, хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн тоо, түвшин, түүний тархалтыг тодорхой шинж байдлаар нь тодорхойлно. Харин тархалтынх нь мөн чанар, шалтгаан, үр дагаврыг тусгайлсан Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгаагаар тодорхойлох боломжтой юм.

Маягтын боловсруулалт

Хүүхдийн хөдөлмөрийн статистикийн олон улсын аргачлал 2018 онд шинэчлэгдсэнтэй холбогдуулан ОУХБ-аас "Мэдээлэл цуглуулах маягт боловсруулах" ажлын хэсэг гарган ажиллаж, эхний төслийг МУ-ын ХХС-нд ашиглахыг зөвлөмж болгон, судалгааг зохион байгуулахад хамтран ажилласан. Мөн Үндэсний статистикийн хороо "Хүүхдийн хөдөлмөрийн судалгааны маягтын төсөл болон үр дүнгийн тайлангийн төсөлд санал өгөх" үүрэг чиглэл бүхий салбар дундын техникийн ажлын хэсэг байгуулан ажилласан.

ОУХБ-аас зөвлөмж болгосон маягтын төслийг өөрийн орны онцлогт нийцүүлэн боловсруулж, төслийг ОУХБ болон Техникийн ажлын хэсэгт танилцуулан, санал солилцсон Мөн маягтын төслийн танин мэдэхүйн тестийг 21 аймаг, 9 дүүрэгт тус бүр 1 өрх, туршилтын судалгааг Төв аймгийн Зуунмод, Баян сумын нийт 40 өрхийг хамруулан зохион байгуулж, төслийг сайжруулсан. Туршилтын дараах шатанд судалгааны маягтыг ҮСХ-ны Аргай зүйн байнгын зөвлөл болон Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, эцэслэсэн. ХХС-ны асуулгын маягт нь хаягийн хэсэг болон 9 бүлэг асуулгаас бүрдэх бөгөөд 266 асуулттай юм. Үүнд:

- Хаягийн хэсэг – 18
- Өрхийн асуулга - 30
- Өрхийн ам бүлийн байдал – 17
- Эрүүл мэндийн байдал - 6
- Шилжилт хөдөлгөөн – 4
- Боловсрол – 19
- Ажил эрхлэлт – 48
- Ажил хайгч – 3
- Сүүлийн 12 сарын байдлаар ажил эрхлэлт – 4
- Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэл – 21
- Цалин хөлсгүй дадлагажигч – 2
- Аюултай ажил – 21
- Ажлын байрны хүчирхийлэл – 6
- Осол гэмтэл – 17
- Сэтгэл зүйн эрүүл мэнд – 9
- Өрхийн хэрэгцээнд зориулсан үйлчилгээ – 36
- Чөлөөт цаг – 5

Ашигласан ангилал

Энэхүү судалгаанд дараах ангиллуудыг судлан ашигласан. Үүнд:

- Үндэсний статистикийн хорооны даргын 2014 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн А/183 дугаар тушаалаар батлагдсан “Монгол Улсын боловсролын түвшний ангилал”;
- Монгол Улсын сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 319, А/160 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”;
- Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн сайдын 2010 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 16 дугаар тушаалаар батлагдсан “Монгол Улсын Үндэсний Ажил, Мэргэжлийн Ангилал ба Тодорхойлолт YAMAT-08 (ISCO - 08)”;
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код (MNS-5641-1:2006:).

Судалгааны түүвэрлэлт

Түүврийн нэгж

Судалгааны мэдээлэл цуглуулалтын үндсэн нэгж нь өрх байна. Өрх: Нэг орон байранд хамт амьдардаг нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг, хэсэг бүлэг хүмүүс, Өрхийн гишүүд нь хоорондоо гэр бүл, ураг төрөл болон хамаатан садны холбоотой хүмүүс, зарим гишүүд нь огт хамааралгүй байж болно. Өрх нь гэр бүл гэдэг ойлголтоос ялгаатай. Нэг өрхөд нэг болон хэд хэдэн гэр бүл амьдарч байж болно.

Дараах өрх, хүн амыг судалгаанд хамруулсан. Үүнд:

- Өрхийн гишүүн биш, өрхийн ам бүлд бүртгэлгүй ч тухайн өрхөд судалгааны хугацаанд амьдарч байгаа хүн. Жишээ нь, тухайн өрхийн цалинтай малчин, хүүхэд асрагч гэх мэт.

Дараах өрх, хүн амыг судалгаанд хамруулаагүй. Үүнд:

- 6 ба түүнээс дээш сарын хугацаагаар өрхөөс гадуур байгаа болон мөн хугацаагаар өрхөөс гадуур байхаар явсан гишүүд,
- Хорих газарт хоригдож байгаа хүмүүс,
- Халамжийн төвүүд, асрах газарт амьдарч байгаа хүмүүс,
- Хугацаат цэргийн албан хаагчид.

Түүврийн хүрээ, түүвэрлэлт

Өрхөд суурилсан судалгаа тул тухайн өрхийн 5-17 насны хүүхдүүд судалгаанд хамрагдах ба гэр оронгүй, хараа хяналтгүй хүүхдүүд болон засан хүмүүжүүлэх газар, асрах газар, халамжийн төв зэрэг нийтийн байранд амьдарч буй хүүхдүүд хамрагдахгүй юм. Судалгааны хамрах хүрээ нь Монгол Улсын 21 аймаг, 9 дүүргийн 5-17 насны хүүхэдтэй өрх байна. Судалгааны түүврийн хүрээг ХАӨМС-гийн 2020 оны жилийн эцсийн мэдээлэлд үндэслэн бэлтгэсэн. Манай улсад 2020 оны эцэст 5-17 насны 816.7 мянган хүүхэд 475.0 мянган өрхөд амьдарч, 5-17 настай хүүхэд нийт хүн амын 25.1 хувийг эзэлж байсан бол 5-17 насны хүүхэдтэй өрх нийт өрхийн 52.3 хувийг эзэлж байв.

Түүвэрт хэчнээн өрх хамрагдах нь судалгааны санхүүжилтээс болон түүвэр судалгааны үр дүнгийн нарийвчлалаас хамаарна. Судалгаанд хамрагдсан 13144 өрхөөс авсан мэдээлэл нь Монгол Улсын нийт өрхүүдийг төлөөлөхдөө судалгааны асуулгаар цуглуулсан мэдээллийн бодит байдал үндэсний хэмжээнд 5 хувиас хэтрэхгүй алдааны магадлалтай ба түүвэрлэлтийн загварын нөлөөний утга нь 1.5-аас хэтрэхгүй байхаар хийгдсэн болно.

Түүврийн үе шат

Түүвэрлэлт хийх үйл ажиллагаа нь үндсэн 2 үе шаттай байна.

Эхний үе шатанд Монгол Улсын аймаг, дүүргийн нийт баг, хэсгийн жагсаалтаас харгалзах тооны түүврийн анхан шатны нэгж (ТАШН)-ийг хэмжээнд пропорциональ магадлалт түүврийн аргыг ашиглан сонголтыг хийсэн.

Хэмжээнд пропорциональ магадлалт түүврийн аргаар анхан шатны нэгжийг сонгоход ТАШН дэхь хүн амын тоо M_{hi} -г хэмжээний тодорхойлогч болгон ашигласан. Бүлэглэлт тус бүрээс хэмжээнд нь пропорциональ магадлалт системчилсэн түүврийн аргыг (ХПМСТ) түүвэрлэлт хийхэд хэрэглэсэн болно. Түүвэрлэлтийн үйл ажиллагааг дараах байдлаар үзүүлэв. Үүнд:

“ h ” бүлэг доторх “ i ” ТАШН-ийн түүвэрлэгдэх магадлал дараах томъёогоор илэрхийлэгдэнэ.

$$P_{hi}^{(i)} = \frac{a_h M_{hi}}{M_h}$$

Үүнд:

a_h = бүлэг тус бүрээс авсан ТАШН-ийн тоо

M_{hi} = “ i ” ТАШН-д түүврийн хүрээнд тодорхойлогдсон хүн амын тоо

$M_h = \sum M_{hi}$ = бүлэг бүр дэх түүврийн хүрээгээр тогтоогдсон нийт хүн амын тоо

“ h ” бүлэг дэх ТАШН-үүдийг аймаг, сум, дүүргийн нэрийн дагуу жагсааж ТАШН-ийн түүвэрлэлтийг хийсэн ба тогтоогдсон хүн амын тоог хэмжээний үзүүлэлт M_{hi} болгож авсан юм. “ M_{hi} ” өсөн нэмэгдэх утгуудыг тооцоолж уг утгуудыг ТАШН тус бүрийн харалдаа тавьсан болно. Түүврийн интервал I_{hi} -ийг дараах байдлаар тооцоолсон.

$$I_{hi} = \frac{M_h}{a_h} \text{ хамгийн ойр бүхэл тоонд шилжүүлнэ.}$$

“ R_h ” санамсаргүй тоо нь 0-с I_{hi} хүртэлх дурын тоо байх ба үүнийг санамсаргүй тооны функцийг тусламжтайгаар тодорхойлов. “ a_h ” тодорхойлогч тоонуудын дарааллыг өмнөх сонгогдсон тоон дээр I_{h1} -г нэмж олсон болно.

$$R_h, (R_h + I_{h1}), (R_h + 2I_{h1}), (R_h + 3I_{h1}), \dots, (R_h + (j-1)I_{h1}), (R_h + (a_h - 1)I_{h1})$$

Хоёр дахь шатанд түүврийн хамралт болон төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, алдааны магадлалыг бууруулахын тулд сонгогдсон ТАШН бүрээс 12 өрхийг сонгон судалгаанд хамруулсан.

Түүврийн жин

Үр дүнгийн тооцоо хийх, дүн шинжилгээ боловсруулахад түүврийн жинг тооцож ашиглана. Түүврийн жинг тооцоход дараах тоо мэдээлэл шаардлагатай. Үүнд:

- Кластерын тоо;
- Сонгогдсон кластерын өрхийн тоо;
- Сонгогдсон өрхөөс судалгаанд хамрагдах боломжтой хүмүүсийн тоо.

Түүврийн жин нь тухайн шатанд сонгогдсон элементүүдийн магадлалын урвуу хэмжигдэхүүн байх бөгөөд дараах байдлаар тооцно:

Нэгдүгээр шатны түүврийн жин:

$$W_{1k} = \frac{A_k}{A_{ks}}$$

A_k = k дугаар бүлгийн нийт өрхийн тоо

A_{ks} = k дугаар бүлгээс сонгогдсон s ширхэг кластерийн нийт өрхийн тоо

Хоёрдугаар шатны түүврийн жин:

$$W_{2kj} = \frac{M_{kj}}{m_{kj}}$$

M_{kj} = k бүлгийн j кластерийн нийт өрхийн тоо

m_{kj} = k бүлгийн j кластерийн судалгаанд хамрагдсан өрхийн тоо

Өрхийн түүврийн жин дээрх 2 жингийн үржвэр байна:

$$W_{kj} = \frac{A_k}{A_{ks}} \cdot \frac{M_{kj}}{m_{kj}}$$

Стандарт алдааны тооцоо

Судалгааны үр дүнгийн нарийвчлал, төлөөлөх чадварыг гаргах нь тооцооны зайлшгүй хэсэг юм. Тухайн сонгож авсан у үзүүлэлтийн вариацийг тооцох томьёо:

$$var(y) = \sum [(1 - f_h)(a_h/a_h - 1) \sum (y_{hi}^2 - y_h^2/a_h)]$$

Үүнд:

f_h - h бүлгийн түүврийн хувь

a_h - h бүлгийн түүвэрлэсэн ТАШН-ийн тоо

y_{hi} - h бүлгийн i дугаар нэгжин у үзүүлэлтийн утга

Судалгааны үр дүнгийн стандарт алдааны утга нь түүвэр хийснээс шалтгаалан ерөнхий олонлогийн бодит утга буюу параметрээс түүврийн утга хэр зэрэг хэлбэлзэж байгааг үзүүлнэ. Стандарт алдааг $se(y)$ түүврийн үндсэн дээр тооцохдоо:

$$se(y) = var(y)^{1/2}$$

Харьцангуй стандарт алдаа буюу вариацийн коэффициент нь cv , түүврийн тооцооны утгын харьцангуй вариацийн утгыг илэрхийлэх ба өрөөр хэлбэл түүврийн алдаа нь тооцооны утгатайгаа харьцуулахад ямар далайцтай байна гэдгийг илэрхийлнэ. Вариацийн коэффициент доорх аргаар тооцно.

$$cv(y) = se(y)/y$$

Дундаж, харьцаа зэрэг үзүүлэлтийн тооцооны утгыг далайц, хэмжих нэгж нь өөр байдгаас хамааран тухайн судлагдаж байгаа үзүүлэлтийн талаар хийгдсэн янз бүрийн судалгааны үр дүнгийн стандарт алдаануудыг шууд харьцуулах боломжгүй учраас cv буюу пропорциональ алдаа нь төлөөлөх чадварыг харьцуулах боломж олгодог. Түүврийн хэмжээ болон түүврийн арга нь түүврийн алдаа хэр зэрэг их, бага байхыг тодорхойлох бөгөөд зарим үзүүлэлтийн хувьд түүргийн алдаа өндөр байх боломжтой бөгөөд эдгээр тоог ашиглахдаа анхааралтай байх хэрэгтэй.

Түүврийн алдаа

Түүвэр судалгаа хийгдэж байгаатай уялдаж дараах 2 төрлийн алдаа гарч байдаг. Үүнд:

1. Түүвэрлэлтийн алдаа
2. Түүвэрлэлтийн бус алдаа

Түүвэрлэлтийн бус алдаа нь тоон мэдээллийг цуглуулах, боловсруулах, тархаах үйл явцын үед гардаг. Энэхүү алдаанд судалгааны бэлтгэл үе шат, мэдээлэл цуглуулах үед хийсэн судлаачийн санамсаргүй болон санаатай хийсэн алдаа, боловсруулалтын шатад гарсан алдааг хамруулж авч үздэг. Түүвэрлэлтийн бус алдаа нь түүврийн үр дүнгийн алдааны ихэнх хувийг эзэлдэг бөгөөд түүврийн дизайн болон түүвэр судалгааг явуулах үе шатуудаас хамаардаггүй, түүнийг

статистикийн аргаар тооцоолох боломж хомс байдаг. Харин түүвэрлэлтийн алдааг статистикийн аргаар тооцдог.

Нийт олонлогоос түүвэрлэн авсан ажиглалт дээр тулгуурлан үр дүнг тооцдогоос шалтгаалан түүвэрлэлтийн алдаа гардаг. Түүвэрлэлтийн алдаа тухайн судалгааг хийхэд ашигласан түүврийн төрөл болон түүврийн хэмжээнээс хамаарна. Энэхүү алдааг боломжит түвшинд байлгах үүднээс түүврийн дизайн болон түүврийн хэмжээг сонгосон.

Улсын хэмжээнд тодорхойлогдсон ТАШН бүрээс сонгогдсон өрхөөс судалгаа авч үр дүнг тооцсонтой холбоотойгоор судалгааны үр дүн бодит утгаас ямар хэмжээний хэлбэлзэлтэй байгааг түүвэрлэлтийн алдаа илэрхийлнэ. Түүврийн загвар болон түүврийн хэмжээнд тулгуурлан алдааг тооцсон бөгөөд зарим нэг үзүүлэлтийн алдааны хязгаар байх нь түүврийн загварыг сонгох үе шатад харагдаж байсан.

Судалгааны түүвэрлэлтийн алдааг дараах үзүүлэлтийн тусламжтайгаар тооцоолсон бөгөөд түүврийн алдааг илэрхийлэх гол үзүүлэлт нь вариацийн коэффициент юм. Үүнд:

- Ерөнхий олонлогийн үзүүлэлтийн тооцооны утга
- Стандарт алдаа
- Вариацийн коэффициент
- 95 хувийн итгэх интервал

Түүвэрлэлтийн алдааг судалгааны үндсэн үзүүлэлтүүдийн хувьд улсын түвшин, бүс, байршил, аймаг, хүйсээр гэсэн ангиллаар тооцсон.

Мэдээлэл цуглуулалт

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2021 оны 10 сард эхлэх 2022 оны 9 сарыг дуустал, 12 сарын мэдээллийг цуглуулсан.

Судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлыг нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсийн ажиллах хүчний судалгаа хариуцсан багийн ахлах, судлаачид хийж гүйцэтгэсэн. Судлаач нь тухайн сард сонгогдсон өрхөд очиж тухайн өрхөд амьдарч байгаа 5-17 насны гишүүнийг судалгаанд хамруулсан. Ингэхдээ 5-11 насны хүүхэд асуултад орсон ойлголтыг ойлгохгүй байх магадлалтай тул тухайн хүүхдийн талаар бүрэн мэдээлэл өгч чадах өрхийн насанд хүрсэн гишүүнийг байлцуулан, 12-17 насны хүүхдээс өөрөөс нь асууж, ярилцлага хийх замаар мэдээллээ цуглуулсан. Харин 12-17 насны хүүхэд өөрөө мэдээлэл өгөх боломжгүй тохиолдолд тухайн хүүхдийн талаар бүрэн мэдээлэл өгч чадах өрхийн насанд хүрсэн гишүүнтэй байлцуулан ярилцлага хийсэн.

Судалгааны мэдээллийг судлаач таблетаар цуглуулан, зааврын дагуу шалгаж, кодлон интернэт орчинд ҮСХ-ны төв серверт графикт хугацаанд дамжуулж ажилласан. Судлаачийн төв серверт байршуулсан мэдээллийг тухайн аймаг, нийслэлийн судалгааны багийн ахлагч серверт хандан орж шалган, ахлагчийн таблетаас эцэслэн дамжуулсан. Өрхийн гишүүд эзгүй байх тохиолдолд судлаач сонгогдсон өрхөө судалгаанд бүрэн хамруулахын тулд өрхөд 2-3 удаа эргэж очин судалгаанд хамруулах оролдлогыг хийж байсан.

Судалгааны чанар

Судалгааны тоон мэдээллийг чанартай цуглуулахын тулд дараах зарчмыг баримталж ажилласан. Үүнд:

- ҮСХ-ны болон орон нутагт ажиллах ажилтнууд /ахлагч, хянагч, судлаач/ тухайн хугацаанд мөрдөгдөж буй “ҮСХ-ны судалгааны багийн ажиллах журам”, “Судалгааны мэдээлэл

цуглуулах багийн ажиллах журам"-ыг мөрдлөг болгосон,

- Судалгаанд ажиллах ажилтнууд /ахлагч, хянагч, судлаач/ нь батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдсан,
- Судалгааны явцад ОУХБ-тай хамтран судалгааны мэдээлэл цуглуулах багт 7 удаагийн цахим сургалтыг зохион байгуулсан,
- Судалгаанд ажиллахаар сонгогдсон ажилтнуудын ажлын явцад хяналт тавих ажлыг ҮСХ-ны Нийгмийн статистикийн газар, Тамгын газар болон орон нутгийн статистикийн албадын дарга нар хариуцаж зохион байгуулсан. ҮСХ-ны судалгаа хариуцсан нэгжийн албан хаагчид судалгааны мэдээллийн чанарт хяналт хийх, тулгарч буй асуудлуудад заавар зөвлөмж өгөх үүднээс Орхон аймгаас бусад бүх аймагт болон Улаанбаатар хотын бүх дүүргүүдэд ажилласан.

Мэдээллийн нууцлал

Судалгааны тоон мэдээллийг судалгааны зорилгын дагуу улсын хэмжээнд нэгтгэн, анализ, дүн шинжилгээ хийхэд ашигласнаас гадна судалгаанд ажилласан бүх шатны ажилтнууд өрхийн мэдээллийг бусдад задруулахгүй байх үүрэг хүлээж ажилласан. Ингэхдээ Мэдээллийн нууцыг Монгол Улсын Хувь хүний нууцын тухай хууль болон Статистикийн тухай хуулийн 22-р зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу чандлан хадгалах үүрэг хүлээсэн.

Мэдээлэл боловсруулалт

Судалгааны асуулга боловсруулах, мэдээллийн орох программын бодлогын даалгаврыг боловсруулах, сургалт зохион байгуулах, мэдээллийн бүрдэлтийг шалгах, хянах, судалгааны үндсэн үр дүн, нэгдсэн тайланг боловсруулах гэх мэт судалгааны бэлтгэл, мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын бүхий л үе шатны ажлуудыг Нийгмийн статистикийн газрын Өрхөд суурилсан судалгааны хэлтсийн Хөдөлмөрийн статистик хариуцсан албан хаагчид хийж гүйцэтгэсэн. Харин мэдээллийн оролтын программ боловсруулах, түүвэрлэгдсэн өрхийн мэдээллийг сар бүр программд холбох ажлыг Мэдээллийн технологийн газар, судалгааны түүврийн холбогдох ажлыг Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын Судалгаа, шинжилгээ, түүврийн хэлтсийн албан хаагчид хийж гүйцэтгэсэн.

Мэдээллийн баазыг үүсгэх, шалгахад CPro багц программыг, мэдээллийн үр дүнг нэгтгэж боловсруулах, холбогдох хүснэгтүүдийг тооцож гаргахад SPSS, STATA программ хангамжийг ашигласан.

НН. ӨРХИЙН АСУУЛГА

НН_1. Сууцны төрөл		НН_9. Та энэ сууцныхаа өмчийн хэлбэрийг хэлнэ үү?	
Гэр	1 => НН_6	Хувийн: Өөрийн өмчийн	1 => НН_11
Байшин: Орон сууцны байшин	2	Бусдын өмчийн	2
Бие даасан тохилог сууц	3	Төрийн өмчийн ААНБ-ын	3
Сууцны тусдаа байшин	4	Хувийн өмчийн ААНБ-ын	4
Нийтийн байр	5		
Зориулалтын бус сууц	6 => НН_4	НН_10. Та энэ сууцаа түрээсэлж суудаг уу?	
		Түрээсэлж байгаа	1
Бусад (бичих)	7	Түрээсгүй амьдардаг	2
НН_2. Танай сууц хэдэн өрөөтэй вэ?	Өрөөний тоо	НН_11. Танайх ямар бие засах газар ашигладаг вэ?	
(гал тогоо, коридор, угаалгын өрөөг оруулахгүй)		Төвлөрсөн шугам (ариутгах татуургаатай)	1
НН_3. Танай сууцны хүн амьдрах талбайн хэмжээ хэд вэ?	Метр квадрат	Битүү тунгаагууртай	2
		Нүхэн жорлон: Хагас нэвчилттэй жорлон, угаадасны нүх	3
		Нэвчилтгүй жорлон, угаадасны нүх	4
НН_4. Танай сууц гал тогооны өрөө/хэсэгтэй юу?		Бохир усны цооногтой	5
Тийм, тусдаа гал тогооны өрөөтэй	1	Био жорлон	6
Тийм, хүн амьдрах талбайтайгаа нэг буюу нэг өрөөнд	2	Задгай жорлон	7
Үгүй, нийтийн эзэмшлийн гал тогоотой	3	Ил задгай бүхээгтэй жорлон	8
		Тосох хувинтай жорлон	9
НН_5. Танай өрх бие засах газартай юу?		Хээрийн нөхцөл	10
Тийм, сууцны дотор	1 => НН_7	Бусад (бичих)	11
Тийм, сууцны гадна	2 => НН_7		
Байхгүй	3 => НН_7	НН_12. Танай сууцны гэрэлтүүлгийн үндсэн эх үүсвэр юу вэ?	
НН_6. Гэрийн ханын тоо	Ханын тоо	Төвлөрсөн системийн цахилгаан	1
		Дизель станц	2
НН_7. Танай сууцны халаалтын үндсэн эх үүсвэр юу вэ?		Нарны эрчим хүчний эх үүсгүүр	3
Төвлөрсөн халаалт/систем	1 => НН_9	Салхины эрчим хүчний үүсгүүр	4
Цахилгаан халаагуур	2	Бага оврын цахилгаан үүсгүүр	5
Нам даралтын зуух	3	Лаа	6
Сайжруулсан зуух	4	Бусад (бичих)	7
Энгийн зуух, пийшин	5	Гэрэлтүүлэггүй	8
Тулга/Ил гал	6		
Бусад (бичих)	7	НН_13. Танайх үндны усаа ихэвчлэн ямар эх үүсвэрээс авдаг вэ?	
Халаалтын эх үүсвэр байхгүй	8	Төвлөрсөн ус хангамж	1
НН_8. Танай өрхийн халаалтдаа ихэвчлэн хэрэглэдэг түлш болон эрчим хүчний эх үүсвэр юу вэ?		Ундны ус түгээх цэг:	
Сэргээгдэх эрчим хүч	1	Төвлөрсөн ус хангамжид холбогдсон ус түгээх цэг	2
Цахилгаан эрчим хүч	2	Зөөврийн ус хангамжтай ус түгээх цэг	3
Нүүрс	3	Гүний худгийн ус хангамжтай ус түгээх байр	4
Мод	4	Гүний худаг	5
Гишүү/бургас	5	Гар худаг: Хамгаалсан гар худаг	6
Аргал, хөрзөн, хомоол	6	Хамгаалаагүй гар худаг	7
Сайжруулсан түлш	7	Булаг: Хамгаалсан булаг	8
Хог хаягдал (хуванцар, дугуй гэх мэт)	8	Хамгаалаагүй булаг	9
Үртэс	9	Савласан ус	10
Бусад (бичих)	10	Зөөврийн усны үйлчилгээ	11
		Ус зөөврийн ердийн хөсөг	12
		Хурын ус	13
		Усны ил эх үүсвэр (гол, мөрөн, нуур, тойром, цөөрөм)	14
		Бусад (бичих)	15

НН. ӨРХИЙН АСУУЛГА

НН_14. Танай усны эх үүсвэр хаана байдаг вэ?

- | | | |
|----------------|---|---------|
| Өөрийн сууцанд | 1 | ⇒ НН_17 |
| Өөрийн хашаанд | 2 | ⇒ НН_17 |
| Өөр газарт | 3 | |

НН_15. Гэртээ ундны ус авч ирэхэд хэдэн минут зарцуулдаг вэ?

(ус авахаар яваад ирэх, дугаарлаж зогсох хугацааг оруулна)

- | | | | | |
|------------------------------|-----|---------|--|--|
| Минут | | | | |
| Өрхийн гишүүд усанд явдаггүй | 000 | ⇒ НН_17 | | |
| Мэдэхгүй | 998 | ⇒ НН_17 | | |

НН_16. Танайх ундны усаа хэр холоос авдаг вэ?

- | | |
|-------------------|---|
| 200 метр хүртэл | 1 |
| 200-1000 метр | 2 |
| 1000 метрээс дээш | 3 |

НН_17. Танай өрхийн сарын орлого хэд вэ (мянган төгрөгөөр)?

--	--	--	--

НН_18. Танай өрхөөс хамгийн ойр зайнд байршилтай дараах үйлчилгээний газрууд хэдэн километрийн зайтай вэ?

- Улсын цэцэрлэг
- Хувийн цэцэрлэг
- Улсын дунд сургууль
- Хувийн дунд сургууль
- Төрийн үйлчилгээний байгууллага
- Хувийн үйлчилгээний байгууллага
- Банк/бичил санхүүгийн байгууллага
- Эрүүл мэндийн байгууллага/эмнэлэг

KM		

Бусад (бичих)

--	--	--

НН_19. Танайх өөрийн өрхдөө мал/тэжээвэр амьтан малладаг уу?

- | | | |
|------|---|---------|
| Тийм | 1 | |
| Үгүй | 2 | ⇒ НН_21 |

НН_20. Танайх хэдэн малтай вэ /зөвхөн өөрийн өрхөд байгаа/?

- Үхэр/сарлаг
- Адуу
- үүнээс: Хурдан морь
- Тэмээ
- Хонь
- Ямаа
- Бусад (тахиа, шувуу, гахай, зөгий, цаа буга)

Тоо		

НН_21. Сүүлийн 12 сарын хугацаанд танай өрхийн орлого өссөн үү, буурсан уу?

- | | | |
|-------------|---|---------|
| Өссөн | 1 | ⇒ НН_24 |
| Буурсан | 2 | |
| Өөрчлөлтгүй | 3 | ⇒ НН_24 |

НН_22. Сүүлийн 12 сарын хугацаанд танай өрхийн орлого буурсан шалтгаан нь юу вэ?
(хамгийн гол гэсэн 3 хүртэлх шалтгааныг дугуйлах)

- | | |
|---|---|
| Үер | a |
| Ган | b |
| Ойн түймэр | c |
| Шуурга | d |
| Хөрсний нуралт | e |
| Гадны нөлөөтэй ургац хураалт буурсан (мал, шавьж гэх мэт) | f |
| Цар тахлаар өвдсөн | g |
| Эдийн засгийн хямралаас болж бизнес хаагдсан | h |
| Газрын тосны үнэ нэмэгдсэн | i |
| Нүүрсний үнэ буурсан | j |
| Үнийн инфляц (хэрэглээний үнийн өсөлт) | k |
| Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл байхгүй | l |
| Ажилгүй | m |
| Ковид-19 хязгаарлах арга хэмжээ | n |
| Өрхийн нэг буюу хэд хэдэн гишүүн өвдсөн | o |

Бусад (бичих) p

НН_23. Тухайн нөхцөл байдал [ШОК]-ыг даван туулахын тулд танай өрх ямар арга хэмжээ авсан бэ? (хамгийн гол гэсэн 3 хүртэлх шалтгааныг дугуйлах)

- | | |
|---|---|
| Хадгаламжаа хэрэглэж эхэлсэн | a |
| Хамаатан садан эсвэл найз нөхдөөсөө тусламж авсан | b |
| Засгийн газар/улсын тусламжийг авсан | c |
| Шашны болон төрийн бус байгууллагуудын тусламж авсан | d |
| Хүүхдээ гэрлүүлсэн | e |
| Хэрэглээний дадал зуршлаа өөрчилсөн (хямд үнэтэй хоол хүнс худалдан авах, өдрийн хоолны тоог багасгах, идэх хэмжээг багасгах гэх мэт) | f |
| Өрхийн ажил эрхэлж байгаа гишүүд нь нэмэлт ажил хийсэн | g |
| Өрхийн ажилгүй байсан насанд хүрсэн гишүүд ажилд орсон | h |
| Өрхийн 15 хүртэлх насны гишүүд ажиллаж эхэлсэн | i |
| Хүүхдээ сургуулиас нь гаргасан | j |
| Өрхийн 1, түүнээс дээш гишүүд дотоод шилжих хөдөлгөөнд орсон | k |
| Өрхийн нэг болон түүнээс дээш гишүүд бусад улс руу шилжсэн | l |
| Эрүүл мэнд, боловсролын зардлаа бууруулсан | m |
| Зээл авсан | n |
| Хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжөө худалдсан | o |
| Өрхийн удаан эдэлгээтэй барааг худалдсан | p |
| Газар/тавилга/орон сууцаа худалдсан | r |
| Хүнсний нөөцөө худалдсан | s |
| Мал, туслах аж ахуйн амьтнаа худалдсан | t |
| Загас барих/ан агнах үйл ажиллагаагаа нэмэгдүүлсэн | u |
| Хүүхдээ өөр өрхөд амьдруулахаар явуулсан | v |
| Шашин шүтлэг үйлдсэн | w |
| Хүнсний бүтээгдэхүүнийг улирлын бус үед тариалсан | x |

Бусад (бичих) y

Ямар нэг арга хэмжээ аваагүй z

НН. ӨРХИЙН АСУУЛГА

НН_24. Сүүлийн 12 сарын хугацаанд танай өрхийн хэн нэг гишүүн зээлтэй, зээл авсан, зээлээр эд зүйл худалдаж авсан уу? (*кредит картын хэрэглээ*)

Тийм

Үгүй

НН_25. Өрхийн гишүүний зээл авсан гол шалтгаан нь юу байсан бэ?

Өрхийн зайлшгүй шаардлагатай зардлыг хангахаар

Тээврийн хэрэгсэл худалдаж авахаар

Өрхийн хэрэгцээнд орон сууц худалдаж авах, барих, өргөтгөх, засахаар

Өрхийн гишүүдийн эрүүл мэндтэй холбоотой зардлыг төлөхөөр

Өрхийн гишүүдийн боловсролтой холбоотой зардлыг төлөхөөр

Нийтээр тэмдэглэх баярт өдрүүдийн зардлыг хангахаар

Бизнес явуулах, өргөжүүлэхээр

Өмнөх зээлээ төлөхөөр

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлдээ/үйл ажиллагаандаа зориулаад

Мал, туслах аж ахуйн амьтан худалдан авахаар

Бусад (*бичих*)

НН_26. Тухайн зээлээ хаанаас авсан бэ? (*хамгийн их хэмжээтэй зээлийнх*)

Засгийн газар

Банк/зээлийн карт

Бичил зээл/банк бус санхүүгийн байгууллага

Ажил олгогч/албан байгууллага

Бараа, түүхий эдийн тоног төхөөрөмж нийлүүлэгч

Хамаатан садан, найз нөхөд

Ломбард

Мөнгө зээлдүүлэгч хувь хүн

Бусад (*бичих*)

НН_27. Авсан зээлээсээ ямар нэг хэмжээгээр буцаан төлөлт хийсэн үү?

Тийм

Үгүй

НН_28. Зээлийн буцаан төлөлтийг хэрхэн төлсөн бэ? (*олон сонголттой байж болно*)

Бэлэн мөнгөөр

Зарим хөрөнгөө зараад

Өрхийн насанд хүрсэн гишүүд зээлүүлэгчид зориулж хөдөлмөр эрхэлсэн

Өрхийн насанд хүрээгүй гишүүд зээлүүлэгчид зориулж хөдөлмөр эрхэлсэн

Биет хэлбэрээр (*мал, амьтан, машин, тоног төхөөрөмж гэх мэт*)

Бусад (*бичих*)

Мэдэхгүй

НН_29. Сүүлийн 12 сарын хугацаанд танай гэр бүлийн хэн нэг гишүүн дараах зүйлээс орлого олсон уу? (*олон сонголттой байж болно*)

Нийгмийн даатгалын сан:

Өндөр насны тэтгэвэр

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр

Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тэтгэмж

Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны

Жирэмсний болон амаржсаны тэтгэмж

Ажилгүйдлийн тэтгэмж

Нийгмийн халамжийн сан:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр

Өндөр настны, тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийн, өрх толгойлсон эх/эцгийн тэтгэвэр болон 16 насанд хүрсэн одой иргэний тэтгэвэр

Жирэмсэн болон 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж

Асаргааны тэтгэмж (*ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэний болон хүнд нөхцөлд байгаа хүүхдийн асаргааны тэтгэмж*)

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ (*хүнсний талон*)

Хүүхдийн мөнгө

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх амралт, рашаан сувиллын хөнгөлөлт

3 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмж

Эхийн алдар 1, 2 дугаар зэргийн одонгийн мөнгөн тусламж

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан:

Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг (*Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд 100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй 5.0 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг*)

Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг (*Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд үзүүлж буй дэмжлэг*)

Түр ажлын байраар хангаж, орлогоор дэмжих (*Нийтийг хамарсан ажил, бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ*)

Жижиг зээл (*Арилжааны банкаар дамжуулан иргэнд 10.0 хүртэл сая төгрөг, аж ахуйн нэгж, нөхөрлөл, хоршоонд 20.0 хүртэл сая төгрөгийн зээл*)

Хөдөлмөр эрхлэлтийн сургалт (*Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэл дээрх сургалт, аж ахуй эрхлэлтийн сургалт*)

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ (*Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ, ажилд зуучлах үйлчилгээ*)

Бусад (*бичих*)

БҮЛЭГ I: ӨРХИЙН АМ БҮЛИЙН БАЙДАЛ

СУДЛААЧ: Энэ бүлгийн асуултуудыг тухайн өрхөд амьдарч байгаа бүх гишүүдээс (насанд хүрээсэд болон хүүхэд) асууна. Тухайн өрхөөс өрхийн бүх гишүүдийнхээ талаар мэддэг, бүрэн мэдээлэл өгч чадах насанд хүрсэн гишүүнээс мэдээлэл авах хэрэгтэй.

Хувийн дугаар	Өрхийн гишүүний нэр СУДЛААЧ: Өрхийн гишүүн гэж хамтын төсөвтэй, хамтран амьдарч, хооллож байгаа нэг болон нэг хэсэг бүлэг хүмүүсийг хэлнэ. Эдгээр хүмүүс нь хоорондоо төрөл садан ба төрөл садан биш ч байж болох бөгөөд 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур оршин суугаа хүнийг хамруулахгүй.	Өрхийн гишүүдийн регистрийн дугаар СУДЛААЧ: 2 үсэг, 10 оронтой тоо байх.	СУДЛААЧ: Өрхийн ам бүлийн байдлын талаар мэдээлэл өгч байгаа гишүүний хувийн дугаарыг бичих. Доорх кодыг уншиж өгнө үү.	(Нэр) нь өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай вэ? Доорх кодыг уншиж өгнө үү.	(Нэр)-ний хүйс? Эрэгтэй - 1 Эмэгтэй - 2	(Нэр)-ний төрсөн он, сар, өдөр? СУДЛААЧ: Хэрэв төрсөн оныг мэдэхгүй бол код 9997, сар болон өдрийг мэдэхгүй бол 97-оор кодлох.			СУДЛААЧ: Төрснийг эсвэл иргэний үнэмлэхийг харахыг хүснэ үү. Үзсэн - 1 Үзээгүй - 2	(Нэр)-ний нас? (Бүтэн жилээр) Хэрэв 15-аас доош настай бол => DEM_12	(Нэр)-ний гэрлэлтийн байдал? Доорх кодыг уншиж өгнө үү. Хэрэв код 1 эсвэл 4-оос 7 => DEM_12	(Нэр)-ний нөхөр/эхнэр/ хамтрагч нь энэ өрхөд хамт амьдардаг уу? Тийм - 1 Үгүй - 2=>DEM_12	Хэн (Нэр)-ний нөхөр/эхнэр/ хамтрагч вэ? (Тухайн хүний нөхөр/эхнэр/ хамтрагчийн хувийн дугаарыг бичих)
						Он	Сар	Өдөр					
A	DEM_01	DEM_02	DEM_03	DEM_04	DEM_05	DEM_06a	DEM_06b	DEM_06c	DEM_07	DEM_08	DEM_09	DEM_10	DEM_11
1													
2													
3													
4													
5													
6													
7													
8													
9													
10													

КОД

Өрхийн тэргүүлэгчийн хамаарал (DEM_04-р багана)	1=Өрхийн тэргүүлэгч, 2=Нөхөр/эхнэр, 3=Хүү/Охин, 4=Эцэг/эх, 5=Ах/эгч/дүү, 6=Хадам эцэг/эх, 7=Хүргэн/бэр, 8=Өвөг эцэг/эмэг эх, 9=Ач/зээ, 10=Ач дүү/зээ дүү, 11=Хүргэн ах/эгч/дүү, 12=Бусад төрөл төрөгсөд, 13=Үйлчлэгч, асрагч, туслах ажилтан, 14=Бусад (бичих)
Гэрлэлтийн байдал (DEM_09-р багана)	1=Огт гэрлээгүй, 2=Гэрлэсэн-батлуулсан, 3=Гэрлэсэн-батлуулаагүй, 4=Тусгаарласан, 5=Цуцалсан, 6=Бэлэвсэн

БҮЛЭГ I: ӨРХИЙН АМ БҮЛИЙН БАЙДАЛ

Өрхөд амьдарч байгаа 0-17 насны бүх гишүүдээс асууна.					Өрхөд амьдарч байгаа бүх гишүүдээс асууна.		Өрхөд амьдарч байгаа 5, түүнээс дээш насны гишүүдээс асууна. Хэрэв хариулагч 5-аас доош настай бол судалгааг дуусгана.					
Хувийн дугаар	(Нэр)-ний төрсөн аав нь энэ өрхөд хамт амьдардаг уу?	(Нэр)-ний төрсөн аав хэн бэ?	(Нэр)-ний төрсөн ээж нь энэ өрхөд хамт амьдардаг уу?	(Нэр)-ний төрсөн ээж хэн бэ?	(Нэр) нь өнгөрсөн 12 сарын хугацаанд хэдэн сар энэ өрхөд амьдарч байна вэ?	(Нэр)-ний энэ өрхөд амьдрах болсон гол шалтгаан юу вэ?	(Дараагийн асуултууд нь (Нэр)-ний эрүүл мэндийн асуудлаас болж одоо дурдах үйл ажиллагаануудыг хийхэд хүндрэлтэй байж магадгүй юм)					
	Тийм-1 Үгүй-2 =>DEM_14	(Тухайн хүний төрсөн аавынх нь хувийн дугаарыг бичнэ үү)	Тийм-1 Үгүй-2 =>DEM_16	(Тухайн хүний төрсөн ээжийнх нь хувийн дугаарыг бичнэ үү)	Сарыг бичих Хэрэв 12 сар =>DEM_18	Доорх кодыг уншиж өгнө үү.	Танд дараах эрүүл мэндийн бэрхшээлүүд байдаг уу? (Асуултуудыг уншиж өгнө, доорх кодыг ашиглана уу)					
							(Нэр)-нд юм харахад хүндрэлтэй байдаг уу? (Харааны шил зүүсэн ч)	(Нэр)-нд юм сонсоход хүндрэлтэй байдаг уу? (Сонсголын аппарат зүүсэн ч)	(Нэр)-нд тэгш гадаргуу дээр алхах, налуу гадаргуу дээр өгсөх, уруудахад хүндрэлтэй байдаг уу?	(Нэр)-нд аливаа зүйлийг санах, анхаарлаа төвлөрүүлэхэд хүндрэлтэй байдаг уу?	(Нэр)-нд бие даан усанд орох, хувцсаа өмсөх зэргээр өөрийгөө арчлахад хүндрэлтэй байдаг уу?	(Нэр)-нд бусадтай ярилцахад ямар нэгэн хүндрэл гардаг уу?
A	DEM_12	DEM_13	DEM_14	DEM_15	DEM_16	DEM_17	DEM_18	DEM_19	DEM_20	DEM_21	DEM_22	DEM_23
1												
2												
3												
4												
5												
6												
7												
8												
9												
10												

КОД

Өрхөд ирж амьдрах болсон гол шалтгаан (DEM_17-р багана)	1=Шинээр мэндэлсэн, 2=Гэрлэсэн/гэр бүлтэй болсон, 3=Ажиллах боломжийг бүрдүүлэхээр, 4=Сургууль, дамжаанд сурахаар, 5=Өрхөд тусламж үзүүлэхээр, 6=Өнчирсөн, 7=Эрүүл мэндийн тусламж авахаар/эмчлүүлэхээр, 8=Аав, ээж, гэр бүл, үр хүүхэдтэйгээ хамт байхаар, 9=Бусдыг асран хамгаалахаар, 10=Хүрээлэн буй орчны буюу байгалийн гамшгийн улмаас (зуд, ган, үер гэх мэт), 11=Амьдрах нөхцөлөө сайжруулахаар/орон байраа өөрчлөхөөр, 12=Цэргийн албанаас халагдсан, 13=Өөр газраас буцаж ирсэн, 14=Бусад (бичих), 97=Мэдэхгүй, 98=Татгалзсан
Эрүүл мэндийн бэрхшээлийн түвшин (DEM_18-23-р багана)	1=Үгүй, хүндрэл байхгүй, 2=Тийм, бага зэргийн хүндрэлтэй, 3=Тийм, их хүндрэлтэй, 4=Тийм, огт чаддаггүй, 97=Мэдэхгүй, 98=Татгалзсан

БҮЛЭГ I: ӨРХИЙН АМ БҮЛИЙН БАЙДАЛ

СУДЛААЧ: Энэ бүлгийн асуултуудыг тухайн өрхөд амьдарч байгаа 5, түүнээс дээш насны гишүүдээс асууна.

Хувийн дугаар	(Нэр) нь энэ баг, хороондоо төрснөөсөө хойш амьдарч байна уу, шилжиж ирсэн үү? Хэрэв код=1 => EDU_01	(Нэр) нь одоогийн оршин суугаа газартаа ирэхээсээ өмнө хамгийн сүүлд хаана амьдарч байсан бэ? <i>Доорх кодыг уншиж өгнө үү.</i>	(Нэр) нь одоогийн оршин суугаа газартаа хэдэн онд ирсэн бэ? Хэрэв мэдэхгүй бол код 9997	(Нэр) нь одоогийн оршин суугаа газартаа нүүж ирэх болсон гол шалтгаан нь юу байсан бэ? <i>Доорх кодыг уншиж өгнө үү.</i>
A	DEM_24	DEM_25	DEM_26	DEM_27
1				
2				
3				
4				
5				
6				
7				
8				
9				
10				

КОД

Шилжиж ирсэн эсэх (DEM_24-р багана)	1=Төрснөөсөө хойш, 2=Өөр газар байнга амьдарч байгаад буцаж ирсэн, 3=Өөр газраас шилжиж ирсэн
Өмнө нь оршин сууж байсан газар (DEM_25-р багана)	1=Энэ аймаг, дүүргийнхээ өөр сум, хороонд, 2=Бусад аймаг, дүүрэгт, 3=Бусад улсад, 4=Бусад (бичих)
Шилжих болсон үндсэн шалтаан (DEM_27-р багана)	1=Өөр газар ажилд орсон, 2=Ажил өөр газарт шилжсэн, 3=Цалин хөлстэй ажил хайхаар, 4=Бизнес эрхлэх боломжийг хайхаар, 5=Сургууль, дамжаанд сурахаар, 6=Сургууль, дамжаа төгссөн, 7=Аав, ээж, гэр бүл, үр хүүхдээ дагаад, 8=Гэрлэсэн, 9=Бусдыг асран хамгаалахаар, 10=Хүрээлэн буй орчны буюу байгалийн гамшгийн улмаас (зуд, ган, үер гэх мэт), 11=Амьдрах нөхцөлөө сайжруулахаар/орон байраа өөрчлөхөөр, 12=Тэтгэвэрт гарсан, 13=Эмчлүүлэхээр, 14=Цэргийн албанаас халагдсан, 15=Гэртээ буцаж ирсэн, 16=Бусад (бичих), 97=Мэдэхгүй, 98=Татгалзсан

БҮЛЭГ II: БОЛОВСРОЛЫН БАЙДАЛ

СУДЛААЧ: Энэ бүлгийн асуултуудыг тухайн өрхөд амьдарч байгаа 5, түүнээс дээш насны гишүүдээс асууна.

Хувийн дугаар	(Нэр) - ний эзэмшсэн боловсролын дээд түвшнийг хэлнэ үү? (Одоо суралцаж байгаа ангиас доогуур байх)	(Нэр) нь сургуульд сурч байсан уу?	(Нэр) нь цэцэрлэгт хамрагдаж байсан уу?	(Нэр) нь ямар шалтгаанаар сургууль, цэцэрлэгт огт хамрагдаагүй вэ?	(Нэр) нь сургуульд анх орохдоо хэдэн настай байсан бэ?	(Нэр) нь цэцэрлэгт анх орохдоо хэдэн настай байсан бэ?	(Нэр) нь өмнөх хичээлийн жилд сургууль, цэцэрлэг, бага насны хүүхдийн боловсролын хөтөлбөрт хамрагдсан уу?	(Нэр) нь өмнөх хичээлийн жилд боловсролын ямар түвшний ангид хамрагдсан бэ?	(Нэр)-ний өмнөх хичээлийн жилд сургууль, цэцэрлэг, бага насны хүүхдийн боловсролын хөтөлбөрт хамрагдаагүй гол шалтгаан юу байсан бэ?	(Нэр) нь энэ хичээлийн жилд сургууль, цэцэрлэг, бага насны хүүхдийн боловсролын хөтөлбөрт хамрагдаж байна уу?	(Нэр) нь энэ хичээлийн жилд ямар түвшний ангид хамрагдаж байна вэ?	(Нэр)-ний энэ хичээлийн жилд сургуульд хамрагдаагүй гол шалтгаан юу вэ?
	Хэрэв код 6-10 => EDU_17a	Тийм - 1 => EDU_04a Үгүй - 2	Тийм - 1 => EDU_04b Үгүй - 2	Бүх хариулт нь => FOW_01	Бүх хариулт нь => EDU_05	Бүтэн нэсвэр бичих.	Тийм - 1 Үгүй - 2 => EDU_07	Бүх хариулт нь => EDU_08	Хэрэв код=16 => EDU_17a	Тийм - 1 Үгүй - 2 => EDU_10	Бүх хариулт нь => EDU_11	Бүх хариулт нь => EDU_17a
A	EDU_01	EDU_02a	EDU_02b	EDU_03	EDU_04a	EDU_04b	EDU_05	EDU_06	EDU_07	EDU_08	EDU_09	EDU_10
1												
2												
3												
4												
5												
6												
7												
8												
9												
10												

КОД

Боловсролын түвшин (EDU_01-р багана)	1=Боловсролгүй, 2=Бага, 3=Суурь, 4=Бүрэн дунд, 5=Техникийн болон мэргэжлийн, 6=Тусгай мэргэжлийн дунд, 7=Дипломын дээд, 8=Бакалаврын дээд, 9=Магистр, 10=Доктор, 97=Мэдэхгүй
Огт суралцаагүй гол шалтгаан (EDU_03-р багана)	1=Нас бага/хүрээгүй, 2= Сургууль, цэцэрлэг байхгүй/хол байсан, 3=Хичээлийн хэрэглэл, хувцас зэрэг зардлыг гаргаж чадаагүй, 4=Сургалтын төлбөр байгаагүй (төлж чадаагүй, хэт өндөр төлбөртэй), 5=Дотуур байр байхгүй, хүрэлцээгүй, 6=Сургуульд сурах сонирхол байгаагүй, 7=Сургуулийн орчин таалагдаагүй, 8=Боловсрол эзэмших нь чухал гэж боддоггүй, 9=Ажлын туршлага суух, ажил хийж сурахаар, 10=Мал маллахаар, 11=Цалин хөлстэй ажиллахаар, 12=Өрхийн бизнес/фермерийн аж ахуйд хувь нэмэр оруулахаар, 13=Гэрийн ажилд туслалцахаар, 14=Гэр бүл нь сургуульд сурахыг зөвшөөрөөгүй, 15=Өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй, 16=Шилжих хөдөлгөөний улмаас, 17=Бусад (бичих), 97=Мэдэхгүй, 98=Татгалзсан
Анги, түвшин (EDU_06, EDU_09-р багана)	1=Сургуулийн өмнөх боловсрол, 2=Бага анги, 3=Дунд анги, 4=Ахлах анги, 6=Техникийн болон мэргэжлийн сургууль, 7=Дээд боловсролын сургууль, 8=Шашны сургууль, 97=Мэдэхгүй
Сураагүй үндсэн шалтгаан (EDU_07, EDU_10-р багана)	1=Сургууль байхгүй/хол байсан, 2=Хичээлийн хэрэглэл, хувцас зэрэг зардлыг гаргаж чадаагүй, 3=Сургалтын төлбөр байгаагүй (төлж чадаагүй, хэт өндөр төлбөртэй), 4=Дотуур байр байхгүй, хүрэлцээгүй, 5=Сургуульд сурах сонирхол байгаагүй, 6=Сургуулийн орчин таалагдаагүй, 7=Боловсрол эзэмших нь чухал гэж боддоггүй, 8=Ажлын туршлагатай болохоор, 9=Мал маллахаар, 10=Цалин хөлстэй ажиллахаар, 11=Өрхийн бизнес/фермерийн аж ахуйд хувь нэмэр оруулахаар, 12=Гэрийн ажилд туслалцахаар, 13=Гэр бүл нь сургуульд сурахыг зөвшөөрөөгүй, 14=Өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй, 15=Шилжих хөдөлгөөний улмаас, 16=Сургуулиа төгссөн, 17=Бусад (бичих), 97=Мэдэхгүй, 98=Татгалзсан

БҮЛЭГ II: БОЛОВСРОЛЫН БАЙДАЛ

СУДЛААЧ: Энэ бүлгийн асуултуудыг тухайн өрхөд амьдарч байгаа 5, түүнээс дээш насны гишүүдээс асууна.

Хувийн дугаар	(Нэр) нь сүүлийн 7 хоногт сургуульд хамрагдсан уу?	(Нэр) нь сүүлийн 7 хоногт хэдэн өдөр сургуульд явсан бэ?	(Нэр) нь сүүлийн 7 хоногт өдөрт хэдэн цагаар хичээллэсэн бэ?	(Нэр) нь сүүлийн 7 хоногт яагаад сургуульд яваагүй вэ?	(Нэр) нь аль нэг түвшний ангид давтан суралцаж байсан уу?	(Нэр) нь хэдэн удаа давтан суралцаж байсан бэ?	(Нэр)-ний эзэмшсэн үндсэн мэргэжил юу вэ? (Диплом, сертификат, гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэх зэрэг баримт бичгийг үндэслэнэ. Хэрэв олон мэргэжил эзэмшсэн бол мэргэжлийн түвшний хувьд хамгийн өндөр байгааг нь сонгоно)	
	Тийм - 1 Үгүй - 2 => EDU_14	Өдрийн тоог бичих.	Бүх хариулт нь => EDU_17a	Доорх кодыг уншиж өгнө үү.	Тийм=1 Үгүй=2 => EDU_17a	Давтамжийн тоог бичих.	Эзэмшсэн мэргэжил	Код
A	EDU_11	EDU_12	EDU_13	EDU_14	EDU_15	EDU_16	EDU_17a	EDU_17b
1								
2								
3								
4								
5								
6								
7								
8								
9								
10								

КОД

Өнгөрсөн долоо хоногт сургуульд сураагүйн гол шалтгаан (EDU_14-р багана)	1=Амралтын өдөр (нийтээр тэмдэглэх баярт өдөр); 2=Өвчтэй; 3=Ажил хийсэн; 4=Сургуульд сурах нь ирээдүйд шаардлагагүй; 5=Сургууль байхгүй/хол байсан; 6=Сургалтын төлбөрөө төлж чадаагүй; 7=Сургуульд явах сонирхолгүй; 8=Нас бага/хүрээгүй; 9=Хичээл эхлээгүй байна; 10=Бусад (бичих)

БҮЛЭГ III: АЖЛЫН ХЭЛБЭРҮҮД

СУДЛААЧ: Энэ бүлгийн асуултуудыг тухайн өрхөд амьдарч байгаа 5-17 насны гишүүдээс асууна. Мэдээллийг өрхийн 5-11 насны гишүүдээс авахдаа тухайн хариулагчийн талаар бүрэн мэдээлэл өгч чадах насанд хүрсэн өрхийн гишүүнээс асуух ёстой. Хэрэв судалгааны хугацаанд мэдээлэл өгөх боломжгүй бол өрхийн гишүүдтэй цэг тахирон дахин өрхөд очих хэрэгтэй.

Хөдөлмөр эрхлэлт															
